

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-17
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	18-78
1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025 оны 09 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	18-78

***Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
10 дугаар сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл***

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Б.Найдалаа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 34 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Болормаа, М.Нарантуяа-Нара;

Томилолттой: Ж.Галбадрах, М.Энхцэцэг;

Тасалсан: Т.Мөнхсайхан, Б.Түвшин.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025 оны 09 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Р.Ринчинбазар, А.Энхбат, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэнджав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Энхболд, Нийцлийн аудитын газрын захирал Б.Баттуяа, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа, Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга Н.Нарангэрэл, Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга Б.Алимаа, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Энхтөр, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга Ю.Рэнцэнханд, Хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Амгаланзаяа, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга Д.Гэрэл, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газрын дарга З.Бауыржан, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, мөн яамны Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Наранпүрэв, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Нармандах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Х.Энэбиш, Б.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, А.Болортуяа, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төсвийн төслийн танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар, А.Ариунзаяа, О.Саранчулуун, Г.Хосбаяр, М.Ганхүлэг, Б.Бейсен, Ш.Бямбасүрэн, С.Эрдэнэбат, Н.Алтаншагай, О.Батнайрамдал, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Боловсролын сайд П.Наранбаяр, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Н.Хүрэлбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

Б.Найдалаа: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, С.Эрдэнэбат нарын гаргасан, Багш, эмч нарын цалин, тэтгэврээс бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад туссан урсгал зардлыг 0.8 хувиар буюу 170.0 тэрбум төгрөгөөр бууруулж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг тэтгэх мөнгөн

тэтгэмжийн 397.5 мянган төгрөг, Асаргааны тэтгэмжийн 302.5 мянган төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэврийн 397.5 мянган төгрөгийг тус тус 24 хувиар нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 7
Бүгд: 24
70.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 хүртэлх сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмжийн зардалд тусгагдсан санхүүжилтийг 178,089.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, уг эх үүсвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын бараа, үйлчилгээний бусад зардлыг 178,089.9 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.9 дэх “Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас” гэснийг “Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон нийгмийн даатгалын шимтгэл” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Саналтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 19
Бүгд: 24
20.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Г.Ганбаатар нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400730 төслийн кодтой “Төв халх” дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/, хэрэгжих хугацаа 2011-2028 он, төсөвт өртөг 32,990.1 сая төгрөг, санхүүжих дүн 8,671.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 543.7 сая төгрөгөөр бууруулж, УТ2403100365 төслийн кодтой Спорт заалны барилга /Дундговь, Луус сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,366.3 сая төгрөг, санхүүжих дүн 255.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 543.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 9
Бүгд: 24
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808718 төслийн кодтой, Багануур тойрог авто зам, 14.4 км /Багануур хот/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 43,321.9 сая төгрөг, санхүүжих дүн 14,656.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, төрийн өмчит Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуульд шаардлагатай урсгал зардлыг санхүүжүүлэхээр Боловсролын сайдын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 8
Бүгд: 24
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Зулпхар, Д.Рэгдэл, С.Эрдэнэбат нарын гаргасан, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардлыг 3,199.0 сая төгрөгөөр бууруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц дахь Урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг 3,199.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 6
Бүгд: 24
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601300966 төслийн кодтой Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 67,119.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн үйлдвэрлэлийн түүхий эд, материалын зардалд 1,100.0 сая төгрөг, мөн төслийн 2 дугаар хавсралтад “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн автомашин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700.0 сая сая төгрөг”, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн өргөтгөлийн барилгын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 200.0 сая төгрөг”, гэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 4
Бүгд: 24
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой “Спорт заалны барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг

3,103.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,396.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 8
Бүгд: 24
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400239 төслийн кодтой “Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 11
Бүгд: 24
54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400052 төслийн кодтой “Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 14
Бүгд: 24
41.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу нарын гаргасан, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багц дахь “Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал”-ын зардал болох 11,830.2 сая төгрөгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн үг хэлж, саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

12.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808719 төслийн кодтой Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2028 онд, төсөвт өртөг 319,998.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын багцын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 10
Бүгд: 24
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагайгийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808512 төслийн кодтой “Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 59.2 км /Хойд бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 101,370.6 сая төгрөг, санхүүжих дүн 19,710.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 11
Бүгд: 24
54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808289 төслийн кодтой “Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62,56 км /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 117,450.0 сая төгрөг, санхүүжих дүн 25,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 13
Бүгд: 24
45.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

15.Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2403100360 төслийн кодтой “Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/” хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,101.0 сая төгрөг, санхүүжих дүн 577.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, “Заяын Гэгээний хүрээ хийдийн цогцолборын” дээврийн засвар /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 577.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808162 төслийн кодтой Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км, /Баруун бүс/ хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 150,926.6 сая төгрөг, санхүүжих дүн 23,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой “Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179,7 км, /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, 186,000.6 сая төгрөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12
Бүгд: 23
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

18.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5 км, /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 15
Бүгд: 23

34.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

19.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 13

Бүгд: 23

43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

20.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102800331 төслийн кодтой “Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 185,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 45,921.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 13

Бүгд: 23

43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

21.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 106,868.4 сая төгрөг, санхүүжих дүн 20,036.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 14

Бүгд: 23

39.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

22.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808473 төслийн кодтой “Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 км /Говийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-

2027 он, төсөвт өртөг 157,864.8 сая төгрөг, санхүүжих дүн 40,460.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 12
Бүгд: 23
47.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

23.Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/” хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих ажлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлыг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/” хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, Тусгай олимпын урсгал зардлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 7
Бүгд: 23
69.6 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200517 төслийн кодтой “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/” хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 14,609.5 сая төгрөг” санхүүжих дүн 3,652.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих зардлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын

сайдын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 14
Бүгд: 23
39.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

26.Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/” хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,500.0 сая төгрөгөөр бууруулж, Үндэсний шигшээ багийн бус спортын төрлийг дэмжих зардлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлыг 2,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5км, /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 436.0 сая төгрөгөөр бууруулж, УТ201500780 төслийн кодтой “Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/”, хэрэгжих хугацаа 2021-2026 он, төсөвт өртөг 4,020.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,272.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 436.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн Зам, тээврийн сайдын авто замын төслийн код УТ2402804410 кодтой төсөл арга хэмжээнээс “1.707,9 сая” төгрөгийг бууруулж, “Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумд баригдаж байгаа Соёлын төвийн барилгын УТ201500781 кодтой төсвийг 1,707.9 сая” төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 6
Бүгд: 23
73.9 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Монгол Улсын төсвийн 2026 оны төсвийн төслийн Соёлын сайдын төсөл арга хэмжээний УТ2603400522, УТ2603400239, УТ2603400052 кодтой төсөл арга хэмжээнээс 4.385,9 сая төгрөгийг бууруулж, Хүүхдийн төв, Номын сан, Хүүхэлдэйн театрын барилгын төсвийг 3.415,3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 9
Бүгд: 23
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн гаргасан, Боловсрол, Эрүүл мэндийн сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын цалингаас бусад урсгал зардлыг 196.0 тэрбум төгрөгөөр бууруулж 6-12 дугаар ангийн нийт сурагчдын үдийн хоол хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 196.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэгийн гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын Эдийн засаг, хөгжлийн яамны УТ2606600085 дугаартай төсөл, арга хэмжээний төсвийг 4,800.0 сая төгрөгөөр бууруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын шууд буюу хөтөлбөр арга хэмжээний урсгал зардлыг 4,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 8
Бүгд: 23
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсений гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601502049 төслийн кодтой “Ерөнхий боловсролын сургуулиудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 26,146.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “3 дугаар сургуулийн биеийн тамирын заалны барилга /Баян-Өлгий, Цэнгэл сум/, төсөвт өртөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Боловсролын яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Тамираа тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 21
Бүгд: 23
8.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен саналаа тайлбарлаж, үг хэлэв.

33.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалт байхгүй байгаа нь уг хуулийн 1.1. дэх заалттай зөрчилдөж байна. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалт байхгүй байгаа тул “Төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалтыг Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагаас давсан орлогоор санхүүжүүлсэн тооцоог тусгах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 23
Бүгд: 23
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

34.Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тооцоололд төсвийн алдагдал 1,380,000.0 сая төгрөг гэж гаргахдаа Нийгмийн даатгалын сангийн зарлагаас давсан орлого 1,281,362.7 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагаас давсан орлого 354,002.6 сая төгрөгийг ашигласан нь Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн 12.2-т “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд нь шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн тул тооцооллоос хасаж, төсвийн алдагдлыг 3,015,365.4 сая төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 2.9 хувьтай тэнцүүлж бодитоор тооцох, өөрчлөх зүйл нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт 2026 оноос шинээр эхэлж, мөн ондоо санхүүжигдэх УТ2601501785, УТ2601501777, УТ2601501767-оос бусад төслүүдийн нийт 1,065,011.7 сая төгрөгийн санхүүжилтийг 2027 он руу хойшлуулж, төсвийн зарлагыг бууруулан алдагдлыг 1,950,353.7 сая төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 1,9 хувьд хүргэх” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0
Татгалзсан: 23
Бүгд: 23
0.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

35.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, ҮОМШӨ-ний даатгалын санд төвлөрсөн 423,978.7 сая төгрөгийн орлогоос Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж дүгнэлт хийх, хууль, эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах, олон нийтэд сурталчлах зардалд 3,500.0 сая төгрөг, Үйлдвэрлэлийн

осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, эрт тэтгэвэрт гарсан ахмадуудыг асрах, сувилах, сэргээн засах зардалд 5,000.0 сая төгрөг, Олон нийтийн хяналтыг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зардалд 1,500.0 сая төгрөгийг тус тус тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат үг хэлж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Энхтөр тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын 3 их наяд 267,3 тэрбум төгрөгийн зардлаас Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчин, боловсролын салбараас бусад салбарт 2026 онд шинээр баригдах барилга байгууламжийн хөрөнгө оруулалтыг тэвчих, бууруулах дүн нь 301.666,7. сая төгрөг, 2026 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төрөөс Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого 431.181,3 сая төгрөгийг 301.066,7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 732.848,3 сая төгрөг болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 10
Бүгд: 23
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Зам, тээврийн сайдын УТ2502808085 “Аргалант-Баянцогт сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 26.7 км, төмөрбетон гүүр, 36 у/м /Төвийн бүс/ төслөөс 15.166,3 сая төгрөгийг бууруулаад, 60 хувиар Боловсролын салбарын урсгал зардлыг, 20 хувиар Эрүүл мэндийн салбарын урсгал зардлыг, ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлд 20 хувиар нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат саналаа тайлбарлаж, үг хэлэв.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 11
Бүгд: 23
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Найдалаа дээрх саналын томьёолол нь дутуу уншигдсан тул дээрх дэмжигдсэн санал хураалтыг хүчингүйд тооцох горимын санал гаргав.

Б.Найдалаа: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 11

Бүгд: 23

52.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцов.

Б.Найдалаа: 38.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, 1.3ам, тээврийн сайдын УТ2502808085 “Аргалант-Баянцогт сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 26.7 км, төмөрбетон гүүр, 36км /Төвийн бүс/, эндээс 15,166.3 сая төгрөг”;

2.3ам, тээврийн сайдын УТ2502808211 “Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, 15,000.0 сая төгрөг”;

3.3ам, тээврийн сайдын УТ2502808162 “Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/, эндээс 23,000.0 сая төгрөг”;

4.3ам, тээврийн сайдын УТ2402804339 “Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/, эндээс 42,904.6 сая төгрөг”;

5.3ам, тээврийн сайдын УТ2402804371 “Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, эндээс 30,499.8 сая төгрөг”;

6.3ам, тээврийн сайдын УТ2402804360 “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто зам, эндээс 38,576.2 сая төгрөг”;

7.3ам, тээврийн сайдын УТ2402804406 “Ховд-Дөргөн сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 40.7 км /Ховд, Дөргөн сум/, эндээс 25,159.7 сая төгрөг”;

8.3ам, тээврийн сайдын УТ2402804412 “Хэрлэн голын төмөрбетон гүүр 265 км, хатуу хучилттай авто зам 14.2 км /Хэнтий, Хэрлэн сум/, эндээс 21,065.4 сая төгрөг”;

9.3ам, тээврийн сайдын УТ2102800632 “Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км /Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум/, 80,101.1 сая төгрөг”;

10.3ам, тээврийн сайдын УТ2602800805 “Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, эндээс 20,036.4 сая төгрөг”;

11.3ам, тээврийн сайдын УТ2602800636 “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, эндээс 25,635.0 сая төгрөг”;

12.3ам, тээврийн сайдын УТ2602800907 “Хэрлэн голын төмөрбетон гүүр, 217.6 км /Дорнод, Хэрлэн сум/ эндээс 6,053.6 сая төгрөг”;

13.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ 3,778.9 сая төгрөг”;

14.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын УТ2403100364 төслийн кодтой “Өвлийн спортын ордны барилга /Дархан-Уул, Дархан сум/, эндээс 6,423.7 сая төгрөг”;

15.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын УТ2102900758 “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил, эндээс 6,130.0 сая төгрөг”;

16.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын УТ2601900178 “Үр тариа хадгалах агуулах /Увс/, эндээс 4,050.0 сая төгрөг”;

17.Эрүүл мэндийн сайдын УТ2602001067 “Хавдар судлалын Үндэсний төв-II” цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, 2026 онд санхүүжих мөнгөн дүнгийн 50 хувийг бууруулах, энэ нь 20,261.0 сая төгрөг”;

18.Эрүүл мэндийн сайдын УТ2602001014 “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Үндэсний оношилгоо, эмчилгээний төв барилгын их засвар /Улаанбаатар/, эндээс 2026 онд санхүүжих мөнгөн дүнгийн 50 хувийг бууруулах, энэ нь 2,191.5 сая төгрөг” хасаж, ахмад настнуудын тэтгэвэр тэтгэмж, боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэх зорилгоор дээр дурдсан хөрөнгө оруулалтын зардлаас хэмнэсэн 411.069,3 сая төгрөгийг нэмэлтээр тусган Боловсролын салбарт 60 хувь буюу 246.641,8 сая төгрөг, Эрүүл мэндийн салбарт 20 хувь буюу 82.213,8 сая төгрөг, Ахмад настнуудын тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлд 82,213,8 сая төгрөгийг тус тус нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 13

Бүгд: 23

43.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

39.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 10,3 хувиар нэмэгдүүлэхээр төсөвт тооцож ирүүлэх гэсэн санал нь хуулийн шаардлага хангаагүй учраас санал хураалт явуулаагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 54 минут үргэлжилж, 30 гишүүнээс 24 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.НАЙДАЛАА

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 34 минут.

**ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Найдалаа: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэндийг хүргэе. Байнгын хорооны хуралдаанаа эхэлье.

Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүдийг танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай, Жадамбаагийн Баясгалан, Амгалангийн Ганбаатар, Цэндсүрэнгийн Мөнхтуяа, Мягмардашийн Сарнай, Лутаагийн Энхнасан, Аюушийн Ариунзаяа, Буланы Бейсен, Мөнгөнцогийн Ганхүлэг, Бадрахын Найдалаа, Ганбатын Хосбаяр, Доржзовдын Энхтуяа, Дамбын Батлут, Дуламын Бум-Очир, Сархадын Зулпхар, Отгоны Саранчулуун, Бадарчийн Хэрлэн, Сүхбаатарын Эрдэнэбат нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хуралдааны ирц хүрсэн учраас Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны өнөөдрийн хурал эхэлснийг мэдэгдье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хэлэлцэх асуудал.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Н.Учрал Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, П.Наранбаяр Боловсролын сайд, Т.Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Ч.Ундром Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Ж.Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, С.Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, И.Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Батжаргал Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Л.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Очирбат Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Даваацэрэн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Р.Ринчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, А.Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Эдийн засаг, хөгжлийн яамнаас Л.Энх-Амгалан Макро эдийн

засгийн бодлогын газрын дарга, Б.Анар Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга, Т.Баясгалан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Б.Мөнхтөр Шинжлэх ухаан, технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, П.Чандмань Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Б.Урьболд Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Ж.Гэрэлбат Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Сангийн яамнаас М.Санжаадорж Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Г.Золбоо Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Б.Тэлмүүн Татварын бодлогын газрын дарга, С.Тулга Санхүүгийн бодлогын газрын дарга, Ж.Дэлгэржаргал Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, З.Энхболд Хууль, эрх зүйн газрын дарга, Л.Ичинноров Төсвийн орлогын хэлтсийн дарга, П.Бат-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Л.Гантогтох Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Ш.Бат-Эрдэнэ Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Б.Ганзориг Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Ч.Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Р.Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга, Э.Номин-Эрдэнэ Төсвийн зарлагын хэлтсийн шинжээч, Б.Дэнсмаа Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, П.Энхманлай Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, П.Очиртогтох Төсвийн зарлагын хэлтсийн мэргэжилтэн, Э.Цолмон Төсвийн орлогын хэлтсийн мэргэжилтэн, Р.Хангал Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын мэргэжилтэн, О.Гантулга Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн мэргэжилтэн, Үндэсний аудитын газраас З.Цэдэнжав Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч, Д.Энхболд Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Б.Баттуяа Нийцлийн аудитын газрын захирал, Боловсролын яамнаас С.Должинсүрэн Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Э.Адьяасүрэн Санхүүгийн хэлтсийн дарга, Х.Тамираа Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Н.Нарангэрэл Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга, М.Цогзолмаа Ерөнхий боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга, Т.Ням-Очир Боловсролын Ерөнхий газрын дарга, П.Оюунаа Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал, О.Сийлэгмаа Боловсролын зээлийн сангийн дарга, Б.Бадамжав Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Б.Баярсайхан Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга, Д.Гэрэл Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын дарга, З.Бауыржан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга, Б.Алимаа Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын дарга, Б.Баасандолгор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Ерөнхий нягтлан бодогч, Ю.Отгонбилэг Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Ж.Энхтөр Төсөв, санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Б.Батжаргал Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, В.Рэнцэнханд Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Ц.Ганцэцэг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас Э.Билигт Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Г.Батхуяг, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Д.Жаргалсайхан, Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Батдорж Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, В.Батчимэг Аялал жуулчлалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, Ж.Отгонбат Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Амгаланзаяа, Хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, М.Одгэрэл Санхүү, хөрөнгө оруулалтын газрын ахлах шинжээч, Эрүүл мэндийн яамнаас Д.Отгонбаатар Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газрын дарга, Б.Туяа Стратеги төлөвлөлтийн газрын даргын албыг түр орлон гүйцэтгэгч, М.Наранпүрэв Эмнэлгийн тусламжийн

бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Б.Цэцэгсайхан Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга, Н.Эрдэнэбаяр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга, Н.Хүрэлбаатар Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, А.Батбаяр зөвлөх, Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газраас М.Нармандах Эрүүл мэндийн даатгалын Ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Б.Батхуяг Бодлого, төлөвлөлтийн газрын төсвийн мэргэжилтэн, Б.Ууганбаяр Тусламж, үйлчилгээний багц зохицуулалтын хэлтсийн дарга, Шадар сайдын ажлын албанаас Б.Батбямба Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга С.Батбаатар Стандарт, хэмжилзүйн газрын дарга, Д.Эрдэнэбаяр Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн гүйцэтгэх захирал, Х.Сүхбаатар Шадар сайдын ажлын албаны референт, С.Ням-Эрдэнэ Үндэсний итгэмжлэлийн төвийн дарга, Д.Мөнхжаргал Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнгийн Бүс орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцууллаа.

Одоо Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Учрал танилцуулна. Учрал сайдын микрофоныг нээе.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж, 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Ирэх 2026 оны төсвийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа. Төсвийн төсөлд туссан тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах онцлох арга хэмжээнүүдийг дурдъя.

1 дүгээрт. Төсвийн урсгал зардлын хувьд:

Удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын нийт орон тооны тэлэлтийг хязгаарлахын зэрэгцээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн байгууллагын үр ашиггүй зардлыг бууруулж, хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулахаар;

Улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдсэнтэй холбоотойгоор Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасан улсын төсвөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн шимтгэлд зориулж 79 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэхээр;

Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилгоор 2023-2028 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулж тус салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор хөнгөлөлттэй зээл олгохоор Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн. Тогтоолын хүрээнд 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа

эрхлэгчдэд зориулж 6 хувийн хүүтэй 6 хүртэлх жилийн хугацаатай нийт 267 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 2026 онд олгуулахаар тооцож, зээлийн хүүгийн дэмжлэгт зориулж 23,1 тэрбум төгрөгийг төрөөс хариуцан төлөхөөр төсвийн төсөлд тусгалаа.

2 дугаарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэл, салбарын яамны түвшинд үе шаттайгаар төлөвлөлөө.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14,4 их наяд төгрөгийн санхүүжих дүн бүхий 1712 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж 579 төсөл арга хэмжээнд нийт 3 их наяд 267,3 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Нийт хөрөнгө оруулалтын 67 хувь буюу 2 их наяд 181,9 тэрбум төгрөг нь үргэлжлэн хэрэгжих бол 33 хувь буюу 1 их наяд 85,5 тэрбум төгрөг нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна.

Энэ нь 2022-2023 онд батлагдсан төслийн тоотой харьцуулахад 2 дахин буурсан үзүүлэлт бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх, шалгуур үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илтгэж байна.

Түүнчлэн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтад хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарт бүсчилсэн хөгжлийн болон хувийн хэвшлийг дэмжиж бизнесийн орчныг сайжруулах хүрээнд эрчим хүч, суурь дэд бүтцийн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын салбарт нийгмийн хэв журам аюулгүй байдлыг хангах үүднээс батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг түлхүү төлөвлөлөө.

Тухайлбал тус Байнгын хороонд хамаарах салбар буюу Боловсролын сайдын багцад 448 тэрбум төгрөг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад 37,4 тэрбум төгрөг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын багцад 169,4 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн сайдын багцад 211,6 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгалаа.

Мөн олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд НҮБ-ын Коп-17 хурлыг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилт болон гадаад зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгийг төсвийн төсөлд мөн тусгалаа.

3 дугаарт Үндэсний баялгийн сангийн хувьд газрын хэвлий дэх байгалийн баялгийг ирээдүй хойч үеийн иргэдэд тэгш шударга хүртээх зорилгоор АМНАТ-өөс Ирээдүйн өв санд хуримтлал бүрдүүлж ирсэн бөгөөд түүхэндээ анх удаа хөрөнгө оруулалтын өгөөжөөр тус сангийн хөрөнгийг арвижуулаад байна.

Мөн Хуримтлалын сангийн дансанд 754,4 тэрбум төгрөг төвлөрч, баялгийн санд нийт 5 их наяд 509 тэрбум төгрөг хуримтлагдлаа. Ирэх онд АМНАТ-ийн орлогоос 2 их наяд 186,9 тэрбум төгрөгийг Ирээдүй өв санд уул уурхайн салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн 34 хүртэлх хувьд ноогдох ноогдол ашгийн орлогоос 372,9 тэрбум төгрөгийн орлогыг хуримтлалын санд төвлөрүүлэхээр Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн төсөлд тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31,6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь зарлага 29,6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 2 хувь байж төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн дүүрэн хангаж байна.

Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Б.Найдалаа: Учрал сайдад баярлалаа. Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагчаас болон төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулттай гишүүн байна уу. Нэрсээ өгье. Бямбасүрэн гишүүнээр тасаллаа. Ганбаатар гишүүнээс эхэлье. Ганбаатар гишүүний микрофоныг нээгээрэй.

А.Ганбаатар: Учрал сайдыг гарахаас нь өмнө асуултаа асуучихъя. Яах вэ, одоо төсөв яриад байдаг бид нар тэгэхээр 1 талаасаа урд талаасаа аваад хойд талаа нөхөөд байгаа байхгүй юу. Эсвэл хойноос аваад урд талаа нөхөөд байгаа ийм л байдал ажиглагдаад байгаа юм. Тухайлбал зарчмын зөрүүтэй санал гаргахад чинь 1 талаас нь аваад л нөгөө тал руу нь хийх гэж байгаа юм. Тэгээд хоорондоо баахан маргаан болоод л хэдэн төгрөг дотроо, төсөв дотор эргээд байхгүй юу.

Тэгэхээр Учрал сайдаас асуух гээд байгаа нь энэ байна л даа. Төсвийн орлого дээр ямар зарчмын бодлого явуулах юм бэ. Та Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа бол хийгээд байсан. Одоо энэ чинь явж байгаа юу. Эрдэнэс Монгол, Эрчис Монгол энэ компаниудаас чинь ашигтай ажиллаж байгаа нь бол маш цөөхөн байна шүү дээ. Эрдэнэс Тавантолгой, Эрдэнэт өөр би сайн мэдэхгүй байна. Тэгэхээр эд нарыгаа хувьчлах паблик лимитэд олон нийтийн хяналтын доор ийм мэтийн компаниуд болгох юм уу. Эндээсээ орлого мөнгө олъя гэж бодож байгаа юм уу. Уул уурхайн нөгөө стратегийн орд гэж нэрлээд байгаа энэ бас зохисгүй байна гэсэн стратегийн бүтээгдэхүүнүүдээ нэрлээд, энэ бүтээгдэхүүнээ үнэлэх, энэ компаниудтай гэрээ хийж, тэр хувь хувьцаагаа больё гэхэд АМНАТ-аар яаж орлуулах орлогуудаа яаж төлөвлөж байгаа юм бэ. Ингээд энэ чинь энэ жилийнх биш гээд дараа дараа жилдээ орлогын эх үүсвэрүүдийг нэмэхгүй бол манай улсын төсөв чинь ерөөсөө л 30-аад их наяддаа л эргэсээр байгаад л дуусна. Багш нарын цалин пүнлүү ярин. Эрүүл мэндийн асуудал ярина. Ингээд л эргэлтдээ дуусаад л хоорондоо бие биеэсээ нөхсөн ийм л төсөв жилээс жилд яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр шууд холбоогүй ч гэсэн энэ асуултыг танаас гарахаас ч өмнө тавиадахъя гэж байгаа юм.

Дараа нь би нөгөө зарчмын зөрүүтэй санал тавьчихсан байгаа учраас тэр дэс дарааны дагуу орох байх тийм үү Найдалаа дарга аа. Баярлалаа.

Б.Найдалаа: Учрал сайд хариулна.

Н.Учрал: Ер нь ирэх жилийн төсвийг өргөн мэдүүлэхдээ төсөвт төрийн оролцоог бууруулъя гэж бодлого барьсан. Тэгээд энэ төрийн оролцоог бууруулаад хувийн хэвшилд яг ямар орон зай бий болгож байгаа юм, бодитой яг юу хийж байгаа юм бэ гэж л гишүүд асуугаад байгаа шүү дээ, Тэгэхээр 1 зүйл байгаа юм. Ерөөсөө энэ ДНБ тэнцвэржүүлсэн орлогын харьцаа 2024 онд бүүр 37 хувь хүрчихсэн байсан байхгүй юу. Энэ чинь юу вэ гэхээр татвараар бүрдүүлж байгаа орлого тэгж их өндөр

байхаар хувийн хэвшилд орон зай байхгүй болчхож байгаа юм. Тийм учраас ерөөсөө л энэ харьцааг буулгахын төлөө л ажиллах ёстой. Тийм учраас 2026 оны төсөв бол өөрөө энэ орлого ДНБ-ий харьцаа бол 30,6 руу буурна. Ингээд 2028 онд бол 28 хувь хүртэл бууруулах гэхээр энэ орон зайг яагаад гаргаад аваад байна вэ гэхээр энэ татварын шинэчлэл хийх гээд байгаа юм. Тэгэхийн тулд энэ орон зайг бий болгох ёстой. Энэ бол нэг дэвшил. Тэгээд энд бол ийм орон зай бий болж байна. Хувийн хэвшлийг дэмжсэн ийм бодлого хэрэгжүүлж байгаагийн гол шалтгаан нөгөө шүүмжлээд байгаа 1,4 их наядын алдагдал чинь эх үүсвэр нь тодорхой алдагдал гээд байхаар үүний цаана дандаа худалдан авалт нөгөө хувийн хэвшилд ажлын байр нэмэгдүүлэх бодлого түүний цаана явж байдаг. Тэрнээс биш ерөөсөө энэ алдагдалгүй төсөв гээд ингээд оруулж ирээд бид нар нөгөө худлаа ингээд GDP-ээ өсгөөд, нөгөө хэдэн бүтээгдэхүүнийхээ үнийг хоосон тавиад ингээд оруулж ирээд нөгөө цалингаа нэмчихлээ гээд хэлбэл ирэх жил дахиад л тодотгол руугаа явчихна шүү дээ. Тийм учраас үнэн байя гэж маш их хичээсэн. Энэ макро тоонууд дээрээ.

Тэгээд дээрээс нь энэ хувийн хэвшилд байгаа ажлын байрыг хадгалахыг зорьсон. Ерөөсөө л хувийн хэвшил. Тэгэхээр тэр жилийн төлөвлөгөөнд байгаа 126 төслийн 50 төсөл бол дандаа төр, хувийн хэвшлийн түншлэл. Тэгээд нөгөө үе, шатуудыг бууруулаад, аймгуудад энэ эрхийг өгөөд эхлэхээр хувийн хэвшилд ажлын байр нэмэгдэнэ, хадгална. Ингээд хувийн хэвшил өрсөлдөх бололцоо нэмэгдэнэ гэхээр зэрэгцүүлээд татварын шинэчлэл, Татварын багц хууль зэрэг явах ёстой. Дээрээс нь нөгөө Эдийн засгийн эрх чөлөөний хууль, Хөрөнгө оруулалтын хууль, нөгөө зөвшөөрөл мэдэгдлийн хууль байхгүй юу. Мөчлөг сөрнө гэдэг бол энэ орон зайг бий болгоно. Дээрээс нь хувийн хэвшил дээр ирээд байгаа ачааг багасгах хэрэгтэй. Энэ бодит өөрчлөлт байх ёстой. Тэгэхээр эдийн засгийн эрх чөлөөний хууль дагасан 120 хуулийн өөрчлөлт legalinfo дээр явж байна. Дээрээс нь энэ Татварын багц хууль зэрэг ороод, явж чадвал хувийн хэвшилд нэг ийм орон зай бий болно. Тэгж байж бид нар бол цаашаа урагшлах юм байна. Тэрнээс биш сургууль дээр гэхэд л жилийн төлөвлөгөөнд 108 сургууль хэрэгтэй гэж байгаа шүү дээ. Тэгээд хамгийн эхний асуут 10 мянган багш байна уу л гэж асууж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг яаж шийдэх үү. Хувийн хэвшлээрээ л шийднэ. Тэрнээс төр бүгдийг хийж чадахгүй гэдэг энэ бодлоосоо бүгд л салж байж л цаашаа явахгүй ер нь бол их хүнд л боллоо. Тэгээд тийм л бодлого барьсан.

Б.Найдалаа: Тодруулъя.

А.Ганбаатар: Учрал сайдын тайлбарлаж байгааг ойлгож байгаа. Тэр мөчлөг сөрсөн бодлого эд нар гээд. Зүйтэй байх л даа. Тэгэхдээ Ардчилсан намын үед 4/10-ын татварын бодлого гээд маш их дэмжлэг авсан. Хувийн хэвшлээ дэмжсэн ийм бодлого явж байсан. Тэгээд Татварын багц хууль хэзээ орох вэ. Тэр хүртэл таны ярьж байгаа энэ арга хэмжээнүүд энэ ондоо больё, дараа жил яг бодитой хэрэгжих тэр 126 төслийн чинь яг хэд нь бодитой хэрэгжих юм бэ. Нөгөө 14 мега төсөл гэдэг шиг 2, 3 нь яваад ингээд алга болчих юм биш биз дээ. Гол нь нөгөө таны яриад байгаа эдийн засаг дахь төрийн монополийг жоохон багасгая гээд байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ Эрдэнэс Монголоосоо хэдийг нь хасах юм. Эрчис Монголоосоо хэдийг нь хасах юм. Хасъя гэдэг нь миний хэлээд байгаа нь таг алга болгоё гэсэн үг биш. Хувийн хэвшил рүүгээ шилжүүлэх, эсвэл зах зээлд юу гэдэг юм тэр паблик лимитед маягаар гаргах эсвэл лист маягаар гаргах энэ бодлого чинь яг хэзээ хэрэгжиж эхлэх юм бэ л гэж асуугаад байгаа.

Б.Найдалаа: Учрал сайд.

Н.Учрал: Тэр төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, засаглал ил тод байдлыг сайжруулах хуулийг Оюун-Эрдэнийн засгийн газар өргөн барьчихсан байхгүй юу. Тэгээд ингээд байж байгаа. Нийтийн өмчийн хууль өргөн барьчихсан. Их Хурал дээр ингээд гацчихсан байгаа. Энэ хуулийг гарчихвал паблик институт нийтийн үйлчилгээний байгууллага төсвөөс санхүүжнэ. Нөгөөдөх нь зөвхөн төрийн өмчит компани. Төрийн өмчит компанийн шалгуур бол ашигтай ажиллах ёстой. Үгүй бол татан буугдах л ёстой. Тэгээд сая нэгтгэж нийлүүлэх, өөрчлөх, зохион байгуулах дээр 20 компани дээр ийм ажил хийгдлээ. Гэхдээ энэ бол ийм механик л ажиллагаа байхгүй юу. Тэгэхээр хуулиа гаргаад Засгийн газар төрийн өмчит компанийн дээр баримтлах чиглэлийг оруулж ирэхдээ нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөн зохион байгуулах, нээлттэй болгох, нөгөө листэд компани болгохоор оруулж ирээд листэд болгох гэхээр олон улсын аудит оруулах зардлыг нь засаг шийд гэдэг эрхийг өгчихвөл бүрэн боломж байгаа. Тэгэхээр хуулиа гаргачихъя. Тэгээд араас нь явбал ингээд цогц шинэчлэл болно л гэж байна.

Б.Найдалаа: Татварын багц хууль хэзээ барих вэ гэж асуусан.

Н.Учрал: Татварын багц хууль ингээд л бас энэ Legalinfo, D-Parliament дээр тавигдчихсан ингээд явж байгаа. Тэгээд одоо ер нь бэлэн байгаа шүү дээ. Тэгээд л ингээд татварынхаа шинэчлэлийг хийе. Хөрөнгө оруулалтын хуулиа ч гаргая. Зөвшөөрөл мэдэгдлийн хуулиа ч явуулъя. Эдийн засгийн эрх чөлөөний хуулиа ч баталъя. Тэгээд ер нь ингээд хурдан хугацаанд шийдээд явъя. Бид бол бэлэн. Төрийн өмчит компанийн хууль ч гэсэн Их Хурал батлаад л өгөхөд бид Засгийн газраас төрөөс төрийн өмчит компани дээр баримтлах чиглэлийг оруулж ирнэ. Ингээд хэд хэдэн компани листэд болгохын зорилго бол компанийг засаглалыг сайжруулах, дээрээс нь хөрөнгө босгох зорилготой шүү дээ. Тэгэхээр хэрвээ тэр хөрөнгө босгохгүй гэвэл тэрийг зүгээр татан буулгачих нь дээр байхгүй юу. Тэгээд дуудлага худалдаагаар зарах л ёстой. Гол нь дуудлага худалдаагаар зараад тэрийг яг хүний хөгжил дэмжсэн салбарт зарцуулж байгаагаа тодорхой Их Хуралд оруулж ирээд шийдүүлчихье л гээд байгаа юм.

Б.Найдалаа: Ганбаатар гишүүн тодруулга болсон уу. Баярлалаа. Энхнасан гишүүн асуулт асууна.

Л.Энхнасан: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Учрал сайд явахаас өмнө бас нэг юм тодруулаад асуучихъя.

Та түрүүн төрийн албан хаагч нөгөө өнгөрсөн жил 14 мянган хүн цомхотгосон гэж байгаа. Энэ яг бодитоор яг яам яаман дээр яг хэдэн хүн цомхотгосон бэ. Яг бодит яг хүнээрээ. Сайд нар бас энэ дээр хариулаад өгнө үү.

2 дугаарт энэ Коп-17 гээд олон улсын арга хэмжээ болох гэж байгаа. Үүний ач холбогдлыг бол ойлгож байгаа. Тэгэхдээ энд зарцуулагдаж байгаа энэ 400 тэрбум төгрөгийг яг ямар ямар ажилд зарцуулагдах гэж байгаа вэ. Ялангуяа хэрвээ АСЕМ-ын хурлыг хийхэд байсан энэ барилга байгууламжийг ашиглаж болохгүй юм уу. Тэгээд энэ хурлыг хийж байгаад хөрөнгө оруулалт татна гэж байгаа. Тэр бэлтгэл ажил ямар шатад байгаа вэ. Ер нь хэлэлцээр хийх тэр хүмүүсээ бэлдэж байгаа юу. Ямар төрлийн хэлэлцээрүүдийг хийхээр ер нь яригдаж байгаа вэ.

Мөн хүүхдийн хамгааллын талаар Баярсайхан даргаас асуумаар байна. Бид нар бол өнгөрсөн Нийгмийн бодлогын байнгын хороо дээр төсвөө нэмж, хүүхдийн хамгааллын төсвийг бол нэлээн нэмсэн. Тэгэхэд энэ удаагийн төсөв дээр 122 сая

төгрөг хүүхдийн хамгаалалт дээр зөвхөн төлөвлөчихсөн байна гэж би харсан. Энэ яагаад бид нар хүүхдэдээ анхаарах ёстой байхад энэ төсөв яагаад ийм багассан байна вэ. Энэ энэ дээр бас хариулт өгнө үү.

Б.Найдалаа: Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ төрийн албаны реформ хийх хүрээнд бас өмнөх Засгийн газрын үед бид бол энэ Төрийн албаны багц хуулийн шинэчлэлийн хуулийг бол дуусгачихсан. Тэр хуулийн концепц бол яг энэ сивил сервис, паблик сервис гэж ангилаад, одоо энэ хуулиар цалин хөлс асуудлыг нь шийддэг биш, нийтдээ цогцоор нь шийддэг болъё гээд ерөнхийдөө хуулийг нь бичээд бэлэн болсон.

Тэгээд шинэ Засгийн газрын үед бол бас дахиад л ажиллаж байх шиг байна. Саяын тэр цомхотгол хийсэн гэдэг 14 мянга бол би үнэн тоо гэж бодож байгаа. Бид нарт ирүүлсэн л мэдээлэл. Энэ Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг Их Хурлаар батлахад тэр жилийн төлөвлөгөө дээр 9 хувийг цомхотгоно гэдэг ийм үг оруулчихсан юм байна лээ. Ийм зорилт Их Хурлаар батлахад. Тэгээд тэр жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 9 хувийн цомхотголыг хийх үүргийг Занданшатарын Засгийн газар хүлээчихсэн байхгүй юу. Тэгээд 9 хувийг яг ингээд хэмнэх гээд эхлэхээр бид нар юу гэж ярьсан бэ гэхээр төсвийн ерөнхийлөн захирагч салбар дотроо заримаас нь 20 хувь хасна уу, заримаас нь огт хэмнэлт хийхгүй байна уу. Гэхдээ салбар бүхэлдээ 9 хувийн хэмнэлт хийх ёстой л гэдэг ийм л зарчмыг барихад энэ 9 хувь гэдэг үгийг далайлгаад, зарим анхан шатын төрийн байгууллагууд дээр хүн хэлмэгдүүлэх үйл явдал гарсан. Ийм байж болохгүй шүү дээ. Төсвийн ерөнхийлөн захирагч нарт Ерөнхий сайд тодорхой үүрэг өгсөн байхгүй юу. Та нар 9 хувиа салбар дотроо шийдэх ёстой шүү. Зарим газраа хүн нэмэх шаардлага бас байж болно шүү дээ. Орлого олдог салбаруудаар. Жишээ нь гааль дээр гэхэд зарим боомт дээр хүн хүч хэрэгтэй байна шүү дээ. Зарим нь 10 цаг, 24 цаг ажиллах хэрэг гарч байна. Зарим газар бүр 20 хувь ч хэмнэх боломжтой. Тэгэхээр энийг төсвийн ерөнхийлөн захирагч өөрөө шийд гэхэд 9 хувь гэдэг үгийг ашиглаад, анхан шатанд бараг нөгөө өөрийнх нь үгэнд ордоггүй хэдэн хүн хөөж явуулж, асуудал үүсгэсэн тохиолдлууд гарсан. Энэ гомдлуудыг бол бид нар хүлээж авсан. Тэгээд жилийн төлөвлөгөө нэгэнт батлагдчихсан бол үүнийг хэрэгжүүлэх үүргийг Засгийн газар хүлээдэг. Тэгэхдээ чиг үүргийн шинжилгээ хийж байж хэмнэлт хийдэг болохоос биш ингэж зүгээр тайрч хаяж зүгээр болохгүй. Тийм бид нар энийг төсвийн ерөнхийлөн захирч нарт тухайлан үүрэг өгсөн. Та нар дотооддоо энийгээ шийд гэдэг. Тэгэхээр энэ үүрэг бол тодорхой байгаа шүү. Тэрнээс биш шат шатын байгууллагад 9 хувь гэдэг юм байхгүй.

Коп бол өмнөх Засгийн газрын үед Бат-Эрдэнэ сайдыг байхад энэ Коп-17 зохион байгуулах үүргийг манай Засгийн газар авсан. Энэ бол том нэр хүндийн хэрэг. Дэлхийн удирдагч нар эх оронд маань чуулах гэж байна. Тэгэхээр энэ бол цаанаа бас аялал жуулчлалын салбарт бас эдийн засгийн эргэлтэд оруулах ийм нөхцөл бололцоог бас бүрэн дүүрэн нээж өгч байгаа ийм л том арга хэмжээ.../минут дуусав/

Б.Найдалаа: Энхнасан гишүүн тодруулж асуух юм уу. Учрал сайдад минут.

Н.Учрал: Тийм учраас бол бид нар нэг их тийм том барилга байгууламж барих тийм төсөв мөнгө бол байхгүй. Одоо энд суусан төсөв мөнгө бол зүгээр ийм түр байшин барих л ийм л зориулалттай л гэж тооцож байгаа. Тэгээд яах вэ, энэ ажлууд бол нийслэл дээр хийгдэнэ. Бид нар бол энэ барилга байгууламж үйл

ажиллагаануудыг нийслэл рүү шилжүүлээд ингээд ажиллана л гэдэг ийм төлөвлөгөөтэй байгаа. Тэгээд тэр нийслэл дээр баригдаж байгаа тэр байшин барилгаа түр зуурын байшин барилгыг буцаад ашиглах, иргэн ашиглах зориулалттай байна гэдгийг нийслэлийнхэн бид нарт ийм мэдээлэл өгсөн. Би бол 2 сарын өмнө Авазад яг энэ Копийн арга хэмжээнд оролцсон. Тэгэхээр энэ бол үнэхээр өндөр ач холбогдол өгөхгүй бол энэ бол ийм улс орны нэр хүндийн асуудал болно. Тийм учраас үүнд бүгдээрээ л идэвхтэй оролцож байж энэ Коп-ыг бол өндөр түвшинд зохион байгуулж, эргээд манай улсад хэрэгтэй, эдийн засагт, аялал жуулчлалд хэрэгцээтэй гэдэг.../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Энхнасан гишүүн тодруулах уу, үгүй юу. Баярсайхан даргын микрофоныг нээе. Энэ чинь яаж байна дугаар байна уу. Аубакир сайд хариулъя. Аубакир сайдын микрофоныг нээе.

Т.Аубакир: Баярлалаа. Өдрийн мэнд хүргэе бүгдэд нь. 2026 оны улсын төсөвт 20,1 тэрбум төгрөг төсөвлөсөн байгаа. Таны асууж байгаа тэр 100 гаруй сая төгрөг бол Хүүхэд, гэр бүлийн газруудад байгаа гэр бүлийн хөтөлбөрийн зардал. Ирэх жил Монгол Улс маань хүүхдийн төлөө 20,1 тэрбум төгрөг зарцуулах нь гэж ойлгож болно.

Б.Найдалаа: Хариулт болсон уу. Энхнасан гишүүн тодруулж асууя.

Л.Энхнасан: Түрүүн нөгөө яамд яамдаараа яг 9 хувийг цомхотгоно гэж байна шүү дээ. Тэр дээр тодорхой бодлого байна уу.

Б.Найдалаа: Энийг Учрал сайд хариулсан. Та бас хариулчих юм уу. Яам болгон дээр хариулчихъя. Яг хэдэн яаж цомхотгож байгаа гээд товчхон. Аубакир сайд.

Т.Аубакир: Манай яам дээр нийт 9 хувь 541 орон тооны асуудал яригдаж байгаа. Бид нар мэдээж хэрэг сая яг Учрал сайдын хэлж байгаатай адилхан яг эд ажлаа хийгээд явж байгаа ажлын байран дээрээ илүүтэй санаачилгатай ажилладаг гэх юм уу даа эдгээрийгээ цомхотгохоосоо илүү бид нар бас сул орон тоонууд байсан. Тэрийгээ ашигласан. Сул орон тоо гэдэг маань тэтгэвэрт гараад явчихсан, нэг бол сонгон шалгаруулалт зарлаад, хүн ирдэггүй гэдэг ч юм уу. Эдгээрийгээ бид нар ашиглаад, үлдсэн дээрээ ч гэсэн бид нар бодлого барьж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй, жишээлбэл өрх толгойлсон эмэгтэй, эрэгтэй, хүнд өвчтэй, асаргаанд байгаа гэх зэрэг хүмүүсээ бид нар бол ерөөсөө халахгүй явж байгаа. Нэгэнт ийм шийдвэр гарчихсан учраас 9 хувьдаа тулгаад эхлээд бид нар тэтгэврийн насанд болчихсон хүмүүсээ мэдэгдлийг нь өгөөд байдаг ч юм уу гэх зэргээр зохицуулаад яг хуулийн хүрээнд зохицуулаад явж байгаа. Хамгийн гол чухал бодлого бол аймгуудад ч гэсэн хэлэхэд саяын өрх толгойлсон эмэгтэй, эрэгтэйтэй, хүнд өвчтэй ийм тохиолдлууд зөндөө гарч байгаа шүү дээ аймаг дээр.

Б.Найдалаа: Баярлалаа Чинбүрэн сайд.

Ж.Чинбүрэн: Эрүүл мэндийн салбарт бол ойролцоогоор 820 ТҮМ ангиллын ажилд цомхотгогдсон. Ер нь тэгэхдээ цомхотголыг хийхдээ эрүүл мэндийн салбарын яг эмчилгээ, үйлчилгээнд оролцож байгаа эмнэлгийн ажилчдыг бол цомхотгохгүйгээр гэсэн заалт орсон учраас ийм 820 орчим цомхотгол хийгдсэн.

Н.Найдалаа: Наранбаяр сайд товчхон хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Энэ эмч, багшаас бусад мэргэжил гэж байгаа. Өөрөөр хэлбэл эмч, багшийг бол цомхотголд оруулж болохгүй гэж анхнаасаа гарсан. Тэгээд манай энэ салбарт 92 мянган хүн байхад 43 мянга нь бол багш бус мэргэжлийн хүмүүс байгаа. Эндээс ингээд тооцоод үзэхээр 4 мянган ажлын байрыг цомхотгох шаардлага гарсан. Үүнээс бол хүүхдийн тоо өсөж байна. Тэгээд бас энэ багшийн дутал их байгаа ийм үед бас бид шуу хасах боломжгүй байгаад байгаа. Тэгээд 4 мянгаас 2 мянга нь бол угаасаа нөхөгдөөгүй байсан. Энэ дээр нь хүн авахгүй, цаашаагаа ажлын байрыг бууруулахгүй чиглэлээр зардлаа нэмэхгүй чиглэлээр сайдад олгогдсон болон салбарынхаа энэ урсгал зардлынхаа хэмжээнд хэтрүүлэхгүйгээр ажлын байр хадгалах ийм бодлого барьж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Ариунзаяа гишүүн асуулт асууна.

А.Ариунзаяа: Сайн байна уу Учрал сайд аа. Харин тийм. Ер нь бол манай намын журмын нөхөд маань тааралдахлаараа мэндлэхгүй өнгөрөөд байх юм. Маш сонин. Энэ чинь ядаж хүн ёсны харилцаатай байх ёстой. Тэгэхээр та хэд маань бас мэндэлдэг байх юмыг цаашаагаа хэлж өгөөрэй. Цаашаагаа хэлж өгөөрэй. Сингапурт бид хэд хамтдаа явж байсан. Та санаж байна уу. Бид Сингапурын хуримтлалын сангийн асуудлыг судалж байсан. Хамгийн гол асуудал нь эрүүл мэнд, боловсрол, орон сууцаас гадна тэтгэвэрт зарцуулдаг. Бид өнөөдөр яг ахмадын тэтгэврийн доод хэмжээг 1,5 сая төгрөг болгох хэрэгтэй гээд ярьж байна. Гэтэл нийгмийн даатгалын сан дангаараа үүнийг үүрч чадахгүй, угаасаа боломжгүй. Нийгмийн даатгалын санд шимтгэл төлж байгаа хүмүүсийн шимтгэл төлөлт дээр суурилж бид нар өнөөдөр олговор хийж байгаа. Төрөөс татаас олгож байгаа. Төрөөс олгож байгаа татаас нь бол төрөөс өгөх ёстой мөнгөө буюу 1995 оноос өмнө тэтгэвэртээ гарсан хүмүүс, цэрэг, цэргийн албаныхан гэх мэтчилэн төрөөс даах ёстой тэр мөнгийг л уг нь бол даах ёстой. Тэгэхээр яг одоо бол уг нь шинэчлэлээ үргэлжлүүлээд, суурь тэтгэврийн асуудал, нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн асуудал, хувийн нэмэлт тэтгэврийн асуудал, мөн дээрээс нь Баялгийн сангаас зөвхөн орон сууц, эрүүл мэнд, боловсрол гэлтгүй өндөр насны тэтгэврийн насандаа хүрэх юм бол түүнээсээ эргээд тэтгэвэр хэлбэрээр авах боломжийг бид нар нээж өгмөөр байгаа байхгүй юу. Суурь тэтгэврийг бол төсвөөс гаргадаг байх. Төсвөөс буюу улс төрчид төсвөөрөө зөвхөн суурь тэтгэврийн талаар л ярьдаг байх, хэрхэн яаж нэмэгдүүлж болох вэ. Төсөвт ямар орон зай байна вэ. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр тэтгэмжийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тухайн шимтгэлийн орлого болон тухайн байгаа чөлөөт үлдэгдлийг хэрхэн яаж арвижуулсан бэ гэдгээсээ хамаарч ноогдол ашиг хэлбэрээр нэмэгдүүлэх энэ орон зайгаа л дэлхийд байдаг энэ шилдэг шинжлэх ухаанч байдлаараа л явуулмаар байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр та Эдийн засаг, хөгжлийн сайд, Тэргүүн Шадар сайд энэ Баялгийн сангийн тухай хууль, Нийгмийн даатгалын асуудлууд дээр бол Аубакир сайд нэмж хариулна биз. Энэ хуулиудаа бас яаралтай оруулж ирээч ээ.

Аубакир сайд маань сайд болоод 130 хоног буюу 4 сар болчихсон. Таныг дөнгөж тангаргаа өргөж байхад би таныг Казахстаны хэлэлцээрийг маргааш оруулаад ир. Яаралтай оруулаад ир гэж хэлсэн дээ. Казахстаны хэлэлцээр байна шүү дээ хэлэлцэж эхлээд, зүгээр соёрхон батлах дээрээ уначихсан байхгүй юу. Хэлэлцэх эсэх дээр унаагүй. Хэлэлцэх эсэх дээр унах юм бол 1 жил оруулж ирдэггүй. Гэтэл бид нар процессыг нь явуулчхаад, улс төрийн шалтгааны улмаас ер нь бол шударга хэлэхэд унагаасан. Соёрхон баталж чадаагүй. Тэгэхээр шууд маргааш нь өргөн барих боломж байгаа. Оруулж ирээч ээ. Энэ чинь та бидний асуудал биш байхгүй юу. Энэ Казахстанд өнөөдөр ажиллаж байгаа тэтгэвэртээ гарч

байгаа хүмүүсийн бодит мөнгө. Яагаад гэвэл Казахстанд биднийг бодвол хуримтлалын тогтолцоо руугаа шилжчихсэн байхгүй юу даа. Аль хэзээний. Тэгэхээр энийг яагаад оруулж ирэхгүй байна вэ. Энийгээ шийдээч ээ.

Эрүүл мэндийн даатгалын сан. Эрүүл мэндийн даатгалын сангаас өнөөдөр нэг үйлчилгээт төлбөр билүү, нэг худалдан авалт. Үүгээрээ даль дамжуулаад цалин хөлс, урсгал зардлыг өгөөд байгаа. Өнөөдөр эмч, эмнэлгийн ажилтнуудын цалин хөлсний асуудлыг ярьж байгаа бол Эрүүл мэндийн даатгалын сангийн л ачааллыг ярина. Энэ хэн дээр ирэх вэ гэхээр Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгчдийн .../минут дуусав/

Б.Найдалаа: Хариулт авъя. Учрал сайд хариулна.

Н.Учрал: Ариунзаяа гишүүн бид 2 бол сайд байхаас нь авхуулаад энэ ажилд хамтарч ажилласан. Тэгээд энэ ажил бас 2020 оны 1 сард энэ тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлын хэсэг 2019 оны сүүлд билүү Занданшатар дарга Их Хурлын дарга байхдаа ажлын хэсэг байгуулаад, би энэ реформыг хариуцсан юм. Тэгээд тухайн үед бол үнэхээр энэ тэтгэвэртээ гарсан тэтгэврийн сангаа шинэчлэхгүй бол явахааргүй байна гэдгийг эдийн засгийн талаас нь харах шаардлага бид нарт зүй ёсоор тавигдаад байгаа юм. Бид нар өөрөө нийгмийн даатгалын санг ч тэр энийг тийм халамжийн сан шиг бодох биш, үүнийг санхүүгийн талаас нь харж байж цаашаа урагшлах ёстой. Энэ ч утгаараа энэ шинэчлэл хаанаас хийгдэх ёстой вэ гэхээр хувийн нэмэлт тэтгэврийн шинэчлэлээс хийгдэх ёстой гээд Ариунзаяа сайд байхдаа хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг Ариунзаяа сайд оруулж ирсэн. Тэгээд 4 хууль нь батлагдаж яваад, 1 хууль дээр нь Их Хурал дээр хэлэлцүүлэг дээр уначихдаг. Унаагүй хойшилчихдог. Тэгээд дахиж орж ирэхгүй удчихсан.

Хувийн нэмэлт тэтгэврийн шинэчлэл бол манай банкны зөвхөн нэг тулгуурт эдийн засагтай эдийн засгийг 2 тулгууртай болгох буюу санхүүгийн салбарыг босгож ирнэ. Тэгээд тухайн үед албан журмын ажил олгогчийн багадаа 2 хувь, ажилтны 2 хувийг санхүүгийн салбарт хувийн нэмэлт тэтгэврийн сангуудад хийх бололцоог ажилтанд олгоё гэсэн байхгүй юу. Ингэх юм бол жилд багадаа 400 тэрбум төгрөг зөвхөн санхүүгийн салбар луу хийх юм байна лээ. 2 хувиар бодоход. Ингээд явах юм бол энэ цаашдаа санхүүгийн салбараа ч дэмжинэ, 2-т нөгөө иргэд өөрөө 2 тэтгэврийн сангаас тэтгэвэр авах бололцоо нь нэмэгдэх ийм боломж байна гээд өнөөдөр энэ тэтгэврийн шинэчлэл нийгмийн даатгалын санг бид нар олон жил ярилаа. Гэхдээ нэг алхам хийгдсэн таны үед. Тэр 1 хувийг нь хуримтлал руу шилжүүлээд, алхам хийгдсэн. Энэ алхам урагшлах ёстой. Тэгээд энэ тоогоо ахиулах ёстой. Тэгээд Баялгийн сангийн хууль дээр хэрвээ энэ шинэчлэл бодитой бол яг тэр Сингапурт ажиллаж байхад бас яригдаж байсан шиг Баялгийн сангийн хуулийг бол бас дахиад шинэчлэх шаардлага бол зайлшгүй тулгарч байна шүү дээ. Яагаад гэхээр Хөгжлийн сан гээд ажилладаггүй сантай болчхоод байна шүү дээ. Хэзээ ч мөнгө хуримтлахгүй ийм сантай болчхоод байна. Тэгэхээр хөгжлийн сангаас төслүүдээ санхүүжүүлдэг болгох, дээрээс нь ер нь иргэдийг нөгөө цалинтай нь болоод амьдрал ахуйтай нь бүрэн ингээд уяа гэвэл зайлшгүй тэтгэвэртэй нь уяхаас өөр арга зам байхгүй байхгүй юу. Тийм учраас цаг нь бол мөн бол мөн. Хууль хийгдчихсэн. Шинэчлэл хийхэд бэлэн. Тэгээд л ер нь бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Олон жил ярьсан. Хоосон улс төржилтөө зогсоод л урагшилчихвал тэгээд л ажил бол бэлэн л байна. Тэгээд .../минут дуусав/

Б.Найдалаа: Аубакир сайд .

Т.Аубакир: Ариунзаяа гишүүнтэй санал нэг байгаа. Засгийн газар бол үндсэндээ төлөвлөж байгаа төлөвлөгөө, санал гэх юм бол 3 давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэхээр зорьж байгаа. Энэ дээр мэдээж хэрэг суурь тэтгэвэр зайлшгүй хэрэгтэй. Төлсөн шимтгэлээс хамаарсан тэтгэвэр, үүн дээр нэмээд хувийн нэмэгдэл тэтгэвэртэй болох болно. Ирээдүйд сая Учрал сайдын ярьж байгаа. Суурь тэтгэврийг бол улс, эх орнууд янз бүрээр бий болгодог. Япон улс жишээлэх юм бол 50 хувь нь улсаас суурь тэтгэврийг нь шууд автомат өгдөг гэдэг ч юм уу, зарим улсууд 100 хувь өгдөг гэдэг ч юм уу. Тийм ээ. Хамгийн чухал зүйл бол олон эх үүсвэрээс тэтгэвэр авах явдал байгаа. Тийм учраас тэтгэвэр авагчдыг бид нар зөвхөн нийгмийн даатгалын сан гэхээс илүү хувийн тэтгэвэрт сонголттойгоор шимтгэлээ байршуулаад эргээд тэрийг нь хувийн тэтгэврийн сан нь арвижуулаад буцаагаад бас нэг эх үүсвэртэй болох ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Ариунзаяа гишүүн Казакстаны хэлэлцээрийн асуудал бол Засгийн газрын газраар ороод дэмжигдээд явчихсан. Та өөрөө процессыг нь маш сайн мэдэж байгаа. Тийм ээ. Одоо Улсын Их Хуралд ороход Улсын Их Хурал маань хэзээ хуралдах бол.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн тодруулаад асуучих юм уу. Чинбүрэн сайд саяын асуултад хариулах уу. Чинбүрэн сайдын микрофон.

Ж.Чинбүрэн: Ариунзаяа гишүүний хэлээд байгаа зөв л дөө. Ер нь яг төсөвт улсын төсөвтэй эмнэлгүүдэд ажиллаж байгаа ажилчдын цалинг тусад нь төсөв байлгая гэдэг санаа бол тэр ч утгаараа Засгийн газраас сая энэ багш, эмч нарын, эмнэлгийн байгууллагын, ажилчдын цалинг нэмэх 15 хувийг бодитой тоо болгож анх удаагаа орууллаа. Өмнө нь том алдаа байсан зүйл нь гүйцэтгэл гэдэг нэрийдлийн доор цалингийн тэдэн хувь, тэдэн хувь нэм гэхихдэг. Тэгсэн хэр нь тоо нэмэгдээгүй. Ингээд даатгалын сан өөрөө зөвхөн цалин олгодог сан болчихоод байгаа байхгүй юу. Гүйцэтгэл биш. Тийм учраас ийм том реформууд хийхийг бид зориод, 8 зорилго, 30 ажлыг энэ 2026 оны төсөвтэй хамт Засгийн газарт бас даатгалыг зөв болгох тогтолцоог нь засах ийм санал төсөл оруулчихсан байгаа.

Б.Найдалаа: Ариунзаяа гишүүн тодруулж асууна.

А.Арунзаяа: Харин тийм ээ. Чинбүрэн сайд аа. Хоёулаа энийг ярьж байсан, тэгээд ер нь ямар ч өөрчлөлт орж ирэхгүй ингээд хэвээрээ явчхаж байгаа байхгүй юу. Дахиад 1 жил алдаж байна гэсэн үг. Гэтэл Эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөгч өнөөдөр эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлсийг нь өгөөд гэтэл өөрөө эрүүл мэндийн үйлчилгээ авч чадахгүй байгаад байгаа байхгүй юу. Яагаад гэхээр сан хоосон гээд эрүүл мэндийн үйлчилгээг хязгаарлаад байгаа байхгүй юу даа. Тэгэхээр төр хүнээ ажиллуулж л байгаа юм бол цалин хөлсөө өөрөө төсвөөсөө даа л даа. Шимтгэл төлөгч шимтгэлд төлсөн тэр дүнгээрээ эрүүл мэндийн үйлчилгээ л авъя. Шударга биз дээ. Тэгэхээр энийг өөрчлөх хэрэгтэй байна. Засгийн газар маань энэ дээр анхаараач. Алдаа хаана байгаа вэ гэдгийгээ мэдэж байгаа шүү дээ.

Аубакир сайдаа өргөн барьчих. Өргөн бариад процесс чинь явах юм Их Хурал өөрийнхөө процессынхоо дагуу үйл ажиллагаагаа эхэлнэ шүү дээ. Тэр чинь даргын дэргэдэх зөвлөл дээр Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо дээр харьяалагдана. Эргээд хэлэлцүүлгүүд нь хийгдэнэ. Чуулганд орж ирнэ. Хугацаа алдаж л байгаа байхгүй юу даа бид нар. Тэгэхээр чинь энэ дээр бол чухал байхгүй юу.

Б.Найдалаа: 1 минут өгье.

А.Ариунзаяа: Би Учрал сайдад юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр та хэд маань Эдийн засаг, хөгжлийн яам Хөгжлийн бодлогоо гартаа аваач ээ. Одоо бол Сангийн яамны бодлогоор л явдаг. Та намайг түрүүн хэлсэн. Би нөгөө сайд байсан учраас гол асуудлыг мэдээд байгаа шүү дээ. Сангийн яамны бодлогоор яваад байгаа байхгүй юу. Эдийн засаг, хөгжлийн яам гол асуудлуудаа гартаа баримаар байна. Ямар хөгжлийн бодлого гаргаж байгаа юм, түүндээ зориулж төсөв сангийн ийм бодлого явах ёстой болохоос биш мөнгө хэд байгаа вэ гэдэг дээрээ суурилж л бодлого яваад байна шүү дээ. Тэгэхээр чинь энэ чинь бүх юм алдаатай байгаад байгаа байхгүй юу.

Залуучуудын асуудлыг маань буцаагаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд өгөөдхөөч. Соёлын яам дээр залуучуудын асуудал ороод, нийгмийн бүлгээсээ 1-ийг нь гаргачхаад, тэгээд тэнд 200 сая төгрөг тавьчхаад, тэгээд залуучууд руу хандсан ажилд явуул гээд байгаа байхгүй юу. Буцаагаад өгөөдхөөч. Та нарт бүрэн эрх нь байгаа шүү дээ. Энэ бодлогын алдаануудаа та нарт засах эрх нь байгаа байхгүй юу. Битгий Их Хурал руугаа ингээд Их Хурал бүх юмыг нь гацаагаад суугаад байгаа юм шиг ийм үг, асуудал хэлж болохгүй шүү дээ тийм ээ.

Б.Найдалаа: Баярлалаа: Ариунзаяа гишүүний энэ гаргаж байгаа санал зөвхөн Ариунзаяа гишүүн биш олон гишүүн ярьж байгаа зөв санал шүү. Яагаад гэвэл эмч, багшийн цалин, тэтгэвэр нэмж чадахгүй байгаа шалтгаан чинь бид нар саяынх шиг бүтцийн шинэчлэлийн ажлаа хийхгүй байгаад байгаа болохоор эх үүсвэргүй болчихоод байгаа биз дээ. Тэгээд нэгэнт боочихсон, хуваарилчихсан төсөв дээр бид нар яаж ч ажиллаад ерөнхийдөө бол маш хэцүүдээд, зөвхөн гал унтраана уу гэхээс бодитой дэмжлэг байхгүй. Тэгэхээр саяын шинэчлэлүүдийг Эрүүл мэндийн даатгалын сантай холбоотой, Нийгмийн даатгалын сантай холбоотой яг эмч, багш нарын цалинг ч юм уу яг тэр хэрэгтэй газраа төсвүүдээ яаж хуваарилахаа алсаас нь шийдэхгүй бол болохгүй байгаад байгаа энэ саналыг бас сайд нар хүлээж аваарай гэж хүсэж байна. Дараагийн гишүүн Саранчулуун гишүүн үгээ хэлнэ. Энэ дээр нэмэх нь Эрдэнэбат гишүүн, Алтаншагай гишүүний нэрийг асуулт асуух дээр нэмээдхээрэй. Саранчулуун гишүүний микрофоныг нээе.

О.Саранчулуун: Ахиад асууя. Түрүүн би Төрийн байгуулалтын байнгын хороон дээр асуусан. Сангийн яамнаас ахиад асууя. Энэ Байнгын хороон дээр ч гэсэн дахиад асууя. 2025 оны 6 сарын 2-ны өдрийн Сангийн сайдын 112 дугаар тушаал дээр төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай гэж тушаал байгаа. Энэ дээр энэ ангилал 2025 онд буюу энэ жил байгаа. Яагаад 3 жилийн өмнө, 4 жилийн өмнө, 2 жилийн өмнө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн яамны дэргэдэх зөвлөл чинь энэ ангилалд энэ ангиллыг оруулаад өгөөч ээ, хүртээмжийн асуудлыг оруулаад өгөөч ээ гэдэг саналыг удаа дараа хэлж байхад хамгийн сүүлд гарсан энэ ангилал яагаад багтаагүй шалтгааныг тайлбарлаач ээ.

Түрүүн бол Төрийн байгуулалтын байнгын хороон дээр бид нар хийж байна, ярьж байна, бодож байна гэдэг хариултаа яг улиг болоод давтаад байгаа байхгүй юу. Би энийг дахиад энд байгаа Сангийн яамны төлөөллөөс асууя.

2 дугаар асуудал нь төсвийн 86, 60, 20 би нөгөө ангиллыг нь л барьж ярья гэж бодож байгаа. Ойлгомжтой хэлээр. Тэгэхээр 86, 60, 20 гэдэг энэ кодтой зардал байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэж байна. 16 тэрбум 813.9 сая төгрөгтэй ийм зардал байгаа. 16 тэрбум төгрөгөөр, энэ мөнгөөр

хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүн хөдөлмөр эрхэлдэг болох вэ. Ийм тооцооллыг сонсоод тодруулъя.

Б.Найдалаа: Сангийн яамнаас микрофон дээр очъё. Ер нь тэр ажлын хэсгийн микрофон дээр бэлэн байхгүй бол энд микрофон байхгүй юм байна шүү. Индэрийн микрофоныг нээе.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Эдийн засгийн ангилал гэдэг ойлголт ОУВС-ийн нэгдэн орсон 190 хэдэн улсын 1 хэлээр ойлголцох зорилгоор гаргасан гэж хэлэх юм уу даа, төрийн санхүүгийн стандарт гэж байдаг. Тэр стандартынх нь дагуу баталдаг. Жишээ нь цалин гэх юм бид нар цалин гэж л тавьдгаас биш хөгжлийн бэрхшээлтэй иргэний цалин гэж тавьдаггүй юм байгаад байгаа юм. Таны хэлээд байгаа энэ зүйл маань бол гол санааг нь би ойлгож байна. Эдийн засгийн ангилал дээр биш зориулалт дээр байгаад байдаг юм. Өөрөөр хэлбэл тухайн мөнгийг юунд зориулах гэж байна гэдэг асуудал дээр, мөн хөтөлбөр дээр байгаад байдаг. Хөтөлбөр зориулалт нь аль хэдийн угаасаа энэ яг нэрээрээ бол орчихсон байж байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй холбоотой тийм зориулалт нэр бол байгаа гэдгийг хэлье. Жишээ нь бол 2025 оны төсөв дээр жишээ нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд дээр яг энэ зориулалтаар 1,3 тэрбум төгрөг батлагдсан байна. Эрүүл мэндийн сайд дээр 350 сая төгрөг. Сангийн сайд дээр 477, Боловсролын сайд дээр 283 сая төгрөг гээд батлагдсан байж байгаа. Энэ зориулалтаар. Та нөгөө зориулалтыг нь харах хэрэгтэй шүү гэдэг зүйлийг хэлье.

Эдийн засгийн ангилал бол ерөнхий тайлбар гэсэн үг. Төсвийг бид нар ер нь зүгээр эдийн засгийн ангиллаас гадна зориулалтаар нь ангилж болж байна, хөтөлбөрөөр нь ангилж болж байна, байршлаар нь ангилж болж байна. Аль аймаг, сум гэдгээр нь, төсвийн төрлөөр нь ангилж болж байна. Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, улсын төсөв гэдэг шиг тийм ялгаатай зүйлүүд байгаад байгаа шүү.

Б.Найдалаа: Хариултаа аль болох товчлох хэрэгтэй юм байна. Яагаад гэвэл бид нар нөгөө дэгийн дагуу 4 минут дээр нь нэмэх 1 байгаа. Хэрвээ шаардлагагүй бол товчхон, дараагийн ажлын хэсгийн гишүүндээ цаг гаргана шүү.

2-т гишүүд ээ, энэ жижигхэн танхим болохоор заалны чимээ их ороод, хуралд саад болох шинжтэй байна. Тэгээд хоорондын яриа чимээгээ жоохон бага байлгахыг хичээх ёстой юм байна шүү. Саранчулуун гишүүн хариулт болсон уу. Сангийн яам дутуу юу. Өөр хэн байсан юм. Сангийн яамнаас яг тодорхой хариулчихмаар байна. 16,8 тэрбум төгрөгөөр хэдэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажилд оруулах юм бэ. Сайд хариулах юм уу. Эсвэл танай Төрийн нарийн хариулах юм уу. 3 номерын микрофон нээе.

Л.Мөнхзул: Гишүүний асуултад хариулъя. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхзул байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн салбарт 2026 онд нийтдээ 245,7 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөж байгаа юм. Үүнээс яг 9,4 тэрбум төгрөг болохоор хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрах зардалд, 1,7 тэрбум төгрөг нь болохоороо хөтөлбөр, арга хэмжээний зардалд, 10,3 тэрбум бол хөрөнгө оруулалтын зардалд, 15,8 тэрбум төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зардалд. Үүнээс шинээр бий болох ажлын байрыг 4 мянга гэж тооцоолж байгаа. Энэ онд бол нийт хөгжлийн бэрхшээлтэй

хүмүүсээс ажил хийх боломжтой хүмүүсийн судалгааг авч дуусаад, энэ онд бол цогц арга хэмжээнд 5 мянга орчим хүнийг хамруулах ийм төлөвлөгөөтэй байгаа. Ирэх онд бол шинээр бий болгох ажлын байр 4 мянга гэж тооцоолж байна.

Б.Найдалаа: Тодорхой хариулт байна. Саранчулуун гишүүн тодруулж асуух уу. Саранчулуун гишүүний микрофоныг нээе.

О.Саранчулуун: Ингээд хариулт болон энэ цаасан дээр байгаа зүйл 2 зөрөөд байгаа болохоор л асууж байгаа байхгүй юу. Энэ төслийн хавсралт дээр байгаа энэ 15 дугаар хавсралт дээр чинь саяын миний хэлсэн тоо байгаа байхгүй юу. Тэгэхээр өнгөрсөн жил, тэрний өмнөх жил энэ тайлангуудыг авч байхад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжих хөдөлмөрийг дэмжих сан гээд явж байна. Дэмжих сан. Гэхдээ ажилд орсон хөгжлийн бэрхшээлтэй хүнийх нь тоо, орсон хойноо ажиллаж байгаа дундаж жил энэ тэр мэдээлэл нь ерөөсөө байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр үнэхээр хөдөлмөрийг дэмждэг юм уу. Энэ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан чинь үнэхээр хөдөлмөр эрхлэлтийг яг дэмждэг юм уу, үгүй юу гэдгийг л би тодруулмаар байгаа юм. Бид нар өнгөрсөн жил яг Боловсролын зээлийн сан шиг одоо энэ сан руу орох цаг болжээ. Энэ сангийн зарцуулалт зөв байна уу, үгүй байна уу гэдгийг ярих болсон байна. Тэгэхээр ийм тоо л асуугаад байгаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан яахаараа хүнд хэлбэрийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эмчилгээ асаргааны зардал руу ордог билээ. Энэ дээр тодорхой хариулахгүй байна шүү дээ ерөөсөө.

Б.Найдалаа: Энэ дээр тодорхой биш гэдэг дээр хариулт байна уу. Хэд билээ. Микрофон 3. Та бас тодорхой хариулчхаарай.

Л.Мөнхзул: Түрүүн дурдсан 276 тэрбум маань Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгаад, хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулж байгаа нийт зардлын дүн юм. Энэ дотор тэтгэвэр, тэтгэмжийг оруулахгүйгээр. Харин үүнээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд нь 15 тэрбум юм. Түрүүний дурдсан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асрах зардал бол бусад нийгмийн халамжийн сангийн зарцуулалтаасаа зарцуулж байгаа юм гэдгийг нь ялгаж бас ялгаатай тоонууд байгаа шүү.

Б.Найдалаа: Саранчулуун гишүүн тодруулчих. Саранчулуун гишүүн тодруулна.

О.Саранчулуун: 15 тэрбум юм байж. Энэ дээр бол 16 гэж байна л даа. Энэ бид нарт ирсэн ном дээр. 15 байна уу, 16 байна уу хамаа алга. Хэлээд байна шүү дээ. Хэдэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд оруулж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийнхөө зорилтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хуулиа биелүүлэх юм бэ. Би ийм тоо л асууж байгаа.

Б.Найдалаа: Тоо байвал хэлнэ үү. Микрофон 3. Хэдэн хүн ажилд авах юм бэ.

Л.Мөнхзул: Яг одоо нөгөө хөтөлбөрийн үр дүнг шалгаж үзэхдээ тухайн ажлын байранд зуучлагдаад байнгын нийгмийн даатгалын шимтгэл төлөөд, дор хаяж 3-аас доошгүй сар шимтгэл төлсөн тохиолдолд байнгын ажлын байранд орсон гэж шалгуур үзүүлэлтээр бол үзэж байгаа. Тэгэхээр ирэх жил нэмэгдэх дүн маань 4 мянган шинэ ажлын байр гэж бид бол тооцоолж байна гэсэн үг. Гэхдээ энэ 15.8 буюу 16 орчим тэрбум төгрөг маань тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг цогц арга хэмжээ буюу хөдөлмөрт бэлтгэх, ажил мэргэжил олгох, сургалтад хамруулах,

ажлын байран дээр ажил олгогчид хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр шимтгэлийг нь төлж цалин хөлс өгч дадлагажуулах, мөн хувийн туслалцаа авах гэх мэт олон цогц арга хэмжээ авч байж хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажлын байранд зуучилдаг, мөн зуучлах гэх мэт. Ингэхээр өөрөөр хэлбэл нийлбэр дүнгээрээ 20-иод орчим мянган хүн хамрагдана. Үүнээс шинээр бий .../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Асуулт асуух нэрс уг нь авчихсан. Гэхдээ Байнгын хороо зэрэгцэж явж байгаа учраас Батнайрамдал гишүүнийг асуулт асуух гишүүний нэр дээр нэмнэ үү. Ганмаа гишүүн бас нэмэгдье. Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: 2026 оныг боловсролын жил болгож зарласан. Тэгээд тэрэнтэй холбоотойгоор ч юм уу мэдээж багш нарын цалин хөлсний асуудал яригдаж байна. Тэгэхээр боловсролын салбарт бол би багш нарын цалин хөлс нэмэгдсэнээр бүх асуудал ингээд шийдэгдчихнэ гэж бас ойлгохгүй л байгаа юм л даа. Тийм учраас зөндөө асуудал байгаа. Жишээлбэл багш нарын байр, орон сууцын асуудал байна. Хөдөө, орон нутагт ажиллаж байгаа, сумд очиж шинээр ажиллаж байгаа багш нарын байр орон сууцын асуудал байна. Тэгээд мөн техник, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн асуудал байгаа. Хөрөнгө оруулалт. Тэгээд сүүлийн үеийн зарим юмыг харахаар хөрөнгө оруулалтаа бараг 0 болгож бүгдийг нь хасчихаад, зөвхөн цалин нэмчихээр л бүх юм болчих юм шиг бас хандлагууд байна л даа. Тэгэхээр тийм юм бол байхгүй. Хөдөө, орон нутагт чинь нураад унах гэж байгаа сургууль, зайлшгүй шаардлага хийх, засвар хийх, шаардлагатай барилга байгууламж гээд олон асуудлууд байна. Тэгэхээр яг тэр төсвийн хуулийнхаа дагуу бид нар барилга байшин, хөрөнгө оруулалтаа ч хийнэ, их засвараа ч хийнэ, тоног төхөөрөмжөө ч авна. Ингээд энэ боловсролын салбарынхаа асуудлыг энэ боловсролын жилийнхээ хүрээнд цогцоор нь авч үзэж байж бас энэ салбарт ахиц дэвшил гарна гэж ингэж ойлгож байгаа юм.

Тэгээд ирэх жилүүдэд 200 сургууль, цэцэрлэг 2030 он хүртэл барьчихвал Монгол Улс ингээд сургууль, цэцэрлэгийн хүртээмж нь хангагдчихна гэж ингэж яриад байгаа. Гэтэл ирэх жилийн төсөв дээр боловсролын салбарт 15 шинэ барилга л байгаа. Дахиад АХБ-ны санхүүжилтээр 41 сургууль, цэцэрлэг барина гэсэн. Үлдсэн 150-ийг нь яаж барих вэ. Яаж эхлүүлэх вэ гэдэг асуудал байгаа. Тэгээд Монголын хувийн хэвшилд бол маш их боломж байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа олигтой болгоод, хувийн хэвшилдээ барилга барихад зохих хэмжээний ашигтай байх юм бол өнөөдөр Монголын барилгын компаниуд өнгөрсөн жил гэхэд 19.600 айлын орон сууц барьж ашиглалтад оруулсан. Энэ бид нарт хэрэгтэй байгаа 150, 200 сургууль цэцэрлэгийг Монголын барилгын компаниуд 1 жил юм уу, 1 жил 6 сарын хугацаанд хийж дуусгаж өгч чадна. Тийм бүрэн боломж потенциал байгаа. Хөрөнгө санхүү ч байгаа. Гол нь улс энэ дээрээ дорвитой арга хэмжээ аваад, тэр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулиа тодорхой болгоод, хувийн хэвшилдээ ч ашигтай, орон сууц бариад зарахад олдог ашгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг барихаар олчихдог байх юм бол энэ хувийн хэвшил чинь энэ сургууль, цэцэрлэг, эмнэлгийг маш богино хугацаанд бариад хангачих ийм боломж байна. Хувийн хэвшилд. Энийгээ яаж ашиглах вэ. Наранбаяр сайд энэ дээр ямар бодолтой байна. Тэгэхгүй бол 10 жилийн өмнө ч бид нар нэг сургууль, цэцэрлэг, үнийн өсөлт, барилга байшингийн үнийн өсөлтийн тухай л ярьдаг байсан. Одоо дахиад хэдэн ч жил ярих юм. Тэгэхээр бид нар зоригтойхон шиг шийдвэр гаргаад, энэ боловсролын жил гэж зарласан 2026 ондоо энэ 200 сургууль, цэцэрлэгээ эхлүүлчхэж болдоггүй юм уу. Энийг бүр Засгийн газрын түвшинд бодлогын түвшинд сайн яриад энийг эхлүүлмээр байна. Би бол ийм санаачилга гаргаж байгаа. Хувийн хэвшилд нөөц байгаа. Гол нь буцаагаад улс бариулчихаад мөнгөө л цаг хугацаандаа

тэр ирэх жилүүддээ өгчих хэрэгтэй байхгүй юу. Тэгэхгүй бол мөнгийг нь өгөхгүй саатуулах юм бол мэдээж хувийн хэвшил хохирно. Тийм учраас ганц боловсролын салбар ч биш, соёлын салбар, эрүүл мэндийн салбар ч гэсэн зөндөө олон барилга байгууламж хэрэгтэй байгаа. Тэгэхээр ер нь энэ яг барилга байшинтай холбоотой хөрөнгө оруулалтаа хувийн хэвшлээ ашиглаад, 1 жилд зоригтой шийдвэр гаргаад ингээд шийдээд эхлүүлээд явж болохгүй юу. Тэгвэл маш богино хугацаанд энэ асуудал шийдэгдчих гээд байгаа юм. Тэгэхгүй бол дахиад л 2028 он, 2030 онд манай Байнгын хорооны гишүүд ингээд л барилга байгууламж, тэгээд л төсөв нэмэгдсэн, хасагдсан зарим нь зогссон 10 жил үргэлжилж байгаа гээд ийм асуудал яриад суух юм шиг байна л даа. Тэгэхээр энэ дээр би нэг ийм дорвитой шийдэл, юмыг эрэлхийлж байгаа юу гэж Боловсролын сайдаас асууя.

Б.Найдалаа: Наранбаяр сайд хариулна.

П.Наранбаяр: Баярлалаа энэ маш зүйтэй ийм санал. Бид бас энэ 200 сургууль, цэцэрлэг гэж ярьж байгаа. Үүнээс гадна улсын төсвөөр бас шинээр барих 15 бий. Ингээд бас орон нутгийн төсвүүдээр барих байгаа. Жишээлбэл нийслэл гэхэд 10-аад сургууль, цэцэрлэг шинээр барихаар төлөвлөсөн байх жишээтэй. Ер нь бол Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн энэ хэрэгжилт болохоороо түншлэлийн төв гэж байгаа. Тэгээд бид Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтраад ажлын хэсэг байгуулаад, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, дараа нь төлбөр мөнгийг нь шуурхай төлөх энэ боломжуудыг нээхээр ажлын хэсэг дээрээ ярилцаж явж байгаа. Гэхдээ нэг юм байдаг юм байна лээ. Дээр үед Концессын хууль гэж гарч ирээд, тэгээд Концессын хууль хэрэгжиж эхлэхдээ зах зээлийн үнээсээ хэд дахин өндөр үнэлгээтэйгээр нэлээн их өндөр үнэтэйгээр баахан төслүүдийг хэрэгжүүлээд, тэрийг нь өрийг нь дарах гэж Сангийн яам хэдэн жил явсан гэдэг билээ. Одоо ч дуусаагүй. Зарим нэг нь ингээд дуусаж байгаа учраас маш их болгоомжилдог. Төр талаасаа ийм нөхцөл байдал үүсчихсэн юм байна лээ. Тэгэхээр зэрэг бид энэ удаагийн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл өргөн барьчихсан байгаа. Энэ бол боловсролын салбарт түншлэлийн төсөл илүү хэрэгжүүлэхэд хялбар болж байна гэж харж байна.

Тэгээд дээр нь нэмээд энэ татварын 1 хувийн хөнгөлөлтөөр бол хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татаж, багийн бага сургууль барих төслийг бол бид хэрэгжүүлж байгаа. Жишээлэх юм бол 1 хувийн хөнгөлөлт дээр өнөөдөр ерөөсөө Хаан банк ороод ирчихсэн. Тэр Номин корпорац билүү, энэ том компани ороод ирчихсэн гээд том том компаниуд орж ирээд, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтраад 4 газарт багийн бага сургууль яг олон улсын жишгээр бариад явж байна. Ийм сайн жишээ байна. Тэгэхээр бид бас энэ Монполимет байх. Ийм сайн жишиг байна. Тэгэхээр бид цаашдаа ийм сайн жишээг их олноор нь бий болгож, төр, хувийн хэвшлийн түншлэлийг илүү сайн дэмжсэн илүү хариуцлагатай ийм түншлэлийг бий болгох нь чухал байна гэж харж байгаа.

Таны хэлдэг яг үнэн. Төр өөрөө барихаараа 3 жил дамнуулчихдаг. Жоохон, жоохон төсөв тавиад, сүүлийн үед арай хурдтай нь 2 жил байна. Тэгэхэд хувийн хэвшил бол 1 жилийн дотор, 1 жил хагасын дотор бариад байгаа нь үнэн. Энэ өөрөө зардлыг бол хамаагүй сайн хэмнэнэ. Тэгэхээр зэрэг энэ сайн талыг нь бид илүү дэмжиж, хувийн хэвшилтэйгээ хариуцлагатай ингэж хэрэгжүүлж явах боломж байна гэж харж байгаа. Энэ дээр бас Сангийн яаманд хандаж уриалахад энэ шинэ цаг үе эхэлчхээд байгаа ийм үед бас төр, хувийн хэвшлийн түншлэлийн энэ төслүүдийг бас сайн дэмжиж өгөөч ээ гэж уриалж байна. Ингэх юм бол нийслэл дээр бол маш

хурдтай шийдчихэж болж байгаа байхгүй юу. Бэлэн ийм сургуулиудыг бас зах зээлийн үнэлгээгээр нь хөндлөнгөөр үнэлүүлээд, худалдаж авах, мөн бариулах ийм хурдтай сайн барьдаг компаниудаар хурдан бариулах энэ тэр гээд ийм сайн талууд байгаа. Түрүүнд бас МАК орж ирсэн ийм нөхцөл байдалтай байгаа шүү. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Хосбаяр гишүүн тодруулна.

Г.Хосбаяр: Хөдөө суманд ажиллаж байгаа багш нар чинь байр орон сууцын асуудал бас байдаг. Шинээр очиж ажиллаж байгаа залуу багш нар суманд ямар орон сууц байх вэ дээ. Тэгэхээр Барилга, хот байгуулалтын яамтай уг нь Барилга хот байгуулалтын яам чинь 90 сумд 8 айлын орон сууц барина гэж байсан. Энийгээ эхлээгүй л байх шиг байна. Тэгээд энэ юу болж байгаа юм. Дээр нь яах вэ, дахиад л хэлэхэд багш нарын цалинг ч нэмэх ёстой. Орон сууц, ахуйн хангамжийг нь ч сайжруулж, нийгмийн баталгааг нь нэмэгдүүлж, мөн очоод хичээл, ажил тал дээрээ тав тухтай ажлын байр бий болгож, барилга байшин, техник тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийж байж энэ багш нарын нийгмийн баталгаа хангагдаж энэ салбарын асуудалд, энэ салбарт ахиц дэвшил гарна. Түүнээс биш зөвхөн цалин яриад байж болохгүй ээ. Давхар хөрөнгө оруулалт, тэр орон сууц, энэ хувийн хэвшил гээд олон юмыг бас давхар давхар яримаар байна. Боловсролын жилийнхээ хүрээнд бас үр дүнтэй тийм зоригтой шийдвэр гаргая гэдгийг бас энэ Байнгын хорооныхоо гишүүдэд уриалж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Үг хэллээ. Ганхүлэг гишүүн асуулт асууна.

М.Ганхүлэг: Хосбаяр гишүүнтэй ер нь асуулт, санал нэлээн давхардаж байна. Сангийн яам болон аудитаас магадлалтай холбогдолтой, ялангуяа орон нутагт хэрэгжиж байгаа төслүүд бараг 2020, 2021 онд эхэлсэн төслүүд өнөөдрийг хүртэл бас дуусаагүй, зарим нь бүр түүнээс ч урт хугацаанд бас хэрэгжээд байгаа. Үүнтэй холбогдолтой асуудлуудыг ер нь цаашдаа бид яах ёстой вэ. Төсвийн санал өргөн баригдсанаас хойш бас аудитын дүгнэлтүүд гарсан. Энэ ондоо бас дуусгачих ийм бүрэн боломжтой хэд хэдэн төслүүд бас зүүн бүс дээр байгаа. Батширээт болон Цэнхэрмандал суманд баригдаж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалттай төслүүд бас байгаа юм. Тэгэхээр энэ төслүүдийг бас нэмэгдүүлэх байдаг юм уу. Аудитын дүгнэлтийг цогцоор нь шийдэх энэ хувилбарууд бас Сангийн яаман дээр яригдаж байгаа зүйлүүд байна уу гэдэг энэ асуултыг бас тодруулъя. Заавал ч үгүй зарчмын зөрүүтэй саналаар энэ асуудлууд төсөл болгон дээр хэрэгжүүлэх шаардлагатай юу гээд.

Ерөнхий энэ 2026 оны төсөв өөрөө хүний хөгжлийн том мега төсөв болно гэдэг ийм зорилготой орж ирсэн. Тэгээд би Байнгын хорооны хурал болгон дээр асуугаад байгаа. Яг үүний цаана хүний хөгжил гэдгээ яг юуг тодорхойлж байгаа юм. Яг ямар асуудлыг бид нар яг цогцоор нь энэ 2026 онд шийднэ гэж харж байгаа учраас энэ мега төсөл гэж бид бүхэн нэрлээд байгаа юм.

Боловсролыг дэмжих жил гэдэг энэ агуулгатай төсөв гэж бас ойлгож байгаа. Үүний хүрээнд саяын бас Хосбаяр гишүүний гаргаж байгаа тэр хувийн хэвшлийн оролцоотой хүртээмжийг сайжруулах энэ чиглэл дээр бас тодорхой анхаарал хандуулах гэдэг дээр бол би санал нэг байгаа юм. Ялангуяа бид бүхэнд шинэ боломжийг бий болгосон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг ер нь энэ чиглэл рүү бас гаргах, хүртээмжийг илүү бий болгох, цэцэрлэг, сургуулийн барилгыг бүрэн хангах, нэг ээлж рүү оруулах гэдэг энэ зорилтоо хамгийн эхэнд тавиад, төсвийн бусад боломжуудыг бий болгох чиглэл дээрээ бас тодорхой шийдвэр

гаргахыг бол бас дэмжиж байгаа. Тэгээд энэ дээр бас ямаршуу бололцоонууд байх вэ. Ялангуяа тэр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг энэ рүү чиглүүлбэл Байнгын хорооноос бас тодорхой санаачилгуудыг гаргавал яасан юм бэ гэсэн ийм саналуудтай байгаад байгаа юм. Асуулт нь нь тэр магадлангаар орж ирж байгаа энэ төслүүдийг ер нь цогцоор нь анхаарч үзэж байгаа зүйлүүд байна уу. Энэ дээр яаж ажиллахаар болж байна вэ. Эсвэл тус тусад нь гишүүд өөрсдөө санаачилгаараа явах уу гэдгийг асууж байна.

Б.Найдалаа: Хэнтэй хариулах вэ. Сангийн яам. Индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Төсвийн тухай хуулиараа бол цаглавар гэж байгаа. Цаглавар бол 9 сарын 1-нд бид нар төсвөө өргөн барих хуультай байгаа. Яг энэ хугацаанд бол Үндэсний аудитын газраас магадлангаар ирсэн тэр зардлуудыг бид нар тусгаад, ингээд оруулаад ирчихсэн байгаа. Тэрнээс хойшоо ирсэн төслийг бид нар хүлээгээд суух боломжгүй. Хуулийн хугацаа байгаад байгаа учраас тэгээд одоо бол тэрийг парламентын хэлэлцүүлгийн шатад л нэмэгдүүлэх боломжтой. Тэрнээс биш Засаг буцаад энэ дээр өргөн барьсан төсвөө задлах тийм боломжгүй байгаад байгаа.

Б.Найдалаа: Ганхүлэг гишүүн тодруулах уу. Болсон уу. Баярлалаа. Дараагийн асуулт асуух гишүүн Бейсен гишүүн. Бейсен гишүүний микрофоныг нээе.

Б.Бейсен: Энэ төсвийн төсөлтэй ерөнхийдөө танилцаад байна л даа. Гэтэл энэ дотор шаардлагатай шаардлагагүй юм их байна. Сангийн яамныхан. Энэ эмч, багш нарын цалинг 15-20 хувь нэмнэ гээд ярьж байна. Багш нар, эмч нар зөвшөөрөхгүй байна. 50 хувь юм уу, 1 дахин нэм гээд. Энийг урсгал зардлаас хасна гэж сонссон. Энэ 2 сар салбарын урсгал зардлыг хасаад нэмэх шаардлага байхгүй. Үнэхээр урсгал зардал нь энэ 2 салбар дээр үнэхээр хэрэгцээтэй тийм салбар байгаа юм. Тэгэхээр энийг яг юунаас, ямар эх үүсвэрээс гаргаад нэмэх гэж байна. Энэ талаар асууя.

2 дугаарт ерөөсөө дуусдаггүй нэг юунууд байж байна. 6, 7 жил болчихсон. Зарим нь 9 жил болчихсон. Баян-Өлгий аймгийн энэ үерийн хамгаалалт гээд байгаа. Энэ эхэндээ 13 тэрбум байсан байх. Дараа нь 23 тэрбум болсон. Энийг бол би байнга үзэж байгаа. Одоо нэмээд юм татаж байгаа юм болов уу гээд үзэхэд нэг ч нэмээд татсан суваг тийм юм байхгүй. Зүгээр уулын жалга дагаад үерийн хамгаалалт хийсэн. Ноднин үер болоход дахиад үерт автсан. Тэгэхээр энийг Сангийн яамныхан шалгаад үздэг юм уу, үздэггүй юм уу Санжаадоржоо. Шууд хэлснээр нь нэмээд өгчихдөг юм уу. 10 тэрбумаар нэмэгдүүлнэ гэж юу байх вэ дээ. Одоог хүртэл үзээрэй. 1 ч нэмэгдсэн юм байхгүй энэ дээр.

Хотгорын уурхайн тэр эмнэлгийн асуудал байж байна. Эхэндээ 400 хэдэн сая байсан. Одоо бараг 2 тэрбум хүрч байна. 1 том хаусны дайтай байшин. 20 ортой эмнэлгийн. Одоог хүртэл барьж дуусдаггүй ерөөсөө. Ийм юм дээр тооцоо хийгээд, хариуцлага тооцмоор юм ярьсан юм.

Дараа нь энэ эрүүл мэндийн салбарын эрүүл мэндийн даатгалын асуудал байж байна. Одоо цаана хоцорчихсон. Гаднаас бүгдээрээ эм авчруулж байна. Эмнэлгийн хэрэгсэл нь дутагдалтай, төсөв нь хүрэлцэхгүй ийм асуудал байж байгаа. Тэгэхээр энэ Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам гурвуулаа хамтарч байж энэ бүтэц, орон тоог шинэчлэхгүй бол сонгууль дөхөөд сүүлийн 2 жилд 240 хэдэн мянгаар төрийн албан хаагч нэмэгдсэн

шүү дээ. Тооцоо хиймээр юм ерөөсөө. 1 шинээр баригдсан сургууль дээр 16 цэвэрлэгч байх ёстойг 31 болгочихсон байсан. Наранбаяр сайд мэдэж байгаа байх тийм ээ. Энэ сонгууль энэ чинь л гаргаж байгаа шүү дээ. Инээдтэй юм их байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ төсөв хүн ам нь олигтой нэмэгдээгүй мөртөө ингээд юугаа нэмээд хаячихдаг. Хөдөөгийн цэцэрлэгүүд байж байна. 150 ортой цэцэрлэг дээр очсон чинь 46 хүүхэд байгаа юм. 47 ажилчинтай. Шалгалт ирэх үед хөдөөгийн малчдын хүүхдийг машинтай яваад бүгдийг нь цуглуулаад авч ирдэг. Тэгэхээр энэ дээр яахгүй бол бас төсвийн үр дүнгүй зарцуулалт байж байгаа байхгүй юу. Ийм юман дээр тооцоо хийхгүй ингээд Боловсрол яам, Сангийн яамныхан энэ дээр анхаарах шаардлагатай байгаа юм. Дараа нь тодруулъя. Хариулт авъя.

Б.Найдалаа: Сангийн яам индэр дээр.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Эх үүсвэрийн хувьд Төсвийн байнгын хороо дээр ажлын хэсэг гарчихсан. Санал гарч ирнэ гэж бид ойлгож байгаа. Мөн бусад Байнгын хороодоос санал хураагаад явж байгаа. Бидний хувьд одоо зөвхөн тооцооллын хувьд дэмжлэг үзүүлж ажиллана. Тэрнээс биш эндээс нь хасах нь зүйтэй, эндээс нь буруу гэдэг байдлаар бид бол яахгүй. Зүгээр энэ зардлын цаана ийм агуулга байгаа шүү, ийм зорилго тавьсан байгаа шүү гэдэг ийм байдлаар тайлбар хийж байгаа.

Дуусдаггүй хөрөнгө оруулалт дээр бол гишүүнтэй 100 хувь санал 1 байна. Энэ дээр зарим хөрөнгө оруулалттай холбоотой асуудлууд дээр бид бас тэгэхдээ зохих арга хэмжээг бол тэгээд зарим нь ч аргаа барсан, зарим нь арай дэвшилтэт тийм аргууд оруулаад л байгаа л даа. Жишээ нь, Төсвийн тухай хуульд бол хөрөнгө оруулалтыг зөвхөн 3 жилд хувааж тавина гэдэг заалт оруулсан. Тэр нөгөө шүүмжлээд байдаг 5 сарын 31-ний дотор тендерээ зохион байгуул буюу оны эцэст 11 сард тендерээ зарлангуутаа төсөв мөнгөө авч чадахгүй ингээд хий тоо төсөв дээр тавьж яваад гэтэл нөгөө талд нь хэрэгцээ шаардлага нь зөндөө байж байдаг. Ажлаа хийчихсэн хүмүүс нь бас ажлаа авч чаддаггүй ийм зохицуулалтыг бид нар оруулсан.

Дээрээс нь хөрөнгө оруулалт дээр бол хэрэвзээ тухайн захиалагч нь гомдол гаргах юм бол бид нар хар жагсаалтад оруулж байгаа. Тухайн компанийг дахиж тендер авахгүй байх ийм зүйлүүдийг бол хийж байгаа.

Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн багц дотор нь Засгийн газраас тогтоол гаргаад бас сайн явж байгаа хөрөнгө оруулалтаа түлхүү явуулж байгаа дээр бол санхүүжилтээ нэмэх энэ боломжийг нь бид нар бас гаргаж өгч байгаа ийм зүйлүүд байгаа. Тухайн үедээ тэгэхдээ энэ 10 жил болсон энэ хөрөнгө оруулалтуудын тухайн үеийн шалтгаан нь хэд хэдэн шалтгаан байдаг юм байна лээ. 1 дүгээрт зураг төсөв нь буруу байснаасаа болоод төсөвт өртгүүд нь маш их нэмэгдчихсэн. Тухайн үедээ компани бол энэ дүнгээр би хийж чадна гээд гэрээ байгуулж, авчихсан боловч одоо би хийж чадахгүй боллоо, энэ мөнгөндөө хүрэхгүй боллоо гэдэг ийм зүйл яриад байдаг асуудлууд байдаг юм байна лээ. Тэгээд тухайн үед нь бас нэг жил бол бүх хөрөнгө оруулалтыг царцааж байсан байдаг. Энэ шийдвэр өөрөө бас буруу байсан байна гэдэг зүйл харагдаж байсан.

Дараагийн асуудал бол Эрүүл мэндийн даатгалын сан хоосорсон гээд байгаа. Эрүүл мэндийн даатгалын сан бол ер нь аль ч салбарын төсөв бол тэр төсөв талаасаа зарцуулж байгаа үнэ талаасаа харах юм бол хангалттай байдаггүй. Угаасаа төсөв мөнгө бол хязгаартай. Орлогын хэмжээндээ л баригдана шүү дээ. Тийм ээ. Тэгэхээр орлоготоо баригдаж байгаа ийм тохиолдолд бол төсвөө яаж үр

ашигтай зарцуулах вэ гэдэг дээр л ажиллах ёстой байсан. Оны эхнээс бол илүү шаардлагатай тусламж үйлчилгээнүүд нь аль юм бэ. Яг хүний амь настай холбоотой нь аль юм бэ гэдэг дээрээ түлхүү санхүүжилтээ өгөөд, зарим гэрээр эмчлэх боломжтой ч байдаг юм уу ийм үйлчилгээнүүдээ бол арай хойш тавих, тарифын тохируулга хийх, эмнэлгүүдтэйгээ гэрээ байгуулах ийм асуудлуудыг хийх ёстой байсан.

Орон тоотой холбоотой асуудлаар бид шалгалт явуулж байгаа. Ер нь чиг үүргийн шинжилгээг бол бүх төсвийн ерөнхийлөн захирагчид хий гээд үүрэг өгчихсөн байгаа. Хууль дээр мөн заалт .../минут дуусав/

Б.Найдалаа: Бейсен гишүүн тодруулна.

Б.Бейсен: Энэ эрүүл мэндийн салбар дээр оношилгооны төв аймаг болгонд байгуулна, бүсчилж байгуулна гээд ярьж байгаа. Уг нь барилга нь байж байгаа байхгүй юу эрүүл мэндийн салбарын. Ганц MRI аппарат юм уу, тэр ангиогийн аппарат өгчихөд болох юм. Харвалт, зүрхний шигдээс дээр. Барилга нь бэлэн, мэргэжилтэн нь байж байгаа юм дээр тоног төхөөрөмж тавьж өгөхгүй тийм асуудал байж байгаа.

Боловсролын асуудал дээр Наранбаяр сайд ноднин би танайд 750 сая төгрөг боловсролын салбарт тавьсан. Урьд нь 3 тэрбум орчим тавьсан. Гэтэл энэ багш нарт сургууль болгонд компьютерын кабинет бүрэн байгуулагдсан 3 сум үлдсэн байсан. Тэгээд сургууль болгон 12, 12 нөүтбүүктэй байсан. Тэр ерөөсөө танайх хяналт хийгээгүй аймаг руу хуваарилсан, аймгийн тендерийнх нь тэгээд удирдлагууд нь цавчсан асуудал байгаа. Энийг шалгаж үзсэн үү.

Цэнгэл сумын тэр спорт заал. Би Сангийн яамныханд очоод газар дээр нь гуйсан, аваачиж өгсөн. Бас л хасаад хаясан. Гадаа гэж хэлж байгаа шүү дээ..../минут дуусав/

Б.Найдалаа: Та нэмж асуух юм уу. Дараа нь тодруулах юм уу. Хариултаа явъя. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Цэнгэл сумын спорт заалны асуудал бол тухайн үедээ яг төсөв зураг нь 7 сарын 25-нд байх бид боогоод, Сангийн яаманд явуулах үед бол ирээгүй байсан. Тэгээд тэндээсээ 9 сарын 1-нд Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсны дараа бол ирсэн. Ингээд цаг хугацааны асуудал байгаа учраас зарчмын зөрүүтэй санал гаргаад, ингээд дэмжээд оруулаад тэгээд ирэх жилийн төсөвт тусгаад спорт заалыг барьж дуусгах энэ ажлыг хийе.

Саяын таны дурдсан энэ тоног төхөөрөмжийн асуудал бол аймагт нь эрхийг нь шилжүүлчихсэн ийм байгаа. Бид тэгээд хэрвээ энэ дээр тендерийг зүй бусаар зарцуулсан, тоног төхөөрөмжийг тийм асуудал байвал бас шалгуулъя. Тэгээд энэ бол аймагт нь эрхийг нь шилжүүлээд байхад тэнд нь очоод найрлачихсан гэж ийм юмыг хүлээн зөвшөөрч болохгүй шүү дээ. Ойлголоо.

Б.Найдалаа: Бейсен гишүүн.

Б.Бейсен: Баян-Өлгий аймгийн тэр оношилгооны төвийн дутуу санхүүжилт гээд түрүүн төсвийн тодотголоор 3 тэрбум 700 сая төгрөг тавьж өгсөн. Энийг Сангийн яамных нь уу, Эрүүл мэндийн яамных нь уу ингээд өгөхгүй, одоо ингээд яг

хүлээлгэж өгөх байсан чинь дараагийн 4 сар хүртэл хойшилж байгаа юм байна. Энийг яагаад шийдэж өгөхгүй байна. Нөгөө талаар тэр түргэн тусламжийн машины асуудлууд байж байна. Ер нь бүх аймагт байдаг байх. Одоо энэ дээр уулын бүстэй аймгууд дээр туулах чадвар сайтай түргэн тусламжийн машин тавьсан уу. Энэ жилийн төсөв дээр.

Б.Найдалаа: Хариулт Наранбаяр сайд уу. Микрофон 7.

Н.Хүрэлбаатар: Эрүүл мэндийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Хүрэлбаатар асуултад хариулъя.

Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлэг 100 ортой барилга 2019 онд анх эхэлсэн байгаа. Өнөөдрийн байдлаар 85 хувийн хувийн гүйцэтгэлтэй, 2,8 тэрбум төгрөгийн гүйцэтгэл нь өгөгдөөгүй, дутуу байгаа. 3,7 тэрбум төгрөгийн цалингийн нэмэгдэл магадлалаар орж баталгаажуулж, аудитаар дүгнэлт нь гараад, сая төсвийн тодотголоор шинэ төсөл, арга хэмжээ дээр батлагдчихсан байгаа. Тэгэхээр энэ шинэ төсөл, арга хэмжээний УТ кодтой учраас шууд нэмэлт гэрээ байгуулж болохгүй байгаа. Тэгэхээр орон нутаг руу эрхийг нь шилжүүлэх асуудал судлагдаад явж байгаа.

Автомашин хувьд .../минут дуусав/

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. Минут байгаа учраас товчхон, тодорхой, хурдан хариулахгүй бол микрофон 7. Автомашин дээрээ гүйцээгээд хариулчих.

Н.Хүрэлбаатар: Тоноглогдсон автомашины хувьд бол Азийн хөгжлийн банкны 225 сая долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд яг одоогийн байдлаар 132 автомашин төлөвлөөд явж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа Бум-Очир гишүүн нэрээ татсан учраас асуулт асуух нэрсээс хасъя. Дараагийн гишүүн Бямбасүрэн гишүүн асуулт асууна.

Ш.Бямбасүрэн: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Ингээд бид нар бас ингээд ирэх оныхоо төсвийг хэлэлцээд сууж байна. Тэгээд төсвийн хөрөнгө оруулалтыг харахаар манай энэ улсын төсөв бол ер нь нэг ийм сонгуулийн жилээр л айхтар олон төсөл хөтөлбөр тавьчихдаг. Тэгээд 2, 3 жилдээ тэд нарыгаа л дуусгах гээд ядаад байдаг л ийм төсөв болчихлоо л доо. Одоо ийм тойргоос ер нь хэзээ гарах юм бэ. 2024 онд эхэлсэн маш их төсөл хөтөлбөрүүд байна. Тэгээд өнөөдөр бид нар яг тэд нарыгаа л дуусгах гээд л шинэ юм тавих гээд тавьж чадахгүй, мянга сайхан нэршил өгөөд энэ жил юуны жил, энэ жил тэрний, миний жил гээд тэр асуудлуудаа шийдэж чадахгүй хэмжээнд оччихоод байгаа юм л даа. Тийм болохоор бид нар ер нь энэ тамын тогооноосоо хэзээ гардаг болох юм бэ. Сангийн яам энэ дээр ер нь тэгээд энэ 3 жил гэдэг бас маш утгагүй байна. 20км замыг 3 жил барина. 200км замыг 3 жил барина гээд. Зарим юмнуудыг бол 1 жилд нь багтаагаад барьчих боломжтой юмыг бид нар бас ингээд заавал ингэж хуваагаад байх ямар хэрэг байдаг юм. Энэ чинь бүр зардал нь өсөөд, үүнээс болоод ингээд л баахан араас нь магадлал болоод явдаг ийм төвөгтэй асуудлууд үүсчихлээ л дээ. Тэгэхээр энэ дээр ер нь бас ямар бодолтой байдаг юм. Сангийн яамнаас бас тодруулж асуумаар байна.

Тэгээд энэ улсын төсөв дээр ер нь орон нутгийн шинж чанартай хөрөнгө оруулалтууд маш их явж байна. Ер нь бид нар орон нутагтаа эрх мэдлийг нь ер нь

хэзээнээс өгдөг болох юм бэ. Бид нар Их Хурал дээр сумын, багийн байрны асуудлуудыг хүртэл яриад байгаа байхгүй юу. Бид нар яг үнэндээ мэдэхгүй шүү дээ. Би бол зүүн бүсээ сонгочихсон Их Хурлын гишүүн. Баруун аймгийн тэр багийн төвийн барилга яг ямар хэрэгцээ, шаардлагатайг нь бид мэдэхгүй. Тэгээд энийг бид нар Их Хурлаар хэлэлцэнэ гэдэг чинь маш утгагүй болчхоод байгаа юм л даа. Орон нутгийн шинж чанартай хөрөнгө оруулалтыг бид нар ер нь орон нутгийн төсвийг ер нь нэмэгдүүлээд цаашдаа явах ёстой биз дээ. Энэ рүүгээ ер нь хэзээнээс явдаг болох юм бэ гэж бас асуумаар байна.

Тэгээд энэ жилээс чинь нийгмийн асуудал болоод байгаа энэ эмч, багш нарын цалинтай холбоотой хүн болгон л ярьж байна. Энийг бид нар заавал шийдэх ёстой. Цалинг нэмэх ёстой. Тэгээд гишүүд болгон л дор бүрнээ л хаанаас эх үүсвэр гаргаж болох вэ гээд өөр өөрсдөө судлаад л явж байх шиг байна. Энэ хүрээнд бас хэд хэдэн гишүүдтэй хамтраад зарчмын зөрүүтэй санал гаргаад явж байгаа. Энэ Байнгын хороогоор бас өнөөдөр санал хураалт явна. Тэгээд үүнтэй холбоотойгоор би Сангийн яамнаас бас тэр тодорхойгүй байгаа 1 юмыг тодруулмаар байгаа юм. Хавсралт 14 дээр байгаа 1 удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын тэр 11 тэрбум гэхихсэн энэ ер нь яг юу юм бэ. Тэтгэмжийг бол ойлгож байгаа юм. Тэгэхдээ ард нь ингээд шагнал, урамшуулал гээд байгаад байгаа байхгүй юу. Тэгэнгүүт тусдаа бас ийм шагналын төсөв гээд тусдаа байгаад байгаа юм. Энд ингээд давхар давхар баахан шагнал гээд тавьчихсан байгааг бас тодруулж өгөөч.

Б.Найдалаа: Хариулт. Индэр дээр Сангийн яам.

Ж.Дэлгэржаргал: Бямбасүрэн гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Тэгэхээр төсвийн хөрөнгө оруулалтын хувьд бол урсгал зардлаас ялгаатай хэд хэдэн онцлог, дээрээс нь хуулийн шаардлагууд байдаг. 3 жил гэж хууль дээр 29 дүгээр зүйл дээр бид нар 3 жилд багтаана гэдэг өөрөө заалт нь заавал тухайн төсөл, арга хэмжээг 3 жил гэсэн үг биш. Хамгийн дээд талын хугацаанд 3 жил хэрэгжүүлж, дуусгана шүү гэдэг ийм заалт байгаа. Энэ нь өөрөө маш олон төслүүдийг бага санхүүжилтээр эхлүүлээд, олон жил явахаас хамгаалж энэ заалтыг оруулсан. Энэ хүрээндээ бид нар ялангуяа 2026 оны төсвийн төсөл дээр байгаа төслийн тоо бол 2024 оныг харьцуулбал 2 дахин буурсан буюу нийт 579 төслийн 430 нь шилжих хөрөнгө оруулалтууд байгаа. Өөрөөр хэлбэл дийлэнх нь 2024 онд эхэлсэн, одоо 2026 онд дуусах гээд явж байгаа.

Хөрөнгө оруулалтуудын ялгаатай гол асуудал бол бид нар олон улсын байгууллагуудтай хамтраад яг энэ эрэлт хэрэгцээ хаана тухайн салбаруудад тулгамдаж байгаа асуудлууд руу илүү төсвийн хөрөнгө оруулалтуудыг чиглүүлэх ийм зохицуулалтуудыг 2022 оноос хийсэн. Энэ хүрээндээ 3 сараас эхлээд ингээд иргэдээс санал аваад сум, дүүрэг, аймаг гээд төлөвлөлтүүд маань явдаг. Нөгөө талдаа орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаа зарим ачааллуудыг ингээд чиглүүлэх ийм хуулийн зохицуулалтууд хийсэн. Гэвч хэрэгжилт дээр ямар асуудал гарч байгаа вэ гэхээр Нэгжийн тухай хууль 2021 онд өөрчлөлт ороод, нийгмийн 5 салбарын их засварыг орон нутгийн төсвөөрөө хийнэ. Улсын төсвөөр хийхгүй. Төрийн хэмнэлтийн хуулиар жижиг орон нутгийн хог хаягдлын асуудал, орон нутгийн жижиг замуудыг орон нутаг хийнэ гээд ингээд хуульчилсан боловч зарим орон нутгууд маань татаас авч байгаа учраас энэ жижиг асуудлуудаа ч шийдэж чаддаггүй. Тийм учраас одоо яг төсвийн онцлог энэ байдлаараа бол улсын төсвийн хөрөнгө оруулалт өөрөө яг нийт 330 сум, 21 аймаг, энд нийгэм болон дэд бүтцийн салбарт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх гол эх үүсвэр нь болоод байгаа.

Цаашдаа яг бид Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулж байгаа. Энэ дээр ялангуяа 2026 оны төсвийг бид нар зөвхөн улсын төсөв гэж харахаасаа илүүтэй ер нь салбарууд дээр нийт эх үүсвэрээр ямар хөрөнгө оруулалтууд хаана хийгдэж байна. Төрийн өмчит компаниуд ямар хөрөнгө оруулалт хийж байна. Хувийн хэвшил ямар хөрөнгө оруулалтууд хийдэг юм гэдэг том эх үүсвэр, зураглалаа гаргаж байгаад, яг улсын төсөв хаана дутагдаад байгаа тэр лүү чиглүүлэхийг илүү их эрмэлзэж, баримталсан. Цаашдаа энэ Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг 11 сард өргөн бариад, батлуулбал яг таны хэлээд байгаа орон нутгаараа бид нар яг ийм асуудлаа шийдье. Улсын төсөв өөрөө ингэж хөрөнгө оруулалтуудаа хийгээд, ялангуяа хөрөнгө оруулалтын төслүүдийг 5 түвшинд ангилаад, мега төсөл гэж ямар төслөө хэлэх юм, ямар хугацаанд хэрэгжих вэ гэдэг ийм зохицуулалтыг хууль, эрх зүйн хувьд нь бас хийгээд ингээд төлөвлөөд явж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Гүйцээж хариулах юм уу. Индэр.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Тэр хавсралт дээр байгаа шагнал урамшуулал гэдэг эдийн засгийн ангиллаас бол нэр нь тийм болчхоод байгаа. Ер нь бол юу гардаг вэ гэхээр үйлдвэрчний эвлэлтэйгээ тухайн байгууллагын байгуулчихсан гэрээ гэж байдаг. Түлээ, нүүрсний дэмжлэг ч байдаг юм уу. Эсвэл шагнал урамшууллын бага зэргийн мөнгө бол байдаг. Жишээ нь салбарын тэргүүн ч байдаг юм уу авах юм бол 100 мянган төгрөг ч гэдэг юм уу ийм байдлаар байдаг. Тэгээд тэр 11 тэрбум төгрөг бол нийтдээ улсын төсвийн 4200 орчим байгууллага байгаа. Тэр бүх байгууллагууд дээрээ задраад суухаар 2 сая, 3 сая ч байдаг юм уу. Жилийн хэмжээнд тиймэрхүү л мөнгө байдаг юм. Тэгэхээр бүх төрийн албан хаагчид бол тэндээс авдаг зүйл биш.

Нөгөө үр дүнгийн урамшуулал бол тусдаа цалин дээр явчхаж байгаа ийм зардал байгаа юм.

Б.Найдалаа: Бямбасүрэн гишүүн тодруулах уу. Гүйцсэн үү. Баярлалаа. Эрдэнэбат гишүүн асуулт асууна уу.

С.Эрдэнэбат: Энэ удаагийн төсөв дээр бас 1 дүгээрт жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний 24 хувийг л бариад суугаад байгаа. Хууль дээрээ бол уг нь урсгал зардал 30 хувь хүртэл гэдэг ийм боломж бол байгаа. Засгийн газар бол энийг өөрөө оруулж ирсэн. Өмнөх хамтарсан Засгийн газрын үед бол. Тийм учраас өнөөдрийн яг бодит хэрэгцээ, шаардлага гэхээр багш, эмч нар маань цалин хөлсөө 3 сая 500 мянган төгрөг болгоё гээд шаардаад суучихсан. Ахмадууд маань тэтгэврээ ядаж 1 сая 500 сая болгооч гээд ингээд суучихсан. Тэгээд үүний гол эх үүсвэрийг гаргая гээд Засгийн газар бас анхаарал хандуулаад, тодорхой тоо яриад эхэлж байгаа. Тийм учраас энэ төсвийн 24 хувь гэдэг нэг ийм юм руу чихчхээд, өөр боломж байхгүй. Их Хурал та нар өөрсдөө баталсан шүү дээ гээд ингээд суугаад байгаа. Тэгээд энийг Засгийн газар өөрөө энэ 24 хувиа өөрчлөөд, тэр хууль дээрээ байгаа 30 хувь руугаа дөхүүлээд, тэгээд энэ төсвийн боломж, юмаа нэмэгдүүлээд энэ асуудлуудаа шийдэх боломж байна уу. Эсвэл энийг чинь Их Хурлын гишүүд санаачлаад явах юм уу. Яах юм. Энэ тал дээр тодруулж асуумаар байна.

2 дугаарт Ерөнхий сайд мэдэгдэхдээ хөрөнгө, урсгал зардлыг бүгдийг нь 10 хувь гэхихсэн жигд гэж байгаа юм шиг байна. Энийг яг жигд гэж байна уу, эсвэл зарим хэсэг дээр нь магадгүй 15, зарим дээр нь бол хасъя ч гэсэн хасахад тун

хүндрэлтэй, эрсдэл өндөртэй бас асуудлууд байгаа. Энэ дээр яг ямар юу барьж байгаа вэ гэдгийг бас тодруулж асуумаар байна.

Яг өнөөдрийн байдлаар боловсрол, эрүүл мэнд, ахмад гэдэг дээр яг хэд хэдэн хувиар ингээд шийдье гэдэг юм яриад байгаа юм бэ. Сайд нар бол ингээд үйлдвэрчний эвлэлийнхэнтэй уулзахдаа ч гэдэг юм уу 1 тоо хэлээд байгаа. Тэгээд энэ дээр Засгийн газар дээр баталгаажсан зүйл байна уу. Шийдсэн зүйл байна уу гэдгийг бол тодруулж асуумаар байна.

Дараагийн асуудал нь хөрөнгө оруулалтаас ерөөсөө хасахгүй гээд тэврээд хэвтчихсэн. Хөрөнгө оруулалт гээд. Яах вэ, эдийн засаг гайгүй, энэ төсвийн олон хүмүүсийн бодит амьжиргааг нэмэгдүүлэх, сайжруулах гэдэг ийм санал шаардлагууд маань харьцангуй гайгүй байсан бол би бол ойлгож байгаа. Өшөө ч хөрөнгө оруулалт дээр олон зүйлүүд байгаа. Тийм учраас энэ хөрөнгө оруулалтуудаасаа уг нь бол би Засгийн газрыг урсгал зардалтайгаа ижилхэн 10 хувь гэж хасаж оруулж ирээд, тэгээд энэ асуудлуудаа шийдэхэд энэ эх үүсвэрүүдээ тавьчхаач гэсэн чинь өөрөө ол. Хэнээс ямар хөрөнгө оруулалтыг хаанаас хасахаа өөрөө ол гэдэг байдлаар хариу өгсөн. Тэгээд би өөрөө олж байна гэдэг байдлаар тавьсан чинь эхнээсээ авхуулаад манай гишүүд миний ч тойргийн юм, миний ч тийм байшин, миний ч сайдын багцын тийм тоног төхөөрөмж, энэ ч чухал гээд сүүлдээ дайсан болж хувирах л юм болчих гээд байна л даа. Уг нь бол энэ Засгийн газрын хийх ёстой ажил. Тэгэхээр засаг өөрөө энийгээ татаж аваад, хөрөнгө оруулалтынхаа тэр чухал юугаар нь эрэмбэлээд, жигд тэр санхүүжилтээс нь 10 хувь гэдэг бол харьцангуй гайгүй шүү дээ. 100 хувь хасуулах, 50 хувь хасуулах гээд дараа дараагийн зарчмын зөрүүтэй саналууд маш олон саналууд байгаад байна. Тэгэхээр гишүүдийг ийм эвгүй байдалд оруулах гэхээсээ илүү засаг өөрөө зохицуулчихвал яасан юм бэ. Ийм боломж нь байвал тун чухал байна.

Тийм учраас энийг би бас тодруулж асууя. Тэгээд би өглөө Өргөдлийн байнгын хороо дээр санал хураалгасан. Тэгээд тэр зарим гадаад, дотоодын цэрэг, хууль хүчний байгууллагын гээд бас чухал тэр янз янзын саналууд хүн болгон л тийм саналууд хэлж байна. Тэр Коп эд нар гээд байж байгаа тэр зарим зүйлүүдийг нь хувийн хэвшлээрээ хийлгэж болдоггүй юм уу. Бид нар 200 тэрбум төгрөгөөр цэцэрлэгт хүрээлэнд түр зуурын байшин бариад, тэгээд буцаагаад тэрийгээ яах юм. Яг ний нуугүй хэлэхэд нөгөө Асем гэдэг шиг юм болчих юм биш биз дээ гэдэг дээр. НҮБ-ын чухал хурал стандартын байх ёстой гэдэг нь бол чухал. Гэхдээ энийг хувийн хэвшлийн байгууллагууд нь бариад, тэрийгээ өөрөө өмчилж аваад, тэрийгээ дараа нь тэр банкнаас зээл авч барьдаг юм уу, яадаг юм нөгөө яриад байдаг жинхэнэ төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг юмаараа хийчхэж болохгүй байгаа юм уу. Заавал хүрч ядаж байгаа төсөв дээр оруулж ирээд ингээд ацан шалаанд хийгээд суучихсан. Гадаадын олон гишүүд ирнэ гээд ингээд суучихсан энэ тэр асуудлууд байгаад байгаа юм. Жишээ татуулна шүү.

Б.Найдалаа: Баярлалаа. Сайд нараас л хариулмаар асуулт байх шиг байна. Наранбаяр сайдаас эхлэх үү. Өөр Эрдэнэбат гишүүн хэнээс асууж байгаа юм. Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Энэ өнгөрсөн энэ 7 хоногийн биш, тэрний өмнөх 7 хоногийн Засгийн газрын хуралдаанаар бол албан ёсоор шийдвэр гаргаад, багш нарын цалинг 20 хувь, үндсэн цалинг шүү дээ нэмье гээд тэрийгээ Улсын Их Хурал дээр саналаа оруулаад, ажлын хэсэг дээр ярилцаад, эх үүсвэрээ ярилцъя гэсэн ийм

шийдвэр гарсан. Тогтоол хэлбэрээр биш, Засгийн газрын тэмдэглэл хэлбэрээр гарах байх.

2 дахь нь бол бас энэ үйлдвэрчний эвлэлийн талтай бас ярилцаад, албан ёсны хэвлэл мэдээллийн өмнө Сангийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Аубакир сайд, ингээд миний бие ингээд уулзаж ярилцах үеэрээ бол мөн энэ 20 хувь дээр нэмэх нь ирэх жилийн 7 сарын 1-ээс бол ахиж 10 хувь нэмээд нийтдээ 30 хувь гэсэн ийм саналыг бол тавьсан. Үүний мөнгөн дүн нь болохоороо зөвхөн 20 хувь дээр гэхэд 2026 оны 1 сарын 1-ээс 509,9 тэрбум төгрөг нэмэлтээр хэрэгтэй. Тэгээд 7 сарын 1-ээс дахиж 10 хувь нэмэхэд 196 тэрбум хэрэгтэй. Ингээд нийтдээ нэмээд явах юм бол ганц 2 юу яагаад ингэхэд яг 2 сая төгрөгийн үндсэн цалин руу орохоор ийм нөхцөл байдал дээр байна. Эх үүсвэрийг нь бол Төсвийн байнгын хороо, ажлын хэсгүүд дээр ярилцаж байна. Нэлээн хүнд. Та бүхэнд бол Сангийн сайдын хэлснийг та бүхэн санаж байгаа байх. Тийм ээ. Төрийн бүхий л байгууллагууд, төсөвт байгууллагуудын үйл ажиллагааных нь зардлаас нь бол 10 хувиар бууруулж, үйл ажиллагааг нь, заримыг нь зогсоох. Төрийн тэргүүнээсээ эхлээд жирийн байгууллагууд бүгд л энэ эрх тэгш хасацгаана гэсэн ийм л юм яригдаж байгаа юм. Ийм нөхцөл байдалтай байгаа. Тэгээд өнөөдрийн бас багш нарын шаардаад байгаа үндсэн цалингаа 3,5 сая төгрөгийг бол бид хэлээд байгаа. Өнөөдрийн яг энэ цалин чинь өөрөө бүтэц нь 50/50-тай болчихоод байна. Үндсэн цалин нь 50 хувьтай нэмэгдэл, нэмэлт хөлснүүдээ нийлүүлэхээр тэр нь 50 хувь болоод, дунджаар нь аваад үзэхэд шүү дээ. Эндээсээ ингээд бодохоор хэрвээ 3,5 дээр очоод, өнөөгийн бүтцээр явах юм бол 7 сая руу орно. Ер нь бол яаж ч бодсон тэгэхээр ийм нөхцөл байдлыг бид дийлэх үү, үгүй юу гэдэг ийм нөхцөл байдалтай байгаа.

Тэгэхээр бид бол аль болохоор богино хугацаанд хүрэхийг зорино. 3,5 саяд хүргэхээр ингэж бас ярилцаж байгаа. Тэгээд энэ цалин хөлсний асуудал зөвхөн салбарын асуудал биш байдаг юм шүү. Салбар салбарын сайд нар нь гэж яриад байна. Энэ бас тийм буруу ойлголт өгнө. Энэ чинь Сангийн яамтайгаа, Эдийн засаг, хөгжлийн яамтайгаа салбар дамнасан макро эдийн засагтай холбоотой асуудал шүү. Энийг бас Улсын Их Хурлын гишүүд маань зөвөөр ойлгоосой гэж хүсэж байна.

Б.Найдалаа: Баярлалаа. Эрдэнэбат гишүүний асуулт их зөв. Одоо бид нар өнөөдөр хэлэлцэх энэ асуудал дээр зарчмын зөрүүтэй санал хэлэлцэнэ. Тэгээд зарчмын зөрүүтэй санал бол бодлогын шийдэл ердөөсөө биш. Зөвхөн гаргасан алдааг, тухайн эндүүрлийг тухайн үед нь богино хугацаанд засдаг залруулгын шинжтэй болохоос биш бодлогын шинжтэй асуудлыг шийддэг зүйл биш. Тийм болохоор өнөөдөр бол яг үнэндээ бас яг бодлогын асуудлыг зарчмын зөрүүтэй саналаар шийдэх гэсэн оролдлогууд байгаад байгаа юм. Энэ бол тэгэхдээ биш байгаа. Саяын асуулт бол маш зөв асуулт. Тэгэхдээ энэ бол Ерөнхий сайд л жинхэнэ хариулмаар асуулт байна. Яах вэ, ямар ч байсан Сангийн яамнаас хариултыг нь авъя. Яг Сангийн яам хуваарилж байгаа боловч яг бодлогын чанартай асуудлуудаа эрэмбэлэх бол Ерөнхий сайдын ажил. Тэгэхээр Сангийн яам зүгээр энэ дээр ямар байр суурьтай байгаа юм гишүүний асуултад хариулаарай. Микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 24 хувь гэдэг бол нөгөө төлөвлөгөөнд бол орчихсон байсан. Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд. Хэрвээ бид нар тэрийгээ эвдээд орчих юм бол нөгөө Их Хурал дээр санал хураахаар тэндээ нийцээгүй байна гээд буцчих байсан. Тэгэхээр тэрийг барьчихаж байгаа 1-д.

2 дугаарт яг цаад агуулга нь бол юу вэ гэхээр ерөөсөө л орлогын л асуудал. Бид нар орлогоо яаж нэмэх вэ л гэдэг асуудал. Бид нар зээл аваад цалин тавьж болдоггүй, тэтгэвэр тавьж болдоггүй ийм хуультай улс. Тэгэхээр бид нар орлогоо яаж нэмэх вэ л гэдэг асуудал болчихож байгаа юм. Одоо бол Улсын Их Хурал дээр ярьж байгаа асуудал нь юуны талаар ярьж байна вэ гэхээр одоо байгаа зарлага дотроо дахиад яаж шилжүүлж болох вэ гэдэг асуудал л ярьж байгаа. Сангийн яамны хувьд бол яг Төсвийн байнгын хороо дээр гарч байгаа бүх байдлаар нь төсвөө задалж танилцуулж байгаа. Жишээ нь урсгал зардлын хувьд төрийн албан хаагчдын цалин хөлс бол нийтдээ 7,4 их наяд байна. Нийгмийн даатгалын сангийн зарлага 6,4 байна. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 2,2 байна гэх мэтээр бүх бүтцээр нь ингээд задлаад үзүүлчхэж байгаа юм.

Б.Найдалаа: Эрдэнэбат гишүүн тодруулах уу. Болсон уу. Эрдэнэбат гишүүн тодруулаад асуучих.

С.Эрдэнэбат: Тэгэхээр яах вэ энэ чинь та хэдийг өөрсдийг чинь асуудал шийдэхэд л мухардуулаад байна л даа. Тэгээд 24 хувь байгаад байгаа учраас бид нар нэмж болохгүй байна гэж яриад байна. Тэгэнгүүтээ энийгээ 24-өө өөрчлөөд оруулаад ирээч гэхээр Их Хурал баталчихсан болохгүй гээд нөгөө талд нь яриад байгаа юм. Их Хурлын гишүүд бол энийг өөрчилье л гэж байгаа шүү дээ. Гол нь асуудал шийдэх юм нь хаанаасаа орж ирэх вэ гэхээр өндөг анхдагч уу, тахиа анхдагч уу гэдэг шиг Засгийн газар нь оруулаад ирэх төсөв санхүүтэй холбоотой асуудлыг бол Засгийн газар өөрөө оруулж ирэх хуультай. Их Хурлын гишүүд бол хязгаарлагдмал. Тийм учраас энийг Ерөнхий сайд өөрөө хэлсэн шүү дээ. 24 хувь гэж байгаа дээрээ бид нар бас эргэж авч үзье. Их Хуралтайгаа ярьж байгаад саналаа оруулаад, Их Хурал өөрөө дэмжих юм бол бид нар нэмэлт зардлуудаа хийгээд, тэр зарим нэгэн нэмэлт орлого олох боломж байна гээд сая түрүүн танилцуулгад орж ирж байна лээ. Уул уурхайн орлогуудыг оруулж ирээд тавья гээд. Тэгэхээр тэр боломжоо ашиглахгүй юм уу. Түүнээс биш гишүүдээр ингээд та та тунгаа хийлгээд, тэрийг нь хас, энийг нь хас гэхээр хүндрэл биш үү л гэдгийг би хэлээд байгаа юм.

Б.Найдалаа: Энэ асуулт уу. Үг үү. Хариулт хэрэгтэй юу. Санжаадорж дарга индрийн микрофон.

М.Санжаадорж: Санжаадорж Сангийн яам. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ер нь бол бид нар зардлын хэрэгцээ шаардлага бол асар их өндөр байгаад байгаа шүү дээ. Хөрөнгө оруулалт гэхэд 14 их наядын хүсэлт байгаад байна. Ирэх жил хэрэгжүүлэх шинэ хөтөлбөрүүд. Гэтэл бид нар шинэ, хуучин нь нийлээд 3,2 их наяд дотор энийг багтааж байгаа юм. Урсгал зардлын хувьд бол хүсэл нь бол тэрнээс дутуугүй маш их байгаад байгаа. Тэгэхээр энэ бүх зүйлүүд чинь бүгдээрээ нөгөө хуулиар хязгаарлачихсан учраас бид нар нэг талдаа зарлага талаа ингээд хуульчлаад байгаад байгаа боловч орлого талаа бид нар яаж дэмжих вэ гэдэг л асуудлыг бид нар том утгаар нь харах хэрэгтэй болчихоод байгаа юм. Орлогоо дэмжээд гараад ирэх юм бол нөгөө талдаа бид нар цалин хөлсөө ч нэмэх боломжтой болно. Тэтгэврээ ч нэмэх боломжтой болно. Ийм зүйлүүд бол гарч байгаа. Тэгээд мэдээж хэрэг Сангийн яам бол орлогоо нэмэх дээр ажиллаж байгаа. Нөгөө талдаа тэгэхдээ ирэх жилийн төсвийн нэг онцлог нь хувийн хэвшлээ дэмжинэ гэдэг ийм нэг бодлого бас орж ирчхээд байгаа. Тэгэхээр төрийн зарлагаа аль болох бага байж байгаад хувийн хэвшилдээ хүү багатай зээлийн олдцыг нэмэгдүүлэх..../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Гэхдээ ер нь зүгээр юу яагаад байгаа юм. Дахиад хэлэхэд бид нар цаашдаа олон асуудал дээр гарч байгаа болохоор энэ бол бодлогын асуудал. Бодлогын асуудал бол Засгийн газрын асуудал. Одоо жишээлбэл төсвөө боогоод, өргөн барьчихсан гэдэг чинь аль хэдийн бодлогоо тодорхойлоод баталчихсан гэсэн үг. Тэрийгээ Их Хурлаар батлуулах гэж байгаа болохоос биш одоо бид нар нэгэнт ингээд өргөн барьчихсан төсөв дээр зарчмын зөрүүтэй саналаар дамжуулаад бодлогын чанартай өөрчлөлт хийх ер нь бол боломжгүй. Яах вэ яг үнэндээ Монгол Улс, бид нар ийм байдалд орчихсон нь харамсалтай байгаа. Цаашдаа харин зүгээр бодлогынхоо чиглэлээр Засгийн газар бүтцийн болон хандлагын, үзэл санааны өөрчлөлт хийхгүй бол юу ч өөрчлөгдөхгүй гэж үзэж байгаа юм.

Алтаншагай гишүүн асуулт асууна.

Н.Алтаншагай: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тодруулах хэдэн зүйлүүд байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд байна уу. Сайдаас асууна. Боловсролын сайдаас асууна. Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаас асууна.

Багш нарын ажил хаялт 2025 оны 10 сарын 16-нд эхэлсэн. Өнөөдөр 6 дахь өдөр явж байгаа. Ажил хаялт яг албан ёсоор зогссон юм уу. Шийдэлд хүрсэн юм уу. Үйлдвэрчний эвлэлтэйгээ уулзалт хийж байсан. Энийгээ цэгцэлж нэг талдаа гарахгүй бол энийг дагасан нийгэм, эдийн засгийн хүндрэлүүд бий болж байна шүү. Олон багш нар ажил хаячихсан. Үүнтэй холбогдуулаад хүүхдүүдээ харах хүн байхгүй гээд аав, ээжүүд маань цалинтай чөлөө аваад, цалингүй чөлөө аваад ингээд хүүхдүүдээ харж байгаа асуудал байна. Үүнийг дагасан бас эрсдэлүүд байна. Үнэхээр ажлын байран дээр байх шаардлагатай аав ээжүүд маань хүүхдүүдээ гэртээ түгжээд явж байна гэж байгаа. Энийг дагасан эрсдэл үүсэх магадлал маш өндөр байна. Боловсролын салбар энэ ажил хаялтаас улбаалаад боловсон хүчнээ алдах бас эрсдэл үүсэж байна. Энэ хэлэлцээрүүд амжилтгүй болох юм бол энэ багш нар чинь өөр ажлын байранд шилжинэ гэсэн ийм юмнууд яригдаад эхэлчихсэн байна шүү дээ. Цэцэрлэгийн багш нар, сургуулийн багш нар. Энэ дээрээ яаралтай арга хэмжээ авч, энэ дээр томоохон шийдэл гаргахгүй бол хүндрэл үүсэж байгаа юм.

Дараагийнх нь асуудал хоолны мөнгөний асуудал үүсэх юм байна. Өдрийн 1000 төгрөгөөр гээд аав ээж нь бас зөрүү төлж байгаа. Одоо энэ ажил хаячихсан, хийдэлтэй байгаа үеийг нь эцэг эхчүүд нь мөнгийг нь төлөх юм уу. Багш нар нь төлөх юм уу. Төр төлөх юм уу. Энэ дээр хариулт авмаар байна.

Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаас асууя. Соёл урлагийн, биеийн тамирын спортын салбарын цалин ингээд нэмэгдэхгүй үлдэж байна гэж ойлгож байгаа. Эрхээ хамгаалдаг, тэмцдэг, дуу хоолойгоо хүргэдэг нь ингээд нэмүүлж байгаа байхгүй юу. Боловсрол, эрүүл мэндийнх. Төрийн захиргааны төв байгууллага нь бас яг ингээд л дагаад үлдэж байгаа юм. Хараад л үлдэж байгаа. Ингээд дуу шуутай, хэрүүл шуугиан хийж чаддаг нь нэмүүлээд, дуугай ажлаа хийгээд явж байгаа ажлын байран дээр яг ингээд байж байгаа нөхөд маань ингээд хохироод үлдэж байгаа ийм юм байгаа юм. Тэгэхээр энэ соёл урлаг, биеийн тамир спортын салбар бас томоохон салбар шүү. Энэ нөхцөл байдлыг маш сайн мэднэ. Энэ биеийн тамирын багш, дасгалжуулагч, соёл урлагийн энэ сум орон нутагт байгаа театрын, соёлын төвийн хүмүүс ингээд л үлдэж байгаа юм. Бодлого жигд л явах ёстой.

Дээр нь энэ тэтгэврийн доод хэмжээг нь нэмэгдүүлэх тал дээр дорвитойхон бодлого гаргамаар юм билээ. Жагсаал хийхээр нь, хэрүүл шуугиан үүсэхээр нь л 6 хувь, 8 хувь гээд яриад байдаг. Энийг ерөнхийдөө болимоор байгаа юм. Доод хэмжээгээ нэмээд өгвөл шатлалтай нь нэмж өгөх хэрэгтэй. Энэ дээр.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллаас тодруулах зүйл байгаа. Энэ төсвийн төсөл дээр орж ирсэн байсан. Ажлын байрыг нэмэгдүүлнэ гээд. Төр бол өөрөө ажил олгогч биш шүү. Явж явж яг ажил олгогч хувийн хэвшил рүү л шилждэг. Тэгэхээр энэ дээрээ бид нар татварын, нийгмийн даатгалын, аж ахуйн нэгжийн албан татвартай холбоотой яг шинэчлэлийг нь хийж өгөхгүй бол яагаад ч энэ урагшаагаа явахгүй. Жил болгон л цалин, тэтгэврээ тойрч ярьсаар л байх болно. Иргэдийн маань орлого нэмэгдэхгүй. Ажилтай болж чадахгүй. Тэгэхээр энэ дээрээ шийдлүүдийг гаргаж явахгүй бол ерөөсөө болохгүй. Тодруулж асууна.

Б.Найдалаа: Хариултыг Боловсролын яам. Микрофон 5.

Х.Батжаргал: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын яам Батжаргал. Тэгэхээр 2025 оны 10 сарын 17-нд ажил хаялт эхэлсэн өдрөөс эхлээд Боловсролын яамны зүгээс Боловсрол, шинжлэх ухаан үйлдвэрчний эвлэлтэйгээ яриа, хэлэлцээрийг эхлүүлэх, мөн түүнчлэн яриа хэлэлцээрийнхээ үр дүнд цалин нэмэгдүүлэх тоонууд дээрээ хамтарч хэлэлцэж байж саналаа ярилцъя гэдэг санал үргэлжилж явж байгаа. Сая Наранбаяр сайдын хэлсэнчлэн өнгөрсөн 7 хоногт холбогдох салбарын сайд нар Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөлтэй уулзаад, ингээд дараагийн хэлэлцээрт шилжиж эхэлж байгаа. Өөрөөр хэлэх юм бол одоо яг энэ мөчид Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн тэргүүлэгчдийн хурал болж байна. Эндээс бас яг хэлэлцээрт салбарын гаргасан ажлын хэсгийн хэлэлцээрт яг хэн хэн, ямар нэр бүхий албан тушаалтан оруулах вэ гэдгээ гаргаж өгч байна. Тэгэхээр үүний дараа шууд өнөөдрөөс хэлэлцээр үргэлжлээд, үндсэндээ бол тоо, тооцоолол бол бидний зүгээс гаргасан байгаа. Тоо, тооцоолол гэдэг маань цалин хөлсийг нэмэгдүүлэх, энэ яригдаад байгаа 20 хувь, түүний дагасан эх үүсвэрүүдийг бид нар бас Төсвийн байнгын хороонд тооцоолол, бас гаргасан үр дүнгээ, хэлэлцээрийнхээ үр дүнг бас хүргүүлэх ёстой байгаа. Гаргасан үр дүн дээрээ бас үүнийг дагаад энэ хэлэлцээрийн бас нэг тулгамдаж байгаа асуудал бол ажил хаяснаас хойших албан хаагчдын цалин хөлсний асуудал яригдаж байгаа. Холбогдох хууль тогтоомжийнхоо хүрээнд бол бас олговрын асуудал бас яригддаг. Энийг хэлэлцээрийн хүрээнд бас хамтран шийдэж тогтдог. Энэ тоон дээрээ бас нийлдэг ийм тогтолцоотой. Тэгээд энийг бас яаралтай эхлүүлэх ийм шаардлага байгаагийн үндсэн дээр бол бид эхлүүлж байгаа энэ яриа, хэлэлцээрийг.

Хүүхдийн хоолны асуудал, ялангуяа Улаанбаатар хотын цэцэрлэгийн хүүхдүүдийн хоол дээр бол эцэг эхчүүдээс өнгөрсөн жилээс 1000 төгрөгийн дэмжлэг авдаг. Үүнээс улбаалж эцэг эхчүүдийн санхүүгийн ирц болон санхүү дээр тавьж байгаа хяналт бол эрс сайжирсан. Үүнийг дагасан бас хэмнэлт ч явдаг. Тэгэхээр энэ өөрөө хүүхдүүдийн ирц дээр тулгуурлаж явдаг учраас ирээгүй, ажил хаялтын явцад бол ямар нэгэн тийм хүндрэл бэрхшээл төсөв дээр ч юм уу гарахгүй гэсэн үг. Мэдээж их цэцэрлэгийн хүүхдүүд хэрвээ ирээгүй бол тэр зардал бол төсөв дээр хэмнэгдээд явна.

Б.Найдалаа: Алтаншагай гишүүн тодруулна. Ундрaм сайд хариулъя.

Ч.Ундрaм: Мэдээж манай соёл, спортын салбарын ажилчдын цалин бол нэлээд доогуур байгаа. Тэгээд энийг боломжтой бол салбарын сайдын хувьд нэмүүлэх чин хүсэлтэй байгаа. Тэгээд одоогийн яригдаж байгаа шийдэл нь бол бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаас 10 хувь хасаад, тэгээд эрүүл мэнд, боловсрол болон ахмадын тэтгэврийг нэмнэ гэсэн ийм шийдэл яригдаж байгаа. Энэ нь бол манай салбарын хувьд нэлээн аюултай ийм үр дагавартай. 2026 оны манай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт урсгал зардлыг 331,1 тэрбум төгрөгөөр Улсын Их Хуралд өргөн барьсан байгаа. Тэгээд манай энэ багцад соёлын 452, спортын 33, нийт 485 байгууллагын 7684 албан хаагч байгаа. Энэ хүмүүсийн.../минут дуусав/

Б.Найдалаа: Минут нэмж өгье.

Ч.Ундрaм: Урсгал зардлаас 10 хувь хасагдчих юм бол энэ хүмүүсийн цалингаас хасагдаж таарах гээд байгаа юм. Тэгэхээр энэ шийдэл бол манай салбар дээр ерөөсөө боломжгүй болчхоод байгаа юм. Нийт бараг энэ чинь 10 хувийг нь хасах хасах юм бол зарим соёлын төвүүд чинь 3-5 албан хаагчтай байгаа шүү дээ. Бараг 100-аад соёлын төвийн бүх албан хаагчдын цалинг нь хасаж байгаа юм шиг ийм хэмжээний үр дагавартай.

Б.Найдалаа: Алтаншагай гишүүн тодруулъя.

Н.Алтаншагай: Энэ юуг Сангийн яамныхан хариулах ёстой доо. Энэ татварын реформууд, аж ахуйн нэгжүүд дээрх дэмжлэгийг би асуусан даа.

Б.Найдалаа: Сангийн яам. Индрийн микрофон.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн. Татварын хуулийн шинэчлэлийн хувьд Хууль тогтоомжийн тухай хуульд 5 сард орсон өөрчлөлтийн дагуу Татварын хууль тогтоомжийг 60 хоногийн хугацаанд хэлэлцүүлэх, дээрээс нь Улсын Ерөнхий прокурор, Дээд шүүх гээд олон газраас санал авах ийм процесс нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор хууль өргөн мэдүүлэх бэлтгэл ажлууд хангагдаад, олон нийтийн хэлэлцүүлгүүд явагдаж байгаа. Яг энэ цаг үед legalinfo цахим хуудсан дээр Татварын хуулийн төслүүд олон нийтэд тавигдан, санал авах ажиллагаанууд явж байгаа.

Энэ хуулийн төслөөр гол том зорилгуудын нэг нь бол татвар төлөгчдөд учирч байгаа татварын хүндрэлтэй байдлуудыг шийдвэрлэх, иргэд, аж ахуйн нэгжүүдийн татварын ачааллыг шаталсан хэлбэрээр тодорхой хэмжээнд бууруулах гэсэн ийм тодорхой зорилтуудыг тусгасан хуулийн төслүүд бол хэлэлцүүлэгдэж байгаа.

Б.Найдалаа: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас хариулт. Микрофон 3.

Л.Мөнхзул: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Хэд хэдэн чухал асуудалд хөндлөө. 1 дүгээрт тэтгэврийн доод хэмжээг нэг ижил түвшинд бага барьж байгаа нь бас бодлого дээрээ анхаараач гээд. Ер нь бол зүйтэй санал. Учир нь гэвэл тэтгэврийн доод хэмжээ авч байгаа иргэдийн хувьд ажилласан хугацааны ялгаа бага болчхоод байгаа юм. 20 жил ч ажилласан, 30 жил ч ажилласан ижилхэн хэмжээний доод хэмжээ аваад байгаа. Үндсэн шалтгаан юу вэ гэвэл эдгээр хүмүүсийг тэтгэвэр тогтоолгож байгаа үед авч байсан цалин хөлс хэт бага байсантай холбогдолтой. Өнөөдөр Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч

байгаа 543 мянган хүн байна. Энэ хүний хамгийн удаан жил тэтгэвэр авч байгаа нь 1975 онд тэтгэвэр тогтоолгосон хүн байгаа. Тэгээд тухайн үеийн цалин хөлсөөс гэсэн үг. 1995 онд тэтгэвэр тогтоолгосон хүний цалин хөлс бол 1980-аад оныхоор гэх мэт. Тэгэхээр сүүлийн үеийн цалин бол эдийн засгийн өсөлттэй уялдчихсан байдаг.

2 дугаарт жишээлбэл .../минут дуусав/

Б.Найдалаа: Алтаншагай гишүүн тодруулъя. Тэгээд хариултыг нь гүйцээгээд авчихъя.

Н.Алтаншагай: Энэ хэсгийн ахлагч гэж бас дуулиан шуугиан болоод л. Хэсгийн ахлагч гэж задарсан хүмүүс байдаггүй юм шүү дээ. 3 жилийн өмнө л 600 мянган төгрөгийн урамшуулал авч ажиллаж байсан. Төрийн ажлыг анхан шатад гүйцэтгэж байсан. Улаанбаатар хотод 9 дүүрэгтэй, 240 хороотой. Энэ дээр 513 мянга орчим өрхөд 1915 хэсгийн ахлагч төрийн анхан шатын үйлчилгээг үзүүлж байгаа. Мэдээ мэдээллээр хангаж, энэ хүчирхийлэлтэй холбоотой олон асуудлуудыг газар дээр нь явж, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, төр иргэнийг холбосон яг гүүр нь болж ажиллаж байгаа энэ хэсгийн ахлагч нарыг бас ад шоо үзээд байгаа юм. Энгийг хөдөлмөр, нийгмийн хамгаалал анхааралдаа авч, төрийн үйлчилгээний ангилалд оруулж, энэ цалингийн системд оруулж өгөх нь бас зохимжтой байх. Энэ бол улсын төсөв дээр ямар нэгэн дарамт үзүүлээд байгаа юм бол .../минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Саяын ярьж байгаатай холбоотой түрүүн Ундрам сайдын хэлж байгаа бас зүйтэй байгаад байгаа юм. Жишээлбэл нөгөө бодлого байхгүй гээд яриад байгаа энэ л дээ. Эмч,багш нарын цалин, ахмадуудын тэтгэврийг жагсахаар нь ямар нэгэн байдлаар нэмчхэж байгаа хэр нь цаана нь нөгөө соёл урлагийн салбар орхигдсон байж таарч байгаа байхгүй юу. 1 цонхоор ер нь цалин хөлсний бодлогоо эргэж Засгийн газар харахгүй бол нэг мэдсэн чинь бүр эсрэгээрээ хасагдах болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд яах юм нэмэхийн тулд жагсах ёстой юм уу гэдэг ийм ойлгомжгүй байдал үүсчхээд байгаа юм. Тийм болохоор л төсөв ирэх жилийг тойрч биш, ирэх 4-5 жилийг тойрч бодлогоо гарга л гээд байгаа юм. Дараагийн гишүүн асуулт асуух гишүүн Батнайрамдал.

О.Батнайрамдал: Тэгээд олон хоног жагссаны дараа багш, эмч нарын цалин, ахмадын тэтгэврээ 5-15, 20 хувь нэмэгдүүлэх гэж байх шиг байна. Нийт бол 830 тэрбум төгрөгийн төсөв шаардлагатай гэж байгаа юм. Энэ дээр бас нэг жишээ хэлье л дээ.

830 тэрбум гэдэг нь өнөөдөр бид нар Рио Тинто компаниас Оюутолгой компанийн 6 тэрбум долларын зээлд 3 сард төлж байгаа хүүтэй л дүйцэхүйц хэмжээний мөнгө байгаа юм. Өдөрт бид нар 10 тэрбум төгрөг Оюутолгойгоос Рио Тинто компанид зүгээр 6 тэрбум олон жилийн өмнө авсан зээлдээ өдөр бүр төлж байгаа. Энгийг хар даа. Энгийн жишээтэй би харьцуулъя. Бүгдээрээ Оюутолгойг Эрдэнэт үйлдвэртэй харьцуулдаг. Эрдэнэт үйлдвэр дээр өдөр бүр 7 мянган залуучууд ажиллан байж өдөрт 11 тэрбум төгрөгийн орлого олдог юм шүү дээ. 7 мянган залуучуудын хөлс хөдөлмөрөөр “Эрдэнэт үйлдвэр” дээр өдөрт олж байгаа 11 орчим тэрбум төгрөг Оюутолгойгоос Рио Тинтод явж байгаа зээлийн хүүд л явчхаж байна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр ийм суурь асуудлуудаа бид нар шийдэхгүйгээр жил болгон л хэдэн багш, эмч нараа гадаа жагсаасан ийм л чөтгөрийн тойргоосоо гарахгүй л байгаа юм л даа.

Тэгээд дөнгөж 7 хоногийн өмнө олон улсын бас веб сайт дээр гарсан байна. Америкийн хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын сан, нөгөө Pentwater гээд хөрөнгө оруулалтын сан Оюутолгойгийн 66 хувийг тухайн үедээ эзэмшдэг байсан. Turquoise Hill гээд Нью-Йоркийн хөрөнгийн бирж дээр гарсан компани Рио Тинто-г шүүхдээд, далд уурхайн бүтээн байгуулалтын явцад гарсан 1,9 тэрбум долларын нэмэлт зардал, 30 орчим сараар хойшлуулсан нь буцаад хөрөнгө оруулагчдыг төөрөгдүүлсэн алдаа байсан гэдгээ нэг ёсондоо хүлээн зөвшөөрч 138 сая доллар буюу 500 тэрбумыг төлөх эцсийн шийдвэр нь гарч байгаа юм байна. Америкийн хөрөнгө оруулагчид Рио Тинтогийн менежментийн алдаанаас болсон, мэдээллээ цаг тухайд нь хөрөнгө оруулагчдад буруу мэдээлсэн гэдэг агуулгаар шүүхдээд ялж байна. Гэтэл өнөөдөр Рио Тинтогийн маш өндөр менежментийн зардал төлж бид нар менежментийн 1,9 тэрбум доллароор хэтэрсэн зардал дээр бид нар хүүтэй нь төлдөг юм шүү дээ. Хүүтэй нь төлж байгаа. Нийлмэл хүүгийн хүү тооцсоор байгаад өдөрт 10 тэрбум долларын хүү болтол ийм байдалтай л бид нар явж байгаа юм. Тэгэхээр дараагийн 7 хоног хэлэлцээрт орж байгаа Засгийн газар энэ асуудлыг тэр чигээр нь ер нь шийдэх ёстой. Гадаа жагсаад зогсож байгаа багш нар, сувилагчид, эмч нар, тэтгэврийн ахмадууд, Монголчууд бид нар бүгдээрээ Монгол Улсын Засгийн газар Рио Тинтотой хэлэлцээрт орж байгаа энэ үйл явцыг нүд цавчилгүй харах ёстой шүү. Монгол Улсын эрх ашгийг 1 дүгээрт тавьж, хэлэлцээр дээр бид нар Монгол улсад ашигтай шийдвэр гарах нь уу. Эсвэл 10 жилийн дараа дараагийн Батнайрамдал дахиад л нэг Хянан шалгах түр хороо байгуулаад, асуудал үүсгэх нь үү. Тэгэхээр энэ дээр энэ удаагийн хэлэлцээр 3,5 сая иргэн илүү мэдээлжсэн, бүгдээрээ нүд цавчилгүй харж байгаа энэ үед явж байгаа. Тийм учраас улс төрийн ямар ч шуурган дундуур явж болно. Ард түмэн минь та нар бүгдээрээ энэ дараагийн 7 хоногоос эхлэх Рио Тинтогийн Засгийн газартай хийх хэлэлцээр дээр нүд цавчилгүй ширтэх ёстой шүү. Үр дүнг нь бид нар шууд харах ёстой. Монгол Улсын эрх ашиг энэ дээр хангагдах нь уу, бүгдээрээ харах ёстой. Энэ дээр бизнесийн шударга зарчмаар харилцан ашигтай байх зарчим хөндөгдөх нь үү. 2009 онд Рио Тинто Монгол Улсад амлаж байсан тэр задарсан амлалт буцаад биелэх нь үү. Энийг нүд цавчилгүй бүгдээрээ харах ёстой шүү л гэж хэлмээр байна.

Б.Найдалаа: Үг хэллээ. Баярлалаа. Ганмаа гишүүн асуулт асууна.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу. Хэдхэн асуулт асуучихъя. Энэ төсөвтэй холбоотой эрүүл мэндийн бодлого, удирдлагын чиглэлээр 1 дүгээрт. Урсгал зардалтай холбоотой.

Бид нарт өгсөн энэ номын 48 дугаар хуудас дээр хэд хэдэн юмнууд байна л даа. Би бодлого асуудаг шүү дээ. Үр ашгаа яаж сайжруулах вэ. Санхүүжилтийг нэмэхэд гээд. 1 дүгээрт ийм дүгнэлт гаргасан юм байна.

Төрийн өмчийн эмнэлгүүдийн санхүүгийн сахилга бат сул байгаа гэсэн дүгнэлт гаргачихжээ. Тэгээд би энэ Төрийн аудитын 2024 оны аудитаар харахаар энийг олж хараагүй байхгүй юу. Тэгэхээр энэ аудит дээр ийм дүгнэлт гараагүй байхад энэ төрийн эмнэлгүүдийн яг хэд нь санхүүгийн сахилга бат нь муугийн улмаас хязгаарлагдмал байсан гэсэн ийм дүгнэлт гаргасан бэ. Энэ дээр хариулт авъя. Тэгэх үү.

2 дугаарт хэрвээ миний тэр харснаар аудитын ийм дүгнэлт байхгүй байгаа нь үнэ үнэн бол би олоогүй байж магадгүй. Үнэн бол яг ямар үнэлгээ, ямар хяналт, ямар шалгалт дээр үндэслээд энэ төрийн эмнэлгийн санхүүгийн сахилга бат нь муу байна гэж дүгнээд байгаа вэ. Төрийн эмнэлгүүдийн санхүүгийн сахилга бат сул

байгаагаас шалтгаалан үр ашиггүй зардал, өр төлбөр нэмэгдэж байна гэж яг дүгнэсэн байгаа байхгүй юу. Төсвийнхөө ном дээр. Гэтэл энэ Эрүүл мэндийн даатгалын сангаас олсон орлогоо юунд зарцуулагддаг вэ гэдэг дээр судалсан юм байгаа юу. Категориор нь. Эхлээд энэ асуултдаа хариулт авчихъя.

Б.Найдалаа: Хариулт. Индрийн микрофон.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж. Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол маш товчхондоо хэлэх юм бол манай улсын төсөв ч гэсэн орлого нь зарлагатайгаа ингээд дүйцэж байж, олж байгаа орлогодоо нийцүүлж зарлагаа гаргах ийм асуудал байгаад байгаа. Эмнэлгүүдийн хувьд ямар асуудал байгаад байна гэхээр 1 дүгээрт засаглалын хувьд бид нар хагас автономи руу шилжүүлсэн. Өөрөөр хэлбэл ТУЗ-тэй болчихсон байх ёстой. ТУЗ нь яах вэ гэхээр захирлыгаа сонгоод, жил бүрээр нь төлөвлөгөөг нь баталж явах ёстой. Хэдэн хүнтэй, ямар бүтэцтэй ажиллах вэ, ямар хэмжээний ажил хийх вэ. Тэр олсон ажлаараа бид нар хэчнээн хүн цалинжуулж чадах вэ гэдэг төлөвлөгөө байх ёстой. Гэхдээ одоогоор Эрүүл мэндийн яам бол энэ хагас автономи руу нь одоо хүртэл шилжүүлж чадахгүй, бүрэн шилжүүлж чадахгүй ингээд яваад байна. Тодорхой хэмжээнд ТУЗ-үүд байгуулагдаад явж байгаа нь үнэн. Гэхдээ ийм байна.

Одоо бид нар нэг талдаа төгсөж орж ирж байгаа эмч нар нэлээд их байна. Нөгөө талдаа бид нар төрийн болон хувийн гэсэн 2 эмнэлэгт энэ хүмүүс орж ирж ажиллаж байна. Тэгэхээр хүний нөөцийн бодлого талдаа бид нар энэ дээр бас алдаа дутагдалтай зүйлүүдээ харах хэрэгтэй болчихоод байгаа юм.

Дараагийн ээлжид бид нар өмнөх байдлаар буюу эдийн засгийн ангиллаар нь эмнэлгийг Сангийн яам дээрээс бүх нэр төрлөөр нь хянаад явдаг байсан энэ үе өнгөрчихсөн байхгүй юу. Одоо эмнэлгүүд яах ёстой вэ гэхлээр аль нь Эрүүл мэндийн даатгалын сангаас ямар хэмжээний санхүүжилт авч болохоор байна. Тэр чиглэл рүүгээ бүтцээ өөрчлөөд явах ёстой. Жишээ нь зарим шаардлагагүй гэж үзсэн, Эрүүл мэндийн даатгалын сангаас ашиг олохгүй байгаа жишээ нь, эмнэлгийн хувьд зүгээр витамин тариулаад хэвтэж байгааг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхгүй асуудал байгаад байгаа. Тэгэхээр энэ дээр хүн аваад байх юм алдагдалтай байгаад байна л гэсэн үг. Нөгөө талдаа эм, эмнэлгийн хэрэгслийн хувьд нөөцөө бүрдүүлэхдээ зохистой хэмжээнд бүрдүүлэх ёстой. Жишээ нь хэт ихийг авч болохгүй, өмнөх шигээ юу гэдэг юм таньдаг хүнээсээ ч байдаг юм уу, эмнэлгээсээ хэт ихээр авчхаад, дараа нь эмнэлгээ алдагдалд оруулаад байж болохгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр одоо эмнэлгүүдийн хувьд яагаад энэ зохицуулалтуудаа хийж чадахгүй байгаад байна гэхээр нөгөө талдаа хариуцлагын гэрээ гэдэг зүйл маань л байхгүй байгаад байгаа.

Сангийн яамнаас энэ зүйл дээр бол Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газартай хамт нийлээд санхүүгийн хувьд болон бүтцийн хувьд бол хяналт шалгалт орсон. Тэгээд тэр дээр дүгнэлт маань ингэж гарсан. Үүнтэй холбоотойгоор төсвийн танилцуулга дээр орсон байгаа гишүүнээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганмаа гишүүн тодруулна.

Д.Ганмаа: Энэ Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбарын хөгжлийн хөтөлбөр 6 гээд төслийн зөвлөх Амаржаргалын төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын төсөв, санхүүгийн байдалд хийсэн дүн шинжилгээ гээд 2025 оны 5 сар гэдэг чинь ерөөсөө саяхных. Энэ дээр харахаар төрийн өмчийн эмнэлгүүд

цалин, нийгмийн даатгалын шимтгэлд дунджаар 60-70 хувийг эм, эмнэлгийн хэрэгсэлд дунджаар 15-50 хувийг зарцуулдаг гээд гарчихжээ. Ингэхээр зөвхөн энэ 2 зардал нь л 80-90 хувийг эзлээд байгаа юм л даа. Үүнтэй холбоотойгоор төрийн өмчийн эмнэлгүүдэд төрийн албан хаагч ажиллаад, төрийн албан хаагчийн цалинд нь сангийн мөнгөө явуулаад, тэгснээрээ эмнэлэг, тусламжийн үйлчилгээ нь доголдоод, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд асуудал үүсээд байгаа нь өөрөө эрүүл үзэгдэл мөн үү, үгүй юу. Энэ дээр Засгийн газар, Сангийн яам хэлэлцэж ярьсан юмнууд байгаа юу, үгүй юу. Саяын миний эхний.../минут дуусав/

Б.Найдалаа: 1 минутаа нэмээд өгье.

Д.Ганмаа: 1 минутаа ашиглаад бас 2 асуулт асуучихъя. Гадаадын зээлийн хөрөнгөөр 17 аймгийн барилгыг шинэчлэх эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, нэн шаардлагатай тоног төхөөрөмж гээд нөгөө хүний хөгжлийн мега төсөл дээр чинь гол оруулж ирж байгаа санхүүжилтийн нэг хэсэг нь энэ. Энийг харахаар зэрэг энэ арга хэмжээний зээлийн хэлэлцээр нь батлагдсан юм уу, үгүй юу. Хэлэлцээр нь батлагдвал санхүүжилт нь хэзээнээс эхэлж явах вэ гэдэг нэг асуулт байна.

2 дахь нь энэ барилга байшинтай холбоотой бас нэг асуулт байгаад байгаа юм. Гадаадын зээлийн хөрөнгөөр 2026 онд шинээр эхлэх төсөл хөтөлбөрүүдийн хэлэлцээрт байгаа юм. Энэ зээлийн хэлэлцээр нь мөн л Улсын Их Хурлаар батлагдсан эсэх. Батлагдаагүй бол хэзээ батлагдах вэ гэдэг ийм 3 асуулт байна.

Б.Найдалаа: Хариулт. Индэр дээр.

М.Санжаадорж: Эрүүл мэндийн байгууллагын хувьд бол төрийн өмчийн эмнэлгүүд дээр бид нар хэд хэдэн өөрчлөлт уг нь хийсэн юм. 1 дүгээрт цалинг доод хэмжээ болгочихсон. Өөрөөр хэлбэл цалингаа нэмэгдүүлэх боломжийг нь гаргаж ирсэн гэсэн үг. Хийсэн ажлаараа, бүтээмжээрээ гэсэн үг.

2 дахь асуудал нь бол бүтцээ өөрөө тогтоох боломжийг нь гаргаад ирчихсэн.

3 дахь асуудал нь бол орон тоогоо өөрсдөө тогтоох боломжийг нь гаргаад ирчихсэн юм байгаа юм. Тэгэхлээр зохистой орон тоогоо уг нь эмнэлэг өөрөө тогтоогоод явах боломжтой болчихоод байгаа юм. Эрүүл мэндийн санхүүжилтийг бид нар хуваарилах аргыг нь бол гүйцэтгэл дээр нь хийчихсэн. Өөрөөр хэлбэл хэдэн хүн эмчилсэн гэдгээр нь өгчхөөд байгаа юм. Харин эмчдээ нөгөө мөнгө нь яаж наалдах вэ гэдэг нь бол дахиад цалин хөлсний шинэ бодлого нь орж ирэх ёстой байгаа юм. Энэ бодлого маань эрүүл мэндийн байгууллагууд дээр байхгүй байгаад байгаа. Тийм учраас эмнэлгүүд яг тухайн үедээ яг эдийн засгийн ангиллаар нь хатуу орон тоог нь тогтоодог байсан үеэрээ хүнээ тооцоод ингээд аваад яваад байгаа учраас энэ алдагдалд орчихоод байгаа юм. Тэрнээс зохистой зүйл рүүгээ орчих, дээр нь ажил хийсэн бол бид нар цалинг нь өгдөг энэ системийг нь дараагийн ээлжид оруулж ирэх хэрэгтэй байгаа юм. Гадаад зээлийг нь..../минут дуусав/

Б.Найдалаа: Гүйцээж хариулна.

Ж.Дэлгэржаргал: Ганмаа гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Ер нь төсвийн хөрөнгө оруулалтуудыг бид нар яг нийт эх үүсвэрээр нь харах шаардлагатай байгаа. Зөвхөн улсын төсвийн хөрөнгө оруулалт бол яг төсвийн хөрөнгө оруулалтын 1 эх үүсвэр. Гадаад зээл, тусламжийн ашиглалт бол бас нөгөө эх үүсвэр байгаа. Тэгэхээр яг энэ 2026 оны төлөвлөлт дээр бид нар хүний

хөгжил, эрүүл мэнд, боловсролын салбар дээр яг эх үүсвэрүүдээ нийт хэрэгцээгээр нь гаргаад, төлөвлөгдсөн болон явж байгаа төслүүдээ гаргаж байж яг улсын төсөв дээрээ аль талаа авч явах уу, гадаад зээл тусламж дээр аль төслүүдээ хэрэгжүүлэх үү гэдэг эрэмбийг боловсрол, эрүүл мэнд, онцгой байдлын салбарт гаргасан. Үүний эрүүл мэндийн салбар бол нийтдээ Азийн хөгжлийн банк дээр 17 аймгийн яаралтай түргэн тусламжийг сайжруулах, бүтээн байгуулалт болон шаардлагатай тоног төхөөрөмж, үүнийг дагаад чадавхжуулах энэ төслийг хэрэгжүүлнэ. Яг төсвийн төслийг өргөн барихдаа хамт зөвшилцөхөөр зээлийн хэлэлцээрийг хүргүүлсэн .../минут дуусав/

Б.Найдалаа: Гүйцээж хариулъя. 1 минут.

Ж.Дэлгэржаргал: Эдийн засгийн байнгын хороо дээр зөвшилцөх асуудлыг дэмжсэн байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Хариулт, тодруулга дууслаа. Зулпхар гишүүнийг асуулт асуух гишүүнд нэмье. Зулпхар гишүүний микрофоныг нээе.

С.Зулпхар: Байнгын хорооны дарга, гишүүд, ажлын хэсгийнхний энэ оройны амар амгаланг айлтгая. Би Байнгын хорооны даргад хандаж, гишүүддээ хандаж бас үг хэлье гэж бодож байна. Уг нь бол дэгээр үг хэлэх зүйл байхгүй боловч бид төсвөө хэлэлцэж байна. Төсөв хэлэлцэж байгаатай холбоотойгоор 3 зүйл дээр анхаарахгүй бол болохоо байж байх шиг байна л гэж бодож байна л даа. Учир юу гэхээр 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх үедээ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тогтвортой байлгана гээд бүр тодорхой заагаад өгчихсөн юм.

Тэр нь яасан гэхээр бид төсөв хэлэлцэхдээ яадаг гэхээр 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр байж байгаа шүү дээ. Засгийн газрын. 5 жилийн чиглэл байгаа. Тэрийгээ суурь болгоно гэсэн үг. Тэрнээс гадуур бид ингээд зарим нэг зүйлийг гэнэт гэнэт оруулж ирэх юм бол энд Хөгжлийн бодлого, төлөвлөлт гэдэг юм 1 дүгээрт байхгүй болно. 2 дугаарт угаасаа алдагдана гэсэн үг. Тэгэхээр энийг та бүхэн сайн анхаараач ээ гэж байгаа юм.

2 дахь зүйл энэ Үндсэн хуультай холбоотой шүү дээ. Үндсэн хууль дээр чинь 2 дахь заалт нь ийм байгаа. Тэр 25.7 дахь хэсэг байхгүй юу. Улсын төсвийг хэлэлцэж батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. 1 дүгээрт. Гэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно гэсэн байгаа. Энэ бол төсвийн сахилга бат. Энэ бол бодлого, төлөвлөлтийн бас зарчим шүү дээ. Тэгэхээр бид үүнээс давсан байдлаар заримдаа их тийм сонин сонин саналууд гаргаад ирлээ. Тэгээд бид энийгээ энэ төсөвтөө яаж багтаах юм. Тэгээд бид өөрсдийгөө хөгжлийн бодлого, төлөвлөлтийг тогтвортой авч явж чадаж байна, чадах ёстой гэж бодож байгаа хүмүүс мөн юм уу, биш юм уу. Энэ чинь их тийм эргэлзээ төрүүлээд байна шүү.

Бид энэ хуулиудыг бүгдийг нь судлаад, хуулиудыг хэрэглэж чаддаг хүмүүс байх ёстой шүү. Би Улсын Их Хурлын гишүүддээ бүр зориуд энийг сануулмаар байна. Ямар хууль байх нь хамаагүй бид уншаад, тэрийг хэрэглэж чаддаг байх ёстой. Тэгж байж бид нар улс төрч болж байгаа. Төрийн улс төрийн албан хаагч нар. Тэгэхгүй тэгээд л бүх зүйлийг хүссэнээрээ оруулна гэх юм бол энэ чинь сүүлдээ энэ чинь асуудал нь ургаад гарч байна шүү дээ.

3 дахь зүйл зарчмын зөрүүтэй саналууд гарч байна. Гарах хэрэгтэй. Сая Байнгын хорооны дарга ч гэсэн хэлж байна. Зарчмын зөрүүтэй санал бол бодлогын том асуудлыг шийдэхгүй гэж байна. Нэг талдаа тийм шүү. Нөгөө талдаа тухайн тодорхой зохицуулалт хийж болох зүйлийг төсвийн бүтэц дотор нь шийддэг ийм л зохицуулалт байхгүй юу. Тэгэхээр энэ зүйлийг хэдүүлээ барихгүй бол би та бүхэнд бие биеэ шүүмжилж байгаа юм биш шүү. Зүгээр л жишээ болгож байгаа юм. 2/50 гэдэг ийм шийдвэр сая гарсан. Өөрөөр хэлбэл жишээ нь, бүх төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвөөс 2 хувийг нь аваад, жишээ нь тодорхой салбарын албан хаагч нарын, ажилтнуудын цалинг 50 хувь нэмнэ гэдэг ийм санал ороод ирж байгаа байхгүй юу. Тэрнээс гадна 10/20 гэдэг ийм санал гарч ирсэн. Бүх салбарын урсгал зардлыг зардлыг 10 хувь танаад, тэгээд тодорхой салбарын албан хаагчдын цалинг бол 20 хувь нэмнэ гэж байгаа юм. Нөгөө салбар нь бодлогогүй юм уу. Нөгөө салбарт нь ажилладаг хүн байхгүй юм уу. Сая Ундрам сайд хэлж байна шүү дээ. Манай соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарт гэж байгаа шүү дээ би энд бичиж авснаар 7612 албан хаагч байна гэж. Тэнд баахан соёлын төвүүд байж байгаа, номын сангууд байж байгаа. Цалин нь маш бага шүү дээ. Тэгээд яах юм. Тэр хүмүүсийн цалинг аваад, нөгөө хүмүүст өгөх гэж байгаа юм уу. Энийгээ та хэд мэдэж байгаа юу ер нь. Энэ зэргийн юмаа мэдэхгүй та хэд энд өнөөдөр улс төр хийгээд сууж байгаа бол ер нь зарим нь зарим зүйлээс татгалзсан нь дээр шүү. Бид энэ эдийн засгаа мэддэггүй, төсөв санхүүгээ мэддэггүй, бодлого, төлөвлөлтөө мэддэггүй баахан хүмүүс энд сууж байгаа юм шиг болж байна шүү дээ. Тэгээд яах юм нөхөд өө, тэгээд л шууд тэтгэврийг тэгээд нэм гээд 1 хүн гараад ирж байна. Үгүй ээ, тэр чинь эх үүсвэр нь байхгүй бол тэгээд яах гээд байгаа юм. Байхгүй зүйлийг бид чинь байгаа боломжоор нь нэмэх ёстой болохоос биш, тэр хүний хэлснээр тэр хүн бусдад таалагдаж популизм хийснээр энийг бид шийдвэр гаргана гэж байхгүй шүү дээ. Тэгэхээр энэ зүйлийг бид нар ярих ёстой. Бүгдээрээ бид нар чадавхтай байж/минут дуусав/

Б.Найдалаа: Баярлалаа. Үг хэллээ. Зулпхар гишүүний санал зүйтэй санал. Гэхдээ яах вэ бид нар Байнгын хороо дээрээ зөвлөхүүдийнхээ хүрээнд, яг хуулийн хүрээнд, Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнх нь хүрээнд, яг хуулиар заагдсан хэм хэмжээнд нь санал хураалт явуулах ёстойг нь хураагаад явж байгаа.

Дараагийн үе шат бид нар сая ярьсан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулах ёстой байгаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй саналууд гишүүдээс ирсэн байгаа. Эдгээр санал дээр санал хураалт явуулна.

Тэгээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 17.3-д зааснаар зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал гаргасан гишүүн зөвхөн санал гаргасан гишүүн саналынхаа үндэслэлийг тайлбарлаж, үг хэлэх ёстой байгаа. Ингээд санал хураалтыг явуулж эхэлье. Нэлээн олон санал байгаа. Та бүхэн анхааралтай сонсоод, би саналуудыг нэг бүрчлэн уншина. Тэгээд санал гаргасан гишүүн үг хэлж болно.

1 дүгээр санал. Багш, эмч нарын цалин тэтгэврээс бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад туссан урсгал зардлыг 0,8 хувиар буюу 170.0 тэрбум төгрөгөөр бууруулах, нөгөө талд нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьжиргааг

тэтгэх мөнгөн тэтгэмжийн 397.5 мянган төгрөг мянган төгрөг, асаргааны тэтгэмжийн 302.5 мянган төгрөг, Нийгмийн халамжийн тэтгэврийн 397.5 мянган төгрөгийг 24 хувиар нэмэгдүүлэх. Зарчмын зөрүүтэй санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, С.Эрдэнэбат нар. Санал хураалтад бэлдье. Баясгалан гишүүн саналаа тайлбарлаж үг хэлнэ.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Сүүлийн үед би маш их ярьж байгаа. 302 мянган төгрөгөөр хөгжлийн бэрхшээлтэй иргэнээ асарч байгаа гэр бүл, 397 мянган төгрөгийн халамжийн тэтгэвэр авч байгаа энэ хүмүүсийн тухай ярьж байгаа. Өнөөдөр Монгол Улсад амьжиргааны доод түвшин Улаанбаатар хотод 497 мянга, бүсийн дундаж түвшинд 487 мянган төгрөг байгаа. Тэгэхээр амьжиргааны доод түвшинд ч хүрэхгүй 302 мянган төгрөг аваад амьдарч байгаа энэ хүмүүсийн асуудлыг оруулж ирсэн юм. Энд нийт 212 мянган иргэний буюу Монгол Улсын өрхөөр нь тооцвол 17 орчим хувь өрхийн асуудал явж байгаа. Тэгэхээр энэ асуудлыг та бүхэн минь дэмжиж өгөөч ээ. Энд бол ямар нэгэн тийм эсрэг юм байхгүй. Тэр юунаас гарах нь тодорхой байгаа.

2 дугаарт гэвэл энэ хүмүүс амьдрах биш өнөөдөр амь зогоож байгаа. Тэгэхээр та бүхэн минь гэрээсээ бүгдээрээ харж байгаа. Жагсаж чадаагүй учраас эд нарын эрх ашиг өнөөдөр яригдаагүй. Тийм болохоор жагсаж чадахгүй байгаа, гэртээ өвдөөд байж байгаа, Саранчулуун, бид 2-ын төлөөлөл болсон энэ хүмүүсийн төлөө та бүхэн минь дэмжиж саналаа өгөөрэй гэж хичээнгүйлэн хүсэж байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Гишүүд санал хураалтад бэлдье. Хуруугаа уншуулна. Уншигдахгүй байна. Ганбаа гишүүн, Бямбасүрэн гишүүн, Бейсен гишүүн, Баясгалан гишүүн бэлэн бус байна шүү. Орсон уу. Болчихсон Алтаншагай гишүүн байхгүй. Саяын Баясгалан гишүүн, Эрдэнэбат гишүүн нарын гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хурааа. Санал хураалт. Гишүүдийн 70,8 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Ариунзаяа гишүүний гаргасан санал. Урсгал шилжүүлэг, зардлын бүлгийн бусад зардал шилжүүлгийн тэтгэвэрт гарах нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 178,089.9 төгрөгөөр нэмэгдүүлэх. Нөгөө талд нь улсын төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын бараа, үйлчилгээний зардлын бараа, үйлчилгээний бусад зардлыг 178,089.9 төгрөгөөр бууруулах. Энэ саналтай холбоотой Ариунзаяа гишүүн үг хэлнэ.

А.Ариунзаяа: Эрхэм гишүүд ээ, Төр төрийн албан хаагчдаа ажиллуулаад улс төрийн албан хаагчдаас бусад төрийн албан хаагчдад хуулиар хүлээсэн үүрэг юу вэ гэхээр өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн 36 сар хүртэл тэтгэмжийг олгодог хуультай, үүрэгтэй. Энэ хүлээсэн үүргээ 50 хувийг л ирэх ондоо өгье, 50 хувийг нь дараа жил рүү нь шилжүүлэе гэдэг ийм төсвийг оруулж ирсэн. Энэ бол Төрийн албаны тухай хуулийн 9.2 дахь заалтыг зөрчсөн. Аливаа хэмнэлтийн бодлого маань төрийн албан хаагчдын цалин хөлс, урамшуулал, тэтгэмжийг түр зогсоох, бууруулах үндэслэл болохгүй гээд заагаад өгчихсөн байдаг. Энэ нь төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа юм. Төсвийн тухай хуулийг ч гэсэн зөрчсөн. Төсвийн тухай хуулийн 6.4.8 болон 70.5 дахь энэ заалтуудыг зөрчсөн. Энэ нь юу вэ гэхээр өр авлага үүсгэж болохгүй. Өр авлага үүсгэсэн бол тухайн төсвийн ерөнхийлөн захирагч хуулийн хариуцлага хүлээнэ гэсэн ийм заалтууд байгаа. Тэгээд би яг энэ дээр эдгээр хуулиудыг зөрчсөн байна уу, үгүй байна уу гэдгийг Ариунзаяа гэдэг хүний үгэнд итгэхгүй байгаа учраас Төрийн байгуулалтын байнгын

хорооноос хамтын шийдвэр гаргаж, хууль зүйн лавлагаа авхуулсан. Тэгээд хууль зүйн лавлагаа бол эдгээр хуулийг зөрчсөн байна гэдэг ийм дүгнэлт ирсэн байгаа.

Тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дээр энэ зарчмын зөрүүтэй санал дэмжигдэж, санал хураагдсан. Тэгээд та бүхнээсээ нөгөө давхардуулан санал хураахгүй гэдэг үүднээс энд хураалгаад яах вэ. Харин төсвийн ажлын хэсэг дээр бас өөр эх үүсвэрүүдийг олох боломжтой бол тэндээ зохицуулах, ямар ч байсан 178 тэрбум төгрөгийг нэмж тусгаж, бүрэн дүүрэн төрийн албан хаагчдынхаа энэ өндөр насны тэтгэвэртээ гарахад олгогддог нэг удаагийн тэтгэмжийг олгох нь зүйтэй. Энэ бол хууль ёсны асуудал бөгөөд аливаа төсөв өөрөө хуульд захирагдах ёстой. Хууль зөрчсөн төсөв байж болохгүй гэдэг агуулгаар ийм саналыг оруулж байгаа. Тэгээд төсвийн ажлын хэсэг дээр өөр эх үүсвэр олдохгүй байх юм бол нэгдсэн чуулган дээр бас энэхүү саналыг дэмжиж өгч саналаа хураалгахыг хүсэж байна. Баярлалаа. Саналаа татаж байна гэсэн үг.

Б.Найдалаа: Баярлалаа. Саналаа татаж авлаа. Ийм учраас дараагийн санал руу орёё. Дараагийн санал.

Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1.9 дэх “Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас” гэснийг “Төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон нийгмийн даатгалын шимтгэл” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал. Үүнтэй холбоотой Гэр бүл, нийгмийн хамгааллын яамнаас хэлэх тайлбар байвал хэлээрэй. Золжаргал гишүүн байгаа юу. Алга байна. Микрофон 3.

Л.Мөнхзул: Яг хуулийн зүйл заалтаа хөөвөл ялгаатай. Шимтгэл гэхээрээ одоо цалингаас өгч байгаа тухайн сар бүр өгдөг шимтгэлийн мөнгөн дүн. Энэ шимтгэлийн татаас гэдэг нь юу вэ гэхээр өмнө нь төр буюу улсын секторт ажиллаж байгаа цэргийн албаны тэтгэвэр тогтоолгочихсон хүнийг улсад ажилласан хугацааных нь шимтгэлийг нь нийгмийн даатгалын сан руу тэтгэвэрт гарах үед нь төлдөг. Өнгөрсөн цаг хугацааны юмыг хэлж байна. Тэгэхээр яах вэ, нөгөө тайлбарыг нь сонсоогүй болохоор агуулгыг нь мэдэхгүй байна. Харахад шимтгэл татаас 2 өөр боловч Нийгмийн даатгалын ерөнхий хуультай зөрчилдөх магадлалтай учраас бас анхаарах нь зүйтэй байх.

Б.Найдалаа: Ойлголоо. Гишүүд мэдээлэл авсан байх. Санал хураалт. Нийт гишүүдийн 20,8 хувь дэмжиж санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400730 төслийн кодтой “Төв халх” дуулалт жүжгийн театр /Дундговь, Сайнцагаан сум/, хэрэгжих хугацаа 2011-2028 он, төсөвт өртөг 32,990.1 сая төгрөг, санхүүжих дүн 8,671.8 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 543.7 сая төгрөгөөр бууруулж, УТ2403100365 төслийн кодтой Спорт заалны барилга /Дундговь, Луус сум/, хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,366.3 сая төгрөг, санхүүжих дүн 255.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 543.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат, Г.Ганбаатар.

Санал гаргасан гишүүд байгаа юу. Алга байна. Санал хураалт. Нийт гишүүдийн 62,5 хувь нь дэмжсэн учраас санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Гишүүд анхаараарай.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808718 төслийн кодтой, Багануур тойрог авто зам, 14.4 км /Багануур хот/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 43,321.9 сая төгрөг, санхүүжих дүн 14,656.9 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, төрийн өмчит Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуульд шаардлагатай урсгал зардлыг санхүүжүүлэхээр Боловсролын сайдын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир. Энэ бол зүйтэй санал байх шиг байна. Санал хураалт. Сандаг-Очир гишүүн байгаа юу. Байхгүй. Тэгэхдээ санал өөрөө гаргасан бөгөөд бас яг ер нь тодорхой зүйтэй санал байна. Анхаараарай. Санал хураалт. Гишүүдийн 66,7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Гишүүд анхаараарай.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн зардлыг 3,199.0 сая төгрөгөөр бууруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багц дахь Урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг 3,199.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, С.Зулпхар, Д.Рэгдэл, С.Эрдэнэбат. Гишүүдээс үг хэлэх үү. Санал гаргасан гишүүдээс. Ойлгомжтой гэж үзэж байгаа учраас санал хэлэхгүй юм байна. Саналын дагуу санал хураалт. Гишүүдийн 75 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Гишүүд ээ, анхаараарай. Саналыг уншъя.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601300966 төслийн кодтой Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улаанбаатар/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 67,119.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,000.0 сая төгрөгөөр бууруулж, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн үйлдвэрлэлийн түүхий эд, материалын зардалд 1,100.0 сая төгрөг, мөн төслийн 2 дугаар хавсралтад “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн автомашин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 700.0 сая сая төгрөг”, “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалт, хөгжлийн төв”-ийн өргөтгөлийн барилгын засвар /Улаанбаатар, Баянгол дүүрэг/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 200.0 сая сая төгрөг”, гэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун. Саранчулуун гишүүн үг хэлнэ.

О.Саранчулуун: Гишүүд ээ, би та хэдэд танилцуулга өгсөн байгаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ гэдэг нь зөвхөн ажлын байр бий болгоод зогсохгүй хөдөлмөр хийгээд эхэлчихсэн хүмүүсээ дэмжих ёстой. Өнгөрсөн жил улсын төсвөөс 3,5 тэрбумыг энэ үйлдвэрийг босгож, хөл дээрээ босгоход нь зарцуулсан боловч гүйцэтгэгч шалгараагүйн улмаас тодорхой дүн нь хасагдсан юм байна. Одоо жишээлбэл та нарт би үзүүлээд байгаа энэ тор, дугтуйнуудыг дандаа харааны бэрхшээлтэй хүмүүс оролцдог энэ үйлдвэрт хийсэн байгаа. Нэгэнт эхэлчихсэн ажил явж байгааг нь дэмжээд өгчихвөл энэ үйлдвэрийн ажиллаж байгаа хүмүүсийн тоо нэмэгдээд, үр ашиг нь нэмэгдээд, жинхэнээсээ ажилд орж байгаа хүмүүсийн тоо нэмэгдэх гээд байгаа юм. Тийм учраас та бүхэн энэ саналыг маань дэмжиж өгөөч ээ. Тэгээд жишээлбэл энэ хийж байгаа бүх бүтээгдэхүүнүүдийн Засгийн газрын

жишээлбэл яамдын дугтуйг хийдэг юм байна. Энийг нь харааны бэрхшээлтэй хүмүүс наадаг юм байна. Монголд харааны бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө өөрсдөө ийм эко 00-ийн цаас бас хийдэг юм байна. Тэгэхээр ядаж үйлдвэрийнх нь тоног төхөөрөмж нь авчихсан мөртөө материал нь дутуу зарим засвар нь дутуу байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг та бүхэн дэмжээч ээ гэдгийг хүсэж байна. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Гэхдээ хамгийн гол нь Байгаль орчны яамнаас хүн байгаа юу. Энэ чинь нөгөө талд нь нөгөө КОП-ын арга хэмжээнээс хасаж байна гэсэн үг биз дээ. Яамнаас хүн байгаа юу. Тайлбар хэлэх хэрэгтэй байна л даа. Тайлбар байхгүй болж байгаа юм бол санал хураалт. Гишүүдийн 83,3 хувь нь дэмжсэн учраас санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400522 төслийн кодтой “Спорт заалын барилга /Ховд, Буянт сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,103.4 сая төгрөг, санхүүжих дүн 1,396.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал гаргасан гишүүд байгаа юу. Бямбасүрэн гишүүний микрофоныг өгье.

Ш.Бямбасүрэн: Байнгын хороонд 4 санал байгаа юм. Ерөнхийдөө яг адилхан байгаа Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга гээд сумуудад байгаа юм. Яах вэ тэнд сумуудад энийг барих шаардлагыг маш сайн ойлгож байгаа. Энийг бол ойлгож байгаа. Гэхдээ өнөөдөр бид нарт ер нь өнгөрсөн жилүүдэд нөгөө багшаасаа илүү сургууль, эмчээсээ илүү эмнэлгийн барилга, байгууламж гээд яваад байсан. Тэгтэл өнөөдөр эмч, багш нарын маань цалин, нийгмийн асуудал маань ... та 2 маань жоохон аяархан ярьж болох уу. Тэгээд эмч, багш нарын маань цалин бол өнөөдөр нийгмийн яг тулгамдсан асуудал болчихсон. Тэгээд бид нар ингээд нэг ийм зарчмаа яримаар байна. Улсын Их Хурал дээр энэ төсөв дээр. Орон нутгийн шинж чанартай энэ төсвүүдийг бид нар ингэж тавих нь буруу байгаа юм. Энэ бол орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх бүрэн боломжтой ажлууд байгаа юм. Тэгэхээр ингээд улсын төсөв дээр бид нар сумын төвийн, багийн төвийн гээд ийм асуудлуудыг ингээд шийдэхээр бас ер нь маш буруу болчихоод байгаа юм. Буруу болчихоод байгаа юм. Одоо 1 юм эхэлдэг. Тэгээд 3 жил ингээд үргэлжлээд явдаг. Тэгээд эхэлсэн юм чинь заавал дуусгахаас өөр аргагүй гэдэг.

Тэгэхээр бид нар 3 гишүүн нийлж байгаад үндсэндээ нийт тэгээд 22 зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм. Тэгээд энэ Байнгын хороонд маань 4 нь байгаа. Эндээс бид нар 1,2 их наяд төгрөгийн эх үүсвэр гарч ирнэ гэж тооцоо хийсэн. Тийм учраас эндээс гарч ирэх, энэ гаргаж байгаа саналууд ямар нэгэн байдлаар төсөвт нэмэлт юм бол байхгүй. Зөвхөн хасах, хөрөнгийн эх үүсвэр гаргаж ирэх, тэгээд тулгамдаад байгаа асуудлуудаа шийдэх гэсэн зорилгоор энэ саналуудыг оруулж байгаа юм шүү. Тэгээд 2026 оноос эхлээд л яг хэдэн сумдад л баахан барилга барья гээд байгаа юм. 8,3 тэрбумын өртөгтэй. Тэгээд яг үнэндээ энийг бол орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдэх хангалттай боломж байгаа. Тийм учраас гишүүд маань зарчмын зөрүүтэй дараах хураалгах 4 саналыг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

Б.Найдалаа: Нөгөө талд нэмэх юм байхгүй. Зөвхөн хасах, хэмнэх юм байна шүү дээ зөв үү. Энэ хасаж байгаа саналтай холбоотой яамдаас өөр санал байхгүй бол саяын уншсан саналын дагуу санал хураалт. Гишүүдийн 66,7 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400239 төслийн кодтой “Спорт заалны барилга /Хөвсгөл, Түнэл сум/, хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 2,156.8 сая төгрөг, санхүүжих дүн 970.6 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Асуулт байхгүй. Зөвхөн санал гаргасан гишүүд тайлбар, үг хэлнэ. Тэр нь байхгүй. Тэгэхээр тайлбар байхгүй бол түрүүн гишүүд саналаа тайлбарлаад үг хэлчихсэн учраас санал хураалт. Гишүүдийн 54,2 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2603400052 төслийн кодтой “Спорт цогцолборын барилга /Сэлэнгэ, Сайхан сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 6,728.8 сая төгрөг, санхүүжих дүн 2,018.7 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Гишүүд үг хэлсэн учраас яг түрүүний агуулгаараа адилхан энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хурааа. Санал хураалт. Гишүүдийн 41,7 хувь нь дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн багц дахь “Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал”-ын зардал болох 11,830.2 сая төгрөгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Энэ дээр санал гаргасан гишүүн Бямбасүрэн гишүүн үг хэлнэ.

Ш.Бямбасүрэн: Энэ саналаа татаад авчихъя. Түрүүн ерөнхийдөө Сангийн яамнаас тодруулаад асуучихсан юм. Тэгээд энэ саналаа татаад авчихъя.

Б.Найдалаа: Энэ саяын саналыг санал гаргасан гишүүн татаж авсан. Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808719 төслийн кодтой Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам /Зүүн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2028 онд, төсөвт өртөг 319,998.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын багцын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Санал гаргасан гишүүн Мөнхтуяагийн микрофоныг нээе.

Ц.Мөнхтуяа: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд ер нь бол за байж бай би ярьчихъя. Хуулиуд дандаа нөгөө амьгүй хууль гаргадаг. Тэгээд хэрэгжих юм байхгүй. Ард иргэд рүүгээ чиглэсэн, хөрсөн дээр буусан хууль энэ ордноос ерөөсөө гарахгүй байна гэсэн юмнууд явж байна шүү дээ. Гишүүд бүгд хэлж байна. Аргаа бараад ийм зарчмын зөрүүтэй санал оруулж байгаа байхгүй юу. Тэрнээс энэ хууль нь үнэхээр хэрэгжээд явдаг бол болж байна. Би бол энэ Боловсролын ерөнхий хуулийн 13.4-ийг амилуулах гэж өөрсдөө ол гэсэн учраас би түүсэн. Тэрнээс би өөртөө авах гэж энийг гаргаагүй. Тэгээд юм явангуут болохгүй, болохгүй гээд, өөрсдийнхөө юмыг болохоор болно, болно гээд миний юм явангуут болохгүй гэж

болохгүй. Энэ бол боловсролын салбар багш, ажилтны нийгмийн асуудал шийдэх гэж байгаа асуудал болохоос Мөнхтуяа энэ байр, орон сууц авах гээд байгаа юм биш. Тэгэхээр одоо яах вэ гэхээр энэ замуудыг бол би 2026 оныг бол хасуулаагүй юм. 2027, 2028 онд хасагдана. Энийг чинь үргэлжлүүлээд тавиулж болно шүү дээ. Тэгэхдээ би их уян хатан хассан. Тавхан тэрбум. Тэгэхэд энд 50 мянган багшийн, 5 мянган багшийн амьдрал шийдэгдэнэ. Жил бүр. Тэгэхээр энэ бол ерөөсөө гишүүд нээрээ энэ жил боловсролын салбарыг дэмжих жил дэмжинэ, дэмжинэ гээд байгаа хүмүүс би кноп дээр чинь шууд зургийг нь дараад л багш нарын групп рүү оруулна. Үнэн. Үнэн. Өөр би арга байхгүй. Угаасаа дэмжихгүй бол тэгээд саналаа хураалгая.

Ер нь бол энэ боловсролын салбарынхаа багш, ажилтны нийгмийн асуудлыг хэдүүлээ эхлээд шийдье. Зам, гүүрнээс илүү хүн рүүгээ оруулъя. Хүүхэд рүүгээ оруулъя. Ирээдүй рүүгээ оруулъя. Зогсоох гээгүй шүү дээ. 5 тэрбумыг нь авъя. Дараагийн жил оруулъя л гэж байгаа. Тэгээд багшийн нийгмийн асуудал шийдэх, нөгөө Боловсролын хуулийн 13.4-ийг амилуулах заалт шүү. Занданшатар сайд хэлсэн шүү дээ. 5 жилд 100 багш оруулсан гээд. Тэгээд энийг бол хийе хэдүүлээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Мөнхтуяа гишүүн тэр төсвийн захиран зарцуулагчтай нь ярьж тохирсон зүйл байгаа юу. Бусад төсвийн захиран зарцуулагчдаас санал, мэдээлэл байхгүй бол саналынх нь дагуу санал хурааа. Санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 58,3 хувь нь дэмжиж санал дэмжигдлээ. Алтаншагай гишүүнийг дэмжсэнээр тэмдэглэе.

Дараагийн санал гишүүд анхаараарай.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808512 төслийн кодтой “Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 59.2 км /Хойд бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 101,370.6 сая төгрөг, санхүүжих дүн 19,710.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхтуяа. Санал гаргасан гишүүн үг хэлэх үү. Мөнхтуяа гишүүн.

Ц.Мөнхтуяа: Боловсролын ерөнхий хуулийн 13.4. дээр багш, ажилтныг орон сууц авахад дэмжлэг үзүүлнэ гээд байгаа юм. Тэгээд ямар дэмжлэг үзүүлэх гээд байгаа юм. Ямар ч тодорхой юм байхгүй. Зүгээр тунхаг төдий хуульд амьгүй заалтууд оруулчихдаг. Тэгээд энэ амьгүй заалтуудыг чинь амь оруулах гэж л ингэж хүмүүсийн ад болж байна шүү дээ яг үнэндээ. Тэгээд үнэхээрийн бодитой сайхан хөрсөн дээрээ буусан хууль хийчихсэн бол би өнөөдөр ингэж хүний хараал идээд ингээд юм гуйгаад суухгүй шүү дээ. Тийм биз дээ. Тэгэхээр энийг дэмжиж өг. Би зургийг нь дарна.

Б.Найдалаа: Баярлалаа. Энэ дээр зүгээр яах вэ, Мөнхтуяа гишүүний зарчмын санал нь зөв өө зөв. Гэхдээ энэ дээр Зам, тээврийн яам болон бусад төсвийн захиран заргалагчдаас ямар нэгэн мэдээлэл, санал хэлэх юм байхгүй юу. Тэгвэл саналын дагуу санал хураалт. Гишүүдийн 54,2 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Мөнхтуяа гишүүн ээ, юу шүү гишүүд дэмжих нь дэмжинэ, дэмжихгүй нь дэмжихгүй. Энэ бол гишүүнийх нь бүрэн эрх. Тэгээд та бас яг энэ

гишүүдээс санал гаргаж байна шүү. Энэ дээр яг зарчмынхаа юмыг л ярьсан нь зөв байна. Хурлын дэгд хэрэгтэй байна.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808289 төслийн кодтой “Орхонтуул-Цээл чиглэлийн хатуу хучилттай авто зам, 62,56 км /Төвийн бүс/”, хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 117,450.0 сая төгрөг, санхүүжих дүн 25,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Тайлбарыг хэлсэн учраас саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 45,8 хувь нь дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2403100360 төслийн кодтой “Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/” хэрэгжих хугацаа 2024-2026 он, төсөвт өртөг 1,101.0 сая төгрөг, санхүүжих дүн 577.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг хасаж, “Заяын Гэгээний хүрээ хийдийн цогцолборын” дээврийн засвар /Архангай, Эрдэнэбулган сум/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 577.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн. Хэрлэн гишүүн үг хэлнэ.

Б.Хэрлэн: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр энэ 300 гаруй жилийн түүхтэй 1994 онд Монгол Улсын түүхийн соёлын биет өвд бүртгэж авсан ийм хийд байгаа юм. Тэгээд энэ хийдийн барилга бас нэлээн дээвэр нь эвдэрчихсэн. Тэгээд үүний засварт бороо, ус оронгуут л нь шууд дээврээс нь ус гоожчихдог ийм хэцүү болчихсон байгаад байгаа. Тэгээд энэ хийдийн соёлын биет төвийг хамгаалах зорилгоор Архангай аймгийн төвд барьж байгаа 3 спорт заалных нь 1 спорт заалны зардлыг нь энэ хийдийг засах энэ барилгын ажилд шилжүүлье гэсэн юм. Одоогоор бол Архангай аймгийн төвд бол нийтдээ 5 спорт заал байгаа. Дээр нь нэмээд 3 заал барьж байгаа. Тэгэхээр 1 спорт заалных нь зардлыг тийш нь шилжүүлэх ийм санал гаргасан юм. Сайд нь зөвшөөрсөн. 1 сайдын багц дотор байгаа. Тэгэхээр энд бол асуудал байхгүй. Сайд нь зөвшөөрсөн. Тэгээд энэ соёлын биет өвөө хамгаалъя. Спорт заал бол хүлээнэ. Энэ 300 жилийн настай барилга бол хүлээхгүй, өнөө маргаашгүй нураад унаж болзошгүй байгаа учраас энэ дээр дэмжээд та бүхэн энэ хөрөнгийг шилжүүлэх тал дээр санал өгөөрэй гэж хүсье.

Б.Найдалаа: Баярлалаа. Зүйтэй санал байна. Энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хурааа. Санал хураалт. Гишүүдийн 69,6 хувь дэмжиж, санал дэмжигдлээ. Хэрлэн гишүүн танаас дахиад нэг санал байна. Энэ саналаа яах юм. Тэгвэл та өөрөө микрофон дээр хэлчих. Яг тэр саналаа уншаад.

Б.Хэрлэн: Зарчмын зөрүүтэй саналын 20-д бичигдсэн байгаа. Төслийн 2 дугаар хавсралтын УТ2003400774 төслийн энэ Байгалийн түүхийн музейгээс спорт урлагийн арга хэмжээний үйл ажиллагааны зардалд мөнгө шилжүүлэхээр санал гаргасан. Энэ саналаа татаж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Хэрлэн гишүүн саналаа татлаа. Санал хураалтаа үргэлжлүүлье.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808162 төслийн кодтой Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км, /Баруун бүс/" хэрэгжих хугацаа 2025-2028 он, төсөвт өртөг 150,926.6 сая төгрөг, санхүүжих дүн 23,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж, Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан "Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ." гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Энэ агуулгын хувьд өмнөх саналуудтай адилхан байгаа учраас шууд санал хураалтад орьё. Санал хураалт. Гишүүдийн 56,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Мөнхтуяа гишүүн ээ, гишүүдийн санал бас зөв шүү. Хурлын дэг болон уур амьсгал илүү цэгцтэй байх үүднээс та бас жоохон юу яагаарай. Гишүүдэд шахалт зөв үзүүлээрэй.

Дараагийн санал гишүүд анхаараарай. Мөнхтуяа гишүүн ээ, дуугаа намдаая. Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 Төслийн кодтой Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам 179,7км ... яах юм. Санал хураах юм уу, яах юм Мөнхтуяа гишүүн. Үргэлжлүүлэх үү. Та чимээгүй байж байгаарай.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой "Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179,7 км, /Хэнтий, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, 186,000.6 сая төгрөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан "Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ." гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Агуулга мөн адилын учир энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 47,8 хувь дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Гишүүд ээ, чимээгээ намжаая. Танхим чимээгүй байя. Дараагийн санал уншлаа. Анхааралтай байгаарай. Гишүүд ээ, санал хураалтдаа л анхаарчих. Санал хураалтаа үргэлжлүүлье. Ингэж хэлэлцэхгүй. Зүгээр яг микрофон дээрээ хуулийнхаа дагуу дэгээрээ хэлэлцье.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой "Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5 км, /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан "Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ." гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая

төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Мөнхтуяа гишүүн үг хэлнэ.

Ц.Мөнхтуяа: Энэ нөгөө Боловсролын ерөнхий хуулийн 13.4-ийг амилуулах заалтууд оруулах гээд л би энд төсөв тавиулах гээд байгаа байхгүй юу. 13.4 ямар ч төсөвгүй. Тэгвэл энэ хүмүүс нь уурлаж байгаа бол Засгийн газар нь энэ мөнгийг шийдэж өг, гаргаж өг. Би ямар өөртөө авах гээд байгаа биш над руу ингэж муухай дайрч болохгүй шүү дээ Зулпхар гишүүн ээ. Тийм биз дээ. Би энд боломжоороо ... бүх гишүүд зарчмын зөрүүтэй санал оруулж байгаа шүү дээ. Би ч гэсэн оруулах эрхтэй шүү дээ. Үгүй ээ, тэгээд бүр зогсоогоогүй шүү дээ.

Б.Найдалаа: Ойлголоо. Баярлалаа. Мөнхтуяа гишүүний гаргаж байгаа санал зарчмын хувьд чиглэлийн хувьд зөв ч гэсэндээ яах вэ бусад төсвийн захиран зарцуулагчтай ярьсан, хэлсэн гээд ямар нэгэн байдлаар бодлого явж байгаа болохоор тэр бодлоготой нь бас яг ярьж тохирох нь зүйтэй байна. Ямар ч байсан Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд зарчмын зөрүүтэй санал гаргасан учраас нэмэлт тайлбар байхгүй бол энэ дээр санал хураалт. Гишүүдийн 34,8 хувь нь дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Танхимд чимээгүй байя. Зулпхар гишүүн ээ, чимээгүй байгаарай. Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын Ут 2602800636 төслийн кодтой Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас Мөнхтуяа гишүүн ээ, саналыг унших уу, яах уу. Та хэд чимээгүй байж байх уу. Давхцаад байна.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800636 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 170,899.7 сая төгрөг, санхүүжих дүн 25,635.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Агуулга, тайлбар хэвийн учраас энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Санал хураалт. Гишүүдийн 43,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2102800331 төслийн кодтой “Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/, хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 185,000.0 сая төгрөг, санхүүжих дүн 45,921.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Агуулга, тайлбар хэвээр учраас энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүдийн 43,5 хувь нь дэмжиж, санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2602800805 төслийн кодтой “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 106,868.4 сая төгрөг, санхүүжих дүн 20,036.4 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 5,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 5,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа.

Агуулга тайлбар хэвээрээ учраас энэ саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 39,1 хувь дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй. Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2502808473 төслийн кодтой “Даланзадгад-Мандалговь чиглэлийн хатуу хучилттай авто замын их засвар, 156 км /Говийн бүс/, хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 157,864.8 сая төгрөг, санхүүжих дүн 40,460.6 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 10,000.0 сая төгрөгөөр бууруулж Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан “Багш, ажилтны амьдрах нөхцөлийг сайжруулах, орон сууцжуулахад төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэснийг хэрэгжүүлэхэд зориулж Боловсролын сайдын урсгал зардлыг 10,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа. Санал хураалт. Гишүүдийн 47,8 хувь дэмжиж, санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/” хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 3,000.0 сая төгрөгөөр бууруулж, Идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих ажлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлыг 3,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар. Санал гаргасан гишүүн үг хэлэх үү. Ганбаатар гишүүний микрофоныг нээе.

А.Ганбаатар: Өмнөх Байнгын хорооны хурал дээр бол саналаа хэлж байсан. Яах вэ, Ерөнхий сайд бол хүн бол мега төсөл юм гэж байгаа юм. Тэгээд энэ хүрээндээ хүнийхээ хөгжлийн тал дээр төсвүүд их унасан байна. Ялангуяа спортын төсвүүд бол их унасан юм байна лээ. Тэгэхээр энэ байгаа төсөв нь харьцангуй 1 тэрбумаас хэтэрсэн төсөв ерөөсөө байхгүй. Тэрийг нь үндсэндээ тэглэхсэн харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм 4 төсөл байгаа. Дээд тал нь 1 тэрбум. Доошоо бүгдийг нь ингээд байхгүй болгочихсон. Тэгээд та бүхнийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Бүгд нийлээд 4 тэрбум.

Б.Найдалаа: Өөр тайлбар байхгүй бол Ганбаатар гишүүний санал гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Гишүүдийн 69,6 хувь дэмжиж, энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2606600085 төслийн кодтой “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Улсын хэмжээнд/” хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, Тусгай олимпын урсгал зардлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар. Ганбаатар гишүүн үг хэлэх үү. Ганбаатар гишүүний микрофон.

А.Ганбаатар: Энэ нөгөө тусгай олимп гээд бүгдээрээ мэдэж байгаа. Аутизмтай, даунтай хүүхдүүдийн спортоор хичээллэх, бүр олимпод оролцох ийм зардал байж байдаг. Тэгээд энэ чинь том холбоо болчихсон. Олон улсын тэмцээнд ордог. Robert kennedy-ийн гэр бүл дэмждэг ийм том олон улсын олимпод ордог юм. Тэгсэн 90 сая төгрөг тавьчихсан. Тэрийг нь хасчихсан юм байна л даа. Тэгээд бүх зардал нь нийлээд 1 тэрбум болоод байгаа юм. Тэгэхээр энийг дэмжиж өгөөч ээ.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Гишүүдийн 69,6 хувь дэмжиж, энэ санал дэмжигдлээ. Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601200517 төслийн кодтой “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын барилга /Өвөрхангай, Хархорин сум/” хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 14,609.5 сая төгрөг” санхүүжих дүн 3,652.4 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, Допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих зардлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганбаатар. Ганбаатар гишүүн хэлэх үг байгаа юу. Ганбаатар гишүүний микрофон.

А.Ганбаатар: Яах вэ, ер нь бол энэ допингтой тэмцэх бол та бүхэн мэдэж байгаа. Тамирчид допингд хамрагдана гэдэг чинь ерөөсөө спортын амжилт нь буурч байгаа, эрүүл мэнд нь хохирч байгаа ийм асуудал байж байгаа. Тэгээд энэ Допингийнхоо төв дээр ерөөсөө 200 сая төгрөг болгоод бууруулчихсан юм байна лээ. Тэгээд тэр нь цалиндаа тавиад алга болчихдог. Нөгөө шинжилгээнд явуулдаг, шинжилгээний хариу авдаг, үүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ дээр ямар ч зардал байхгүй болчихсон. Тэгээд тэрбум төгрөг тавьж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм. Саяын ярьсан Шүүхийн шийдвэр биелүүлэх газрын барилгаас 14 тэрбумаас нь 1 тэрбум хасаж байгаа юм. Энэ угаасаа цаашаа явж байгаа төсөл. Тэгээд л дараа ондоо дамжаад л явчих юм байна лээ.

Б.Найдалаа: Ганбаатар гишүүн энэ дээр нөгөө төсвийн захиран зарцуулагчтай ярьсан, тохирсон, зөвшөөрсөн юм байгаа юм уу.

А.Ганбаатар: Манай яамны Отгонбат маань яриад зохицуулчихсан байж байгаа. Нэмэлт тайлбар байхгүй бол ... үгүй ээ, та хэлэх нөгөө нэг дэггүй юм байна лээ.

Б.Найдалаа: Гишүүн тайлбараа хэлсэн. Тэгээд бусад захиран зарцуулагчдаас тайлбар байхгүй учраас саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 39,1 хувь дэмжиж, энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601400232 төслийн кодтой “Тусгай зориулалтын төвийн барилга /Улаанбаатар/” хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 20,132.1 сая төгрөг, санхүүжих дүн 9,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 2,500.0 сая төгрөгөөр бууруулж, Үндэсний шигшээ багийн бус спортын төрлийг дэмжих зардлыг санхүүжүүлэхээр Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын урсгал зардлыг 2,500.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар. Ганбаатар гишүүн тайлбар хэлэх үү. Ганбаатар гишүүний микрофон.

А.Ганбаатар: Яах вэ дээ, одоо ингээд бид нар чинь 4 спорттой л байгаа шүү дээ. Олимпын төрлийн 4 спорт. Олимпоос, тив дэлхийгээс медаль авдаг гээд. Тэгэхээр бусад спортын төрөл Монголд хөгжих юм уу, үгүй юу л гэдэг асуудал. Бүгдийг нь хасчихсан байгаад байгаа байхгүй юу даа. Тэгээд энэ тамирчдын чинь төлөө хэн явах юм. Энэ спортынхны төлөө хэн явах юм. Яам нь хамгаалахгүй болохоор л бид дуугарч байгаа царайтай юм. Тэгээд манай Отгонбат бүгдийг нь зохицуулаад ингээд ярьчихсан гэсэн. Яагаад хэлэхгүй байна. Энэ болно. Энийг дэмжье хэдүүлээ.

Б.Найдалаа: Энэ тусгай зориулалтын төвийн барилга гэж яг юу байна. Энэ дээр тайлбар байхгүй юу. Яг хариуцаж байгаа яамнаас нь хариулах нэмэлт мэдээлэл байхгүй юу. Нэмэлт мэдээлэл, тайлбар байхгүй бол Ганбаатар гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 60,9 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5км, /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/, хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг 1,708.0 сая төгрөгөөр бууруулж, УТ201500780 төслийн кодтой “Соёлын төвийн барилга, /Хэнтий, Батширээт сум/”, хэрэгжих хугацаа 2021-2026 он, төсөвт өртөг 4,020.8 сая төгрөг, санхүүжих дүн 1,272.0 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,708.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Ганхүлэг гишүүний микрофон.

М.Ганхүлэг: Энэ төсөв хооронд явж байгаа 2 төслийн ажил байгаа. Хоёулаа Хэнтий аймагт хэрэгжиж байгаа төсөл байгаа. 2000 оноос хойш 5, 6 дахь жил рүүгээ орж байгаа дуусгахгүй бол болохгүй ийм 2 барилгын ажлыг өнөөдөр оруулж ирж байгаа юм. Хоёулаа соёлын төв байгаа. Тэгэхээр өөр хэн нэгнээс бас аваагүй. Тэгэхээр та бүхэн маань бас дэмжиж өгөхийг хүсье.

Энэ үнийн дүнг нь би уул нь засаад өгсөн юм. 436 сая байгаа Батширээт сумын зөрүү нь 436 сая байгаа. Цэнхэрмандалынх болохоор 1,707.9 байгаа. Та тэрүүгээр нь томьёоллыг нь оруулаад хурааж өгөөч.

Б.Найдалаа: Аль дүн нь өөрчлөгдөж байна гэнэ ээ. Таны саяын хэлсэн дүн.

М.Ганхүлэг: Батширээт сум 436 сая төгрөгийн зөрүү гарч байгаа.

Б.Найдалаа: 436 сая төгрөг Батширээт сум дээр Нөгөөх нь Цэнхэрмандал сум дээр болохоор 1,707,9 сая төгрөг.

Б.Найдалаа: Яг энэ дүнгээр тодотгосон дүнтэй дүнгээр Ганхүлэг гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая. Санал гишүүдийн 73,9 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн Зам, тээврийн сайдын авто замын төслийн код УТ2402804410 кодтой төсөл арга хэмжээнээс “1,707.9 сая” төгрөгийг бууруулж, “Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумд баригдаж байгаа Соёлын төвийн барилгын УТ201500781 кодтой төсвийг 1.707,9 сая” төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг. Тайлбар хэлсэн учраас дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 73,9 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Монгол Улсын төсвийн 2026 оны төсвийн төслийн Соёлын сайдын төсөл арга хэмжээний УТ2603400522, УТ2603400239, УТ2603400052 кодтой төсөл арга хэмжээнээс 4.385,9 сая төгрөгийг бууруулж, Хүүхдийн төв, Номын сан, Хүүхэлдэйн театрын барилгын төсвийг 3.415,3 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг. Ганхүлэг гишүүний микрофоныг нээе.

М.Ганхүлэг: Соёлын сайдын багц дотор байгаа энэ 3 төсөл арга хэмжээ нь болохоор нөгөө Сангийн яамнаас тавьдаг, зураг төсөв бэлэн байдал хангах ёстой гэдэг энэ шалгуурыг хангахгүй байгаа ийм 3 төсөл бас байгаа юм. Тэгээд тийм учраас энэ спорт заалны барилгын төслүүд байгаа. Тэгэхээр энэ 3-ыг бол ирэх жил зураг төсөв юмнуудаа бас магадлан энэ тэрээр нь оруулаад, жин тан болгоод дахиад оруулахад бас болох байх гэж бодож байна. Буцаагаад энэ Хүүхдийн төв, Номын сангийн тухай асуудал, Хүүхэлдэйн театрын тухай асуудал. Энэ хоёр хоёулаа нийлээд Тасганы овоон дээр үндсэндээ 2 томоохон цогцолбор нэг дор байгуулахаар болж байгаа. Ингээд нийтдээ 4.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг суулгаад, энэ жил ажлыг нь эхлүүлчихье гэсэн ийм саналтай байгаа.

Дашрамд хэлэхэд Байнгын хорооны, шинээр байгуулагдсан Байнгын хорооны хамгийн эхний уулзалтаар бид бүхэн төсвийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэ төсвийн хэлэлцүүлэг дээр гарсан бодитой зураг төсөв бүх юм нь бэлэн байгаа ганц санал нь бас энэ байсан гэдгийг хэлье.

Б.Найдалаа: Баярлалаа. Ганхүлэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал өгсөн гишүүдийн 60,9 хувь дэмжиж, санал дэмжигдлээ.

Гишүүд ээ, анхааръя. Дараагийн санал.

Боловсрол, эрүүл мэндийн сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын цалингаас бусад урсгал зардлыг 196 сая төгрөгөөр бууруулж, 6-12 дугаар ангийн нийт сурагчдын үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжиж санхүүжүүлэхээр 196 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж. Сэддорж гишүүн байна уу. Энийг түр хойшлуулчихъя. Яагаад гэвэл дүнг нь шалгая. Сэддорж гишүүн орж ирье.

Дараагийнх нь саналыг хурааж байя.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601502049 төслийн кодтой “Ерөнхий боловсролын сургуулиудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 26,146.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “3 дугаар сургуулийн биеийн тамирын заалны барилга /Баян-Өлгий, Цэнгэл сум/, төсөвт өртөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх. Энэ дүн нь жоохон юу л байна даа. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен. Бейсен гишүүний тайлбар хэрэгтэй санал байна даа. Энэ жоохон бүрхэг юм.

Сэддорж гишүүний гаргасан саналыг түрүүн уншсан. Дүн дээр нь гишүүд эргэлдэж байх шиг байна. Та тайлбар хэлнэ үү. Сэддорж гишүүний микрофоныг нээе.

Р.Сэддорж: Гишүүддээ өдрийн мэнд дэвшүүлье. Тэгээд хамгийн гол нь бол бид хэд багш, эмч нарын цалинг их ярьж байна сүүлийн үед. Тэгээд ер нь хүүхдүүдээ алагчилж үдийн цай өгдөг улс орон гэж байхгүй байх. Тийм учраас 826 мянган хүүхэд улс даяар байгаа. 1-5 дугаар анги нь үдийн цай ууж байгаа. 6-12 дугаар анги бол үдийн цай уухгүй байгаа. Сургууль дээр та бүхэн нийслэлээс сонгогдсон хүмүүс сургуулиудаар явж байгаа байх. Аймгаас сонгогдсон хүмүүс бас ажиллаж байгаа байх. Үдийн цайны цаг болохоор дүүрэн хоол үнэртээд, тэр бол 1-5 дугаар ангийн хүүхдүүдийн хоол. 6-12 дугаар ангийн хүүхдүүд бол боломжтой ч хүүхэд байна, боломжгүй ч хүүхэд байна. Тэгээд хоол ундгүй, тэгээд хоол үнэртээд байдаг. Тэгээд нөгөө хоолны газар нь дотроо байдаггүй. Тэгээд л эргэн тойронд дэлгүүрээс юм хум авах гэж яаж ч хооллож байгааг мэдэхгүй. Тэгээд та нар бас хүүхэд байхдаа ямар байснаа бас эргээд сана. Тийм ээ.

Одоо манай төсвийн зарлага чинь 33 их наяд хүрчихсэн байгаа. Тэгэхээр үдийн цай 1 доллар хүрэхгүй байгаа шүү дээ. Одоо өгч байгаа үдийн цай чинь 1-5 дугаар ангид 3 мянган төгрөг, 1 доллар хүрэхгүй. Ийм бага зардлаар хангаж байгаа. Ингээд килокалори нь өсөөд бол 3500, 4000 гэж хүүхдэд шаардлагатай үдийн цайг харьцуулсан аргаар гаргадаг юм байна. Ингээд 196 тэрбум төгрөг гэж Сангийн яамнаас өнгөрсөн хурал дээр надад хэлсэн. Тэгээд энэ мөнгийг бол гаргах бүрэн боломжтой. Бид хэд бол энэ мөнгөө гаргахгүй янз бүрийн бүүр аймаг биелэх магадлал багатай, үр дүнгээ олон жилийн дараа өгөх төслүүдийг санхүүжүүлээд бол нэмэргүй юм байна гэдгийг бол хөрсөн дээрээ энэ хүмүүс мэдэж байгаа байх.

Дээрээс нь зөвхөн энэ жилийн хувьд зардал хасахаас илүү орлогоо нэмж гаргах боломж байгаа. Жишээ нь Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт заасны дагуу Эрдэнэс Монгол компани, түүний нэгдлийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 340 тэрбум төгрөгийн ноогдол ашгийн

төлбөрийг, өрийг барагдуулж төсвийн ачааллыг бууруулах боломжтой байгаа гэсэн ийм тооцооллууд гарсан байна. Тэгээд энийг та бүхэн маань тэгээд дэмжиж өгөөч э. Боловсролын сайдтай уулзаж амжсангүй. Ингээд энэ дотор хүүхэдгүй, дүү наргүй хүн байхгүй байх.

Б.Найдалаа: Сэддорж гишүүнээ 196 сая дүн нь мөн юм уу.

Р.Сэддорж: Тэрбум гэсэн. Сангийн яамнаас тэгж хэлсэн. Энийг дэмжиж өгөөч ээ. Баярлалаа та бүхэнд.

Б.Найдалаа: 196 тэрбум юм байна шүү. Боловсрол, Эрүүл мэндийн сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын цалингаас бусад урсгал зардлыг бууруулна. 196 тэрбумаар бууруулаад. Өөр нэмэлт тайлбар яамдаас байхгүй бол Сэддорж гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Гишүүдийн 65,2 хувь нь дэмжиж, Сэддорж гишүүний санал дэмжигдлээ.

Түрүүн санал хураасан Ганхүлэг гишүүний зарчмын зөрүүтэй 2 санал дээр Ганхүлэг гишүүн яг тэр нөгөө төсөвт өртгийг нь төсвийн ажлын хэсэг дээр тодорхой болгож өгөх юм байна шүү. Тэгээд энийг зүгээр тэмдэглэлд үлдээлээ. Та тэрийг өөрөө тодорхой болгож баталгаажуулах ёстой юм байна шүү. Баярлалаа

Дараагийн санал.

Монгол Улсын 202 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын Эдийн засаг, хөгжлийн яамны УТ2606600085 дугаартай төсөл, арга хэмжээний төсвийг 4,800.0 сая төгрөгөөр бууруулж, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын шууд буюу хөтөлбөр арга хэмжээний урсгал зардлыг 4,800.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг. Ганхүлэг гишүүн энэ дээр тайлбар байгаа юу. Ганхүлэг гишүүний микрофон.

М.Ганхүлэг: Төсвийн хэлэлцүүлгүүд дээр та бүхэн маань бас сонссон байх. Энэ жил Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2 төслийг бол онцгойлон анхаарахгүй бол маш ихээр хасагдсан юм байна лээ. 1 нь болохоор энэ залуучуудын салбарын төсөв байгаа. 200 сая төгрөг тавигдсан. Тэгээд энэ жил Монгол Улс Залуучуудын яамтай болоод орж ирж байгаа бараг эхний төсөв байх. Тэгээд зөндөө олон арга хэмжээнүүд хийх ёстой гээд Засгийн газрын мөрийн хөтөлбөр бүхий л юмнууд дээр оруулчихсан байж байдаг. Тэгээд 200 сая төгрөгөөр 21 аймаг, 9 дүүрэг улсын хэмжээнд төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүд зохион байгуулаад ажиллана гэдэг бол бас үнэхээр хэцүү байгаа юм.

Тийм учраас 4,8 тэрбум төгрөгөөр үндсэндээ энийг нэмэгдүүлье. Хасаж байгаа тал нь болохоор зөвлөх үйлчилгээний зардал байгаа. Эдийн засаг, хөгжлийн яам дээр төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ ТЭЗҮ, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ улсын хэмжээнд 40 тэрбум төгрөгөөс нь 4,8-ыг нь үндсэндээ шилжүүлж, залуучуудын хүрээнд хэрэгжүүлэх хамгийн багадаа 12 төсөл арга хэмжээ байгаа. Малчдын асуудал, залуучуудын хорт зуршил болон ажлын байр нэмэгдүүлэх чиглэлийн тодорхой судалгаа олон улсын конвенцын хүрээнд хийгдэх томоохон хөтөлбөр арга хэмжээнүүд гээд ингээд бүгдийг нь хасчихсан юм байна лээ. Тэгэхээр энэ багадаа 12 томоохон улсын хэмжээнд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг санхүүжүүлэх энэ зардлыг хийе гэсэн ийм саналыг оруулж ирж байгаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Манай Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны Спорт, залуучуудын дэд хорооны дарга Ганхүлэг гишүүний гаргасан санал байгаа. Ганхүлэг гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 65,2 хувь дэмжиж, Ганхүлэг гишүүний санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Бейсен гишүүний санал. Бейсен гишүүн байна уу. Бейсен гишүүний саналыг түрүүн уншин танилцуулсан. Бейсен гишүүний саналыг түрүүн уншсан. Тэгэхдээ дахиж уншаад, тэгээд санал хураая.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601502049 төслийн кодтой “Ерөнхий боловсролын сургуулиудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/, хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг, санхүүжих дүн 26,146.5 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг болон санхүүжих дүнг 1,000.0 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “3 дугаар сургуулийн биеийн тамирын заалны барилга /Баян-Өлгий, Цэнгэл сум/, төсөвт өртөг, санхүүжих дүн 1,000.0 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бейсен. Бейсен гишүүн байхгүй байна. Тэгэхдээ бид нар дэгээрээ санал хураах ёстой байгаа. Энийг бас тодруулах ёстой юм байна. Боловсролын яамнаас тодруулах уу. Микрофон 5.

Х.Тамираа: Боловсролын яамны хөрөнгө оруулалтын хэлтсээс. Хасъя гэж оруулж байгаа санал нь бол ирэх жил ашиглалтад орох нийт 54 сургуулийн 42 мянган хүүхдийн сурагчийн ширээ, сандал авах ийм зардал байгаа. Тэгээд эндээсээ хасуулахгүй байх ийм санал бол манай яамны зүгээс байна.

Б.Найдалаа: Хасаж байгаа төсөвт өртөг нь хасуулмааргүй байгаа яамны зүгээс хасах ёсгүй зардал гэж үзэж байна. Гишүүд мэдээлэл авсан байх. Бейсен гишүүн өөрөө хэлэх байхгүй байна. Тэгэхээр энэ дээр Бейсен гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 8,7 хувь дэмжиж, Бейсен гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Дуусаагүй, гэхдээ одоо удахгүй ээ.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалт байхгүй байгаа нь уг хуулийн 1.1. дэх заалттай зөрчилдөж байна. Өөрчлөх зүйл нь яг энийг Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалт байхгүй байгаа тул “Төсвийн алдагдлыг тодорхойлсон зүйл, заалыг Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагаас давсан орлогоор санхүүжүүлсэн тооцоог тусгах” ийм саналыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал гаргасан байна. Золжаргал гишүүн байна уу. Энийг тайлбар, нэмэлт тайлбар хэлэх юм байгаа юу. Микрофон 4.

Л.Мөнхзул: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Мөнхзул. Энэ их л нюанстай санал байна даа. Төсвийн үр дагавар 1 их наяд. Тэгээд ямар учиртай вэ гэхээр орлогоос зарлагаас зарим сангууд тухайн жилийн урсгал дүнгээрээ орлого давж болдог. Тэгэхээр нийт Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсвийн алдагдал ДНБ-ий 2 хувиас давахгүй. Тэгэхээр давсан орлогыг хасчих юм бол дахиад төсвийн алдагдлыг 1 их наядаар нэмэгдүүлж байж энэ хуулийн заалтаа баримтална гэсэн үг. Төсвийн тогтвортой байдлын тухай хуультай бас зөрчилдсөн л юм шиг харагдаж байна. Бас томьёоллыг нь нарийн хараагүй болохоор сонсож байгаад хэлэхэд ийм байна.

Б.Найдалаа: Саналыг сонслоо. Золжаргал гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 23 гишүүнээс 1 ч гишүүн дэмжээгүй учраас Золжаргал гишүүний санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Монгол Улсын 2026 оны төсвийн тооцоололд төсвийн алдагдал 1,380,000.0 сая төгрөг гэж гаргахдаа Нийгмийн даатгалын сангийн зарлагаас давсан орлого 1,281,362.7 сая төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагаас давсан орлого 354,002.6 сая төгрөгийг ашигласан нь Нийгмийн даатгалын сангийн тухай хуулийн 12.2-д “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд нь шилжүүлэн зарцуулах, нэгтгэх, зориулалтын бусаар ашиглахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн тул тооцооллоос хасаж, төсвийн алдагдлыг 3,015,365.4 сая төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 2.9 хувьтай тэнцүүлж бодитоор тооцох, Сангийн яамны ... тооцооллын хүснэгт хавсралт 1-ийг хавсаргав. Өөрчлөх гэж байгаа зүйл нь Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралт 2026 оноос шинээр эхэлж мөн ондоо санхүүжигдэх УТ2601501785, УТ2601501777, УТ2601501767-оос бусад төслүүдийн нийт 1,065,011.7 сая төгрөгийн санхүүжилтийг 2027 он руу хойшлуулж, төсвийн зарлагыг бууруулан алдагдлыг 1,950,353.7 сая төгрөг буюу Дотоодын нийт бүтээгдэхүүний 1,9 хувьд хүргэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал.

Энэ дээр тайлбар хэрэгтэй байна. Золжаргал гишүүн байхгүй. Сангийн яамнаас хэн байгаа билээ. Тайлбар авъя. Тайлбар өгөх хүн байхгүй байна. Гишүүн бас өөрөө тайлбар гаргахаар байхгүй байна. Тийм учраас гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Санал хураалтад оролцсон гишүүд 100 хувь дэмжсэнгүй. Ийм учраас санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал. Эрдэнэбат гишүүний санал.

ҮОМШӨ-ний даатгалын санд төвлөрсөн 423,978.7 сая төгрөгийн орлогоос Орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлийг үнэлж дүгнэлт хийх, хууль эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах, олон нийтэд сурталчлах зардалд 3,500.0 сая төгрөг, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан, эрт тэтгэвэрт гарсан ахмадуудыг асрах, сувилах, сэргээн засах зардалд 5,000.0 сая төгрөг, Олон нийтийн хяналтыг мэргэжлийн болон төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зардалд 1,500.0 сая төгрөгийг нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Эрдэнэбат гишүүн тайлбарлая.

С.Эрдэнэбат: Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн сан гээд бас багагүй хуримтлагдсан байгаад байдаг ийм мөнгө байдаг юм. Одоо бол бараг 400-аад тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй. Тэгэхээр энэ дээр хөдөлмөрийн аюулгүй байдлын гарах ёстой зардлууд дээрээс нь үйлдвэрлэлийн ослоос гэмтсэн, бэртсэн, хөдөлмөрийн чадвараа алдсан ахмадуудыг нь гэж би оруулж ирж байгаа юм. Тэр хүмүүсийн асрах, сувилах гэдэг үйлчилгээнд 5 тэрбум төгрөг тавьж өгье.

Тэгээд олон нийтийн мэргэжлийн хяналтын төрийн бус байгууллага гүйцэтгүүлэх энэ тэр гээд энэ осол аваар энд тэнд гарч байгаа. Энэ осол аваар юмнуудыг заавал төр өөрөө байгаа боловсон хүчиндээ хянах боломж бололцоо бол

тун хязгаарлагдмал байгаа. Тийм учраас иймэрхүү байдлаар 10 тэрбум төгрөгийг заръя.

Нөгөө талд нь буюу орлого талд нь бол үндсэндээ бол өөрөө ашигтай сан. Ямар нэгэн энд тэндээс хасах юм бол ерөөсөө байхгүй. Үлдэгдэл нь 420 орчим тэрбум төгрөг байгаа ийм сан байгаа. Сан юм. Саяын 3 юманд. Сангаасаа зар л гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө төсөвт тавьдаггүй учраас зарж болдоггүй юм байна лээ энэ төсөвтөө тавьчих юм бол зарна гэдэг байдалтай л байгаад байдаг юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Тайлбар нэмэлт тайлбар авъя. Микрофон 3 байна уу. Микрофон 4-ийг нээе.

Ж.Энхтөр: Оройн мэнд хүргэе. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Энхтөр. Нийгмийн даатгалын тухай хуульд Нийгмийн даатгалын ерөнхий хуулиараа зохицуулдаг. Энэ хууль бол Үйлдвэрийн ослын тухай хуулийг бол хуульдаа заасан зардлуудыг заахаар заасан байдаг. Энэ бол 4 сан байгаа.

1 дүгээрт нь Тэтгэврийн тухай хууль, Тэтгэмжийн тухай хууль, Үйлдвэрийн осол гээд энэ хуулиараа зохицуулж байгаа. Энэ зардал нь болохоор өөр юманд зарцуулна гэх юм бол Нийгмийн даатгалын тухай тусдаа хуулиар зохицуулагдаж байгаа. Энэ улсын төсөв ийм зардлууд гарна гэвэл бас нөгөө хоорондоо холилдох ийм юмнууд болох вий дээ гэж би бас бодож байна.

Б.Найдалаа: Тэгээд яг тодорхой хэл дээ. Тэгээд яг яана гэнэ ээ. Энэ боломжтой юм уу, боломжгүй юм уу. Зохисгүй юм уу. Дэмжиж байгаа юм уу, дэмжихгүй байгаа юм уу.

Ж.Энхтөр: Дэмжихгүй л байна л даа. Яагаад гэвэл нөгөө үйлдвэрийн ослын тухай хууль нь нөгөө өөрийнхөө хуулиараа зохицуулагддаг зардлууд нь гардаг.

Б.Найдалаа: За ойлголоо. Энэ нөгөө Уянга гишүүний саналтай давхцахгүй юу. Дэмжигдсэн шүү дээ. Биш үү. Эрдэнэбат гишүүн тодруулчих.

С.Эрдэнэбат: Тэгж худлаа ярьж болохгүй ээ нөхөр минь. Үйлдвэрлэлийн осолд орчихсон хүмүүсийг нөхөн сэргээх, түүнээс нь урьдчилан сэргийлэх, мөн үйлдвэрлэлийн орчны бохирдол, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх ийм зардлуудыг гаргаж болох хуулиараа бол байгаа. Тийм учраас бол энийг бол та хэд яг ийм байдлаа хэлсээр байгаад 400 гаруй тэрбум төгрөг одоо зүгээр банканд хадгалаад, мөнгөө хүүлээд, тэгэнгүүт тэнд осол гарч л байдаг, хүмүүс нь өвдөж зовоод ингээд байж л байдаг. Гэртээ ажил хөдөлмөр хийж чадахгүй байдаг. Бүр дээрээс нь нэмэх нь ажил олгогчдыг хүртэл урамшуулах ийм зардал гаргах ёстой байдаг юм.

Тийм учраас энэ эрсдэлийг нь үнэлнэ. Эрсдэл үнэлэхэд нь ажил олгогч нарт тусална энэ тэр гэдэг ийм зардлын ангиллаар бол оруулчхаж болох юм байгаа юм. Тийм учраас би яах вэ, энэ дээр хийх ажлуудыг нь тавиад, хууль дээр байгаа заалтууд дээр нь нийцүүлээд зарцуулах эрх нь бол Хөдөлмөрийн яаманд тавьж өгч байгаа юм. Тэгэхээр манай Хөдөлмөрийн яам маань олон жил ерөөсөө зарцуулахгүй байсаар байгаад үндсэндээ энэ санг хадгаламж хэлбэрээр хадгалдаг л ийм байдалтай болчихсон.

Б.Найдалаа: Санал гаргасан гишүүн болон яамнаас тайлбар хэллээ. Тэгээд Эрдэнэбат гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 56,5 хувь дэмжиж, Эрдэнэбат гишүүний санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Гамнаа гишүүний санал байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2026 оны төсвийн жилд хөрөнгө оруулалтын 3 их наяд 267,3 тэрбум төгрөгийн зардлаас Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчин, боловсролын салбараас бусад салбарт 2026 онд шинээр баригдах барилга байгууламжийн хөрөнгө оруулалтыг тэвчих, бууруулах дүн нь 301.666,7 сая төгрөг, 2026 оны Эрүүл мэндийн даатгалын сангийн төрөөс Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого 431.181,3 сая төгрөгийг дүн зөв бол шалгаарай. 301.066,7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 732.848,3 сая төгрөг болгох.

Үндэслэл нь 2024 онд Эрүүл мэндийн даатгалын сангаас тусламж үйлчилгээ авсан иргэдийг даатгуулагчийн төрлөөр авч үзвэл 32,8 хувь нь тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн, 26,6 хувь нь 0-18 насны хүүхэд, 15,7 хувь нь төсөвт байгууллагын болон аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, бусад даатгуулагч 0,04-6,4 хувь нь 6,8 хувь байгаа ба нийт тусламж үйлчилгээний тохиолдлын 89,5 хувийг Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь төр хариуцдаг иргэд 9,7 хувийг шимтгэлээ өөрөө хариуцсан төлөгч иргэд эзэлж байна. Иймээс төсөвт өртгийг нь 301.666,7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганмаа. Ганмаа гишүүн тайлбар хэлнэ.

Д.Ганмаа: Би маш амархнаар тайлбарлачихъя. Ерөөсөө 2026 онд шинээр ямар ч барилга барихгүй. Ганцхан удаа тэсчихье. Тэр нь жишээлбэл төсвийн зардлаар барилга барих 401 тэрбум төгрөг тавигдчихсан байгаа байхгүй юу. Төсөв дээр шинэ барилга шүү. Хуучин барилгууд, эхэлчихсэн барилгууд, урсгал засвар эд нар бол ерөөсөө огт оролдохгүй тэр чигээрээ явна. Зөвхөн төсөвт 401 тэрбумыг улсын төсвөөс барьж эхлэхээр шинээр эхлэх гэж байгаа барилгуудыг түр тэсчих. Түр больчихъё. Тэгэхээрээ тэрэнд жишээлбэл сая түр тэсье гэдэг дээр тэгэхдээ сургуулиудыг огт оруулаагүй. Боловсрол буюу цэцэрлэг, сургууль руу ороогүй. Онцгой байдлын ерөнхий газрыг оруулаагүй, Хил хамгаалах ерөнхий газар, Зэвсэгт хүчин, боловсролын салбарыг огт оруулаагүй. Тэгээд тэвчихвэл бид нар 301 тэрбум төгрөгийг төрөөс эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шимтгэлийг нь төлдөг тодорхой хэмжээний иргэд байдаг юм. Энэнээс тэтгэврээс өөр орлогогүй иргэд, 0-18 насны хүүхдүүд, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэд, малчин, оюутан, суралцагч гэх мэтчилэн 8 бүлэг ч билүү байдаг. Яг эдгээрийг одоогоор төрөөс гаргаж байгаа мөнгө нь 430 орчим тэрбум төгрөгийг 301 тэрбумаар нэмэгдээд, нийт 700 тэрбум болгоод өгөөч ээ. Тэгснээрээ эдгээр хүүхдүүдэд, эдгээр малчдад, энэ тэтгэврээс өөр орлогогүй хүмүүст маань эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх энэ боломж нь бүрдэж эхлэх юм.

Тэгснээрээ эмнэлгийнхэн эдгээр хүмүүсийг тусламж үйлчилгээ үзүүлэхгүй буцаахгүй байх, эрсдэлд оруулахгүй байх, нас баралт, хүндрэлүүдийг бууруулах энэ боломжууд нь гарч ирэх юм. Баярлалаа.

Б.Найдалаа: Баярлалаа. Үүнтэй холбоотой тайлбар хэлэх яам байхгүй юу. Байхгүй юм байна. Ганмаа гишүүний гаргасан саналыг дэмжье гэсэн томьёоллоор

санал хураалт. Гишүүдийн 56,5 хувь нь дэмжиж, Ганмаа гишүүний санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Эрдэнэбат гишүүнээр гарсан санал шүү. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Зам, тээврийн сайдын УТ2502808085 Аргалант Баянцогт сум чиглэл сум чиглэлийн хатуу хучилттай авто зам 26,7км, төмөрбетон гүүр 36км /төвийн бүс/ төслөөс 15 тэрбум 100 За энэ дүнгүүд ер нь жоохон юутай л байна даа энэ 15.166,3 сая төгрөгийг бууруулаад, боловсролын салбарын ... байз энэ байна шүү дээ. Жоохон ойлгомжгүй байна даа. Энэ томъёолол маш буруу ойлгомжгүй байна. Ингээ боловсролын салбар эрүүл мэндийн салбарт нэмэгдүүлэх гэсэн байна.

Тэгээд энийг Эрдэнэбат гишүүн өөрөө яг тодорхой дүнтэй танилцуулахгүй бол энэ санал бол боловсруулалт дутуу байна. Эрдэнэбат гишүүний микрофоныг нээе.

С.Эрдэнэбат: Энэ дээр бол нийт урсгал зардлыг 10 хувиас гэдэг нь хөрөнгө оруулалт дээр бас тодорхой хувиар хасаач ээ гэдэг би ийм зарчмын санал гаргасан юм төсөв дээр. Тэгэхээр энийг бол заавал өөрөө олж ир гэсэн учраас би бол хэн нэгэн тэр энэ гээгүй. Зарчмын хувьд нь бол хөрөнгө оруулалтын шинээр эхэлж байгаа болон зам гүүр, тэгээд боловсрол, эрүүл мэнд, онцгой, шүүх, цагдаа гэх мэтчилэн маш чухал ажил нь явж байгаа энэ тэр гэдэг юмыг нь хасаад, голцуу дараах зам барилга, мөн бусад нийтдээ 18 ийм зардал байж байгаа. Энийг хасаад хассан дүнгээр нь боловсролд 60 хувийг нь, эрүүл мэндэд 20 хувийг нь, ахмадын тэтгэвэр нэмэхэд 20 хувийг нь гэдэг байдлаар бол эх үүсвэр гаргаж өгч байгаа юм.

Өөрөөр хэлбэл хөлийн дүнгээр нь нийт хэмнэгдсэн зардлын 60 хувийг нь ахмадуудынхаа тэтгэврийг нэмэхэд зарцуулъя. Үгүй ээ, 20 хувийг нь. Боловсролдоо бол 60 хувийг нь шийдье. Эрүүл мэнд нь 20 хувийг нь гэж байгаа юм.

Тийм учраас та бүгд дэмжиж өгөхийг хүсье.

Б.Найдалаа: Үүнтэй холбоотой нэмэлт тайлбар хэлэх хүн байна уу. Яг үнэндээ ийм байна л даа. Боловсролын салбар, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулалт, төсвийг нэмье гэж байгаа нь сайшаалтай боловч яг 60 хувь, 20 хувь гэдгийг нь яг үнэнийг хэлэхэд тодорхойгүй, шийдвэр гаргахад маш бүрхэг байна Эрдэнэбат гишүүн ээ. Тэгээд Өргөдлийн байнгын хороон дээр бас хураасан гэж ойлгоод байна. Яг зүйл заалт нь байхгүй. Энэ дээр хамгийн харамсалтай нь энэ дээр яамдаас тайлбар хэлэх тодорхой юм байхгүй юм байх даа. Сангийн яамнаас юу ч байхгүй юу. Болж байгаа юм уу. Ямар ч байсан тэгвэл гишүүний бүрэн эрхийнх нь хүрээнд яг тэр боловсролын салбар, эрүүл мэндийн салбарт 60 хувь, 20 хувиар нэмье гэсэн томъёоллоор нь яг энэ томъёоллоор нь тэр авто замаас авч байгаа шүү дээ. Тэрүүгээр нь дэмжье гэсэн саналаар санал хураая. Гишүүдийн 52,2 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Тэгэхдээ Эрдэнэбат гишүүн энэ нөгөө нэг Өргөдлийн байнгын хороод хураалгачихсан шүү дээ. Хураагаад дэмжээгүй юм байна шүү дээ. Гэхдээ энэ чинь нөгөө хамгийн гол нь тийм юу байхгүй ч гэсэндээ дахиж энд ингэж хураах хэрэг байна уу. Дээр нь байна шүү дээ.

Дараагийн саналууд адилхан тийм ээ. Тэрэнтэйгээ нийлүүлээд хэлчих саналаа.

С.Эрдэнэбат: Тэгэхээр Өргөдлийн байнгын хороон дээр ингэчихсэн юм хураавал нөгөө багцаар нь бүгдийг нь хураа гэдгээр хураачихсан чинь маш олон гишүүдийн өөр өөрийнх нь тойрог дээр нь байсан учраас унагаачихсан байхгүй юу. Уг нь би 1, 1-ээр нь хураагаад өгөөч ээ гэсэн чинь багцаар нь хураана. Тэгээд энийгээ хөлийн дүнгээр нь яаж яаж хуваарилах гэж байгаа гэдэг юмыг нь тодорхой болго гэдэг байдлаар оруулж ирээд тэгээд уначихсан байхгүй юу. Тийм учраас би энэ Өргөдлийн байнгын хороон дээр хураасан тэр Коп, бусад тэр нөгөө ажил нь явж байгаа тэр саналуудаа бол татаад авчихсан. Тэр Шүүхийн шийдвэр, Батлан хамгаалах, цэргийн ангитай холбоотой.

Б.Найдалаа: Яг ингэх гээд байна. Бид нар яг юунд юм, ямар зардал юм, яг төсөв дээр байгаа тодорхой зүйл заалт байх ёстой шүү дээ. Тэр нь байхгүй болчихоод байна шүү дээ. Бид нар санал хураалт дээрээ буруудаж болзошгүй болоод явчихна.

С.Эрдэнэбат: Энэ дээр нийт энэ төсвийн мөнгөн дүнгүүд хамгийн доор нь саналууд нь бүгд байж байгаа. Энэ саналуудыг бүгдийг нь зарим нь унаж магадгүй. Зарим нь бол дэмжигдэнэ. Тэгэхээр нийт хэмнэгдсэн зардлуудынх нь хэмнэгдэж үлдсэн хөлийн дүн нийлбэрээ гарангуут түүнийх нь 60 хувийг боловсролд....

Б.Найдалаа: Эрдэнэбат гишүүн ээ, энэ ингэж байна. Сая санал хураасныг бид нар бас залруулахгүй бол болохгүй байна. 15.166,3 сая төгрөгийг төгрөгийг буурах нь тодорхой дүнтэй тодорхой байгаа байхгүй юу. Тийм төсвийн зүйл. Нэмэгдүүлэх нь гэхээр боловсролын салбар 60 хувь гэж байгаа чинь яг энэ зарчмын хувьд саналын шаардлагыг бас хангахгүй л гэж би үзээд байгаа юм.

С.Эрдэнэбат: 15.166,3 ...

Б.Найдалаа: Үгүй ээ, яг боловсролын салбар дотроо олон зүйл байгаа шүү дээ. Цалин байгаа, зардал байгаа, төсөв байгаа. Яг алинд нь оруулах юм.

С.Эрдэнэбат: Ерөөсөө л цалин.

Б.Найдалаа: Тэгвэл та тэрийг тодорхой бичих ёстой. Тэгэхгүй бол энэ чинь бид нар ерөнхийдөө тийшээ гэж болохгүй байгаа.

С.Эрдэнэбат: Хамгийн доор нь бүх багцаар нь санал нь байгаа. Арынх нь 2 урдах хуудсыг нь хараарай.

Б.Найдалаа: Тэгвэл та ингэ саяын санал энийгээ яг юуг нь ингээд яг өөрөө томьёолоод, яг тэр зардал гээд микрофонд хэлэх хэрэгтэй.

С.Эрдэнэбат: Тэгэхээр нийтдээ 18 хөрөнгө оруулалтын зардлууд бол байгаа. 15 тэрбум 166 сая төгрөг 300 мянган төгрөгийг хасаад, үүний боловсролын салбарын ажилчдын цалинг нэмэхэд 60 хувьд нь, үүнийх нь 20 хувийг эрүүл мэндийн салбарын ажилчид 20 хувийг нь, нийт ахмадуудын тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд 20 хувийг нэмье гэж байгаа юм. Ойлгомжтой биз дээ. 18 ширхэг санал шүү дээ.

Б.Найдалаа: Уучлаарай тэгвэл энэ саяынх чинь би олон санал гэж бодоод байсан чинь буруу байна шүү дээ. 18 багц санал. Олон зүйлтэй 1 санал юм байна шүү дээ. Яагаад гэвэл сая энэ чинь эхнийх нь санал ганцхан санал гэж зөвхөн 15

тэрбумыг уншчихсан байхгүй юу. Энэ чинь нийт дүнгээр 15 тэрбум биш. Өөр дүнтэй. Нийлбэр дүнгээрээ нэлээн том дүн байгаад байна шүү дээ. Тийм байна. Тэгээд бид нар ингээд саяын уншсан санал чинь өөрөө бүрэн санал нь биш зөвхөн эхнийх нь нэг өгүүлбэрийг нь уншаад санал хураачихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бид нар залруулахгүй бол болохгүй юм байна. Саяынхыг гишүүд ойлгосон байх. Энийг бид нар хүчингүй болгоод, дахиж багцалж томъёолохгүй бол буруу болох гэж байна.

Сая гишүүний гаргасан саналыг бүрэн томъёолоод бүрэн хураахын тулд саяын хамгийн сүүлд хураасан саналыг хүчингүй болгох хэрэгтэй байна. Тэгэхээр хамгийн сүүлд тэр дэмжигдсэн саналыг санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураая. Гишүүдийн 52,2 хувь дэмжигдэж, сүүлд хураасан санал хүчингүйд тооцлоо.

Эрдэнэбат гишүүний гаргасан багц саналыг бүгдийг нь уншаад 1 санал хураалт явна. Би саналыг уншъя.

1.Зам, тээврийн сайдын УТ2502808085 “Аргалант-Баянцогт сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 26.7 км, төмөрбетон гүүр, 36км /Төвийн бүс/, эндээс 15,166.3 сая төгрөг”;

2.Зам, тээврийн сайдын УТ2502808211 “Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км /Төвийн бүс/, 15,000.0 сая төгрөг”;

3.Зам, тээврийн сайдын УТ2502808162 “Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дуусгал, 66 км /Баруун бүс/, эндээс 23,000.0 сая төгрөг”;

4.Зам, тээврийн сайдын УТ2402804339 “Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай авто зам, 54.18 км /Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт сум/, эндээс 42,904.6 сая төгрөг”;

5.Зам, тээврийн сайдын УТ2402804371 “Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/, эндээс 30,499.8 сая төгрөг”;

6.Зам, тээврийн сайдын УТ2402804360 “Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто зам, эндээс 38,576.2 сая төгрөг”;

7.Зам, тээврийн сайдын УТ2402804406 “Ховд-Дөргөн сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 40.7 км /Ховд, Дөргөн сум/, эндээс 25,159.7 сая төгрөг”;

8.Зам, тээврийн сайдын УТ2402804412 “Хэрлэн голын төмөрбетон гүүр 265 км, хатуу хучилттай авто зам 14.2 км /Хэнтий, Хэрлэн сум/, эндээс 21,065.4 сая төгрөг”;

9.Зам, тээврийн сайдын УТ2102800632 “Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох хатуу хучилттай авто зам, 122.4 км /Төв, Угтаалцайдам, Цээл, Заамар сум/, 80,101.1 сая төгрөг”;

10.Зам, тээврийн сайдын УТ2602800805 “Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 37 км /Өмнөговь, Баяндалай, Гурвантэс сум/, эндээс 20,036.4 сая төгрөг”;

11.Зам, тээврийн сайдын УТ2602800636 “Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замаас /Хөшигийн хөндий/ Архивчдын гудамж хүртэлх авто замын өргөтгөл, шинэчлэл /Төвийн бүс/, эндээс 25,635.0 сая төгрөг”;

12.Зам, тээврийн сайдын УТ2602800907 “Хэрлэн голын төмөрбетон гүүр, 217.6 км /Дорнод, Хэрлэн сум/ эндээс 6,053.6 сая төгрөг”;

13.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын УТ2603400215 төслийн кодтой “Аялал жуулчлал, спортын цогцолборын барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ 3,778.9 сая төгрөг”;

14.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын УТ2403100364 төслийн кодтой “Өвлийн спортын ордны барилга /Дархан-Уул, Дархан сум/, эндээс 6,423.7 сая төгрөг”;

15.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын УТ2102900758 “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил, эндээс 6,130.0 сая төгрөг”;

16.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын УТ2601900178 “Үр тариа хадгалах агуулах /Увс/, эндээс 4,050.0 сая төгрөг”;

17.Эрүүл мэндийн сайдын УТ2602001067 “Хавдар судлалын Үндэсний төв-II” цогцолборын А, С блокийн барилга, гадна шугам сүлжээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/, 2026 онд санхүүжих мөнгөн дүнгийн 50 хувийг бууруулах, энэ нь 20,261.0 сая төгрөг”;

18.Эрүүл мэндийн сайдын УТ2602001014 “Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцын 17 дугаар бага хурал зохион байгуулахтай холбоотой Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Үндэсний оношилгоо, эмчилгээний төв барилгын их засвар /Улаанбаатар/, эндээс 2026 онд санхүүжих мөнгөн дүнгийн 50 хувийг бууруулах, энэ нь 2,191.5 сая төгрөг” эндээс эдгээр дүнг хасаад, ахмад настнуудын тэтгэвэр тэтгэмж, боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлсийг нэмэх зорилгоор дээр дурдсан хөрөнгө оруулалтын зардлаас хэмнэсэн 411.069,3 сая төгрөгийг нэмэлтээр тусгах. Ингэхдээ боловсролын салбарт 60 хувь буюу 246.641,8 сая төгрөг, Эрүүл мэндийн салбарт 20 хувь буюу 82.213,8 сая төгрөг, ахмад настнуудын тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэлд 82,213,8 сая төгрөгийг тус тус нэмж тусгах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Түрүүн тайлбараа хэлсэн учраас энэ бол тэгэхдээ нэлээн зарчмын том шийдвэр байна шүү дээ. Том дүнтэй ч юм байна. Яамдаас санал хэлэх хүн байхгүй юу. Сангийн яам ингээд болж байгаа юм байх даа. Та хэн билээ. Микрофон 6.

Ж.Отгонбат: Гишүүний уншсан санал дотор Гандангийн дэнжийн зураг төсөв хийлгэнэ гэдэг нь манай сайдын багцад байхгүй тийм төсөл арга хэмжээ өргөн барьсан хуулийн төсөлд. Тэгэхээр энэ андуурагдаад уншигдчих шиг боллоо.

Тэгээд цаашид зарим энэ шилжиж байгаа арга хэмжээ буюу өөрөөр хэлбэл ирэх он дуусах Дарханы өвлийн спортын ордон гээд шилжиж байгаа барилгуудаас хасах санал бас орж ирсэн байх юм. Энэ уг нь үргэлжилж байгаа барилга шүү дээ. 2, 3 жилийн өмнө эхэлчихсэн барилга. Тэгээд шилжиж байгаа барилгуудаас бас хасъя энэ тэр гээд орж ирсэн санал байна. Ийм учраас саналыг дэмжих боломжгүй байна.

Б.Найдалаа: Та хэн гэсэн бэ. Дахиад албан тушаалаа хэл дээ.

Ж.Отгонбат: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Отгонбат.

Б.Найдалаа: Та яамаа төлөөлж хэлж байгаа нь зөв үү.

Ж.Отгонбат: Тийм ээ, Манай сайдын багцад байхгүй өөр арга хэмжээ уншигдаад байна.

Б.Найдалаа: Ойлголоо өөр бусад яамдаас санал байхгүй юм байна. Сая анзаарсангүй. Сая уншсанд байсан уу. Ямар ч байсан гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд гаргаж байгаа санал байгаа. Тэгээд энэ маш олон тэр зам, тээвэр, дэд бүтцийн төслөөс авсан байна. Тэгээд ахмад настан, эмч, багш нарын цалинг нэмье гэж байгаа юм байна. Тэгэхдээ энэ дээр өөр Сангийн яам эд нараас тайлбар байхгүй байгаа юм. Санал хураалт явуулъя. Багцлаад бүгдийг нь саяын 411 тэрбумын асуудал шүү. Энэ Эрдэнэбат гишүүний гаргасан энэ багц саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. Гишүүдийн 43,5 хувь нь дэмжиж, Эрдэнэбат гишүүний санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэврийн хэмжээг 10,3 хувиар нэмэгдүүлэхээр төсөвт тооцож ирүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж.

Гэхдээ энэ зарчмын зөрүүтэй саналын шаардлагыг хууль, дэгийн дагуу хангахгүй байгаа учраас санал хураах боломжгүй байна.

Түрүүн Бейсен гишүүн аргагүй ажилтай байж байгаад санал дээрээ нэмэлт тайлбар хэлж чадаагүй. Зүгээр үг авъя гэж байна. Бейсен гишүүнд үг өгье.

Б.Бейсен: Эрхэм гишүүд ээ, би сая Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны давхцаад яг санал хураалт явагдсан. Энэ Цэнгэл сумын бага сургуулийн спорт заал 2 дахь жилээ хасагдаж байна. 2 дахь жилээ гадаа хичээллэж байна. Тэгээд Барилгын хөгжлийн төвийн дүгнэлт гарсан. Зураг төсөв, аудит хийгдсэн байсан. Энийг та бүгд энэ хурлын протоколд тусгаад шийдэж өгөөч ээ. Энэ Боловсрол яамны хариуцлагагүй байдлаас болсон. Сангийн яаманд ч би очоод хэлсэн. Мөнхжаргал энэ тэр бүгд мэдэж байгаа. Сангийн яамныхан мэдэж байгаа. Энийг тусгаж өгөөч гэж би санал хэлэх гэсэн юм. Сая хүндэтгэх шалтгаанаар хуралтай, яг үүний адил санал хураалт явагдаж байгаад би оройтчихлоо.

Б.Найдалаа: Баярлалаа Бейсен гишүүн. Тэгээд одоо нөгөө төсвийн ажлын хэсэг рүү явчих юм чинь тэнд очоод угаасаа саналууд хэлэлцэгдээд явна. Та тэнд очоод тайлбараа хэлээд, хамгаалаад яваарай.

Зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулж дууслаа.

Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулсан талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргах санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 онд төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа.

18.28 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ